

Лиахоно

**Биднийг
чөлөөлөхөөр
төржээ, 16 ба 44-р
хуудсууд**

**Бусад сүмүүдтэй хамтран
үйлчилснээс ирдэг
адислалууд, 26-р хуудас**

**Нэгэн залуу эмэгтэй
донтолтыг даван туулахын
төлөө тэмцсэн нь,
56-р хуудас**

**Хүүхдүүдийн хийх үйл
ажиллагаа: Есүсийн
тухай өөрийн номыг
хийгээрэй, 68-р
хуудас**





“Би Иосеф Смитийг
харах үед, зүйрлэн
хэлбэл, тэр
тэнгэрийг газарт
буулган ирж; мөн
тэрээр тэнгэрийг
авчран, Бурханы
зүйлүүдийг энгийн
тодорхой байдалд
нээсэн; мөн энэ нь
түүний номлолын
гайхамшиг юм.”

Ерөнхийлөгч Бригам Янг
(1801–77), *Discourses of
Brigham Young*, эмхэтгэсэн
Жон А. Видцүе (1954),
458-459-р хуудсууд.



ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Гэр бүл ба найзууд үүрд мөнх**
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
- 7 Айлчлагч багшийн захиас бичиг: Бурханы Төрсөн Ганц Хүү, Есүс Христийн тэнгэрлэг зорилго**

ХАВТСАН ДЭЭР

Хавтасны нүүрэн хэсэгт: *Дэлхийн гэрэл*, Жэй Брайнт Вард Ар талд; *Хоньчид Исүсийн төрөлтийн талаар ярьсан нь*, Артур А.Диксон. Хавтасны дотор талд: Скотт Жарвигийн авсан Иллинойн Наувугийн ариун сүмийн гэрэл зураг

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 16 Ирцгээ, Түүнийг шүтэн биширцгээе**
Ахлагч Брус Д.Портэр
Эртний нэгэн бошиглолын биелэлт нь боолчлогдогсдод эрх чөлөө, хүмүүний гэр бүлд найдвар авчирсан юм.
- 22 Индексжүүлэх нь маш чухал**
Жэннифэр Грэйс Жонс
Маш энгийн ямар нэг зүйл дэлхий даяарх гэр бүлүүдэд өөрчлөлтийг үнэхээр бий болгож чадах уу?
- 26 Бусад сүмүүдтэй хамтран ажиллахад оролцох замаар илүү сайн гэгээнтэн болох нь**
Бэтси Вандэнбэрг
Бусад шашны хүмүүстэй хамт үйлчлэх нь бидний шавийн харилцааг хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?
- 32 Зүнгүгээс найздаа**
Дэвид Диксон
Годфри модны тайрсан мөчрүүд сэтгэл санааг нь өөрчлөхөд хүргэх хүртэл сүмд явахыг огт хүсэхгүй байв.

34 Африк—өөдрөг найдварын тив

Ричард М.Ромни
Африк бол бид сэргээлтийн гайхамшиг нээгдэхийг харж болох газар юм.

ХЭСГҮҮД

- 8 Бид юунд итгэдэг вэ?: Их Эзэн алдар суундаа дэлхийд эргэж ирнэ**
- 10 Бидний гэр орон мөн гэр бүлүүд: Хүүхдүүдэд Ариун Сүнсийг танин мэдэхэд туслах нь**
Мэррили Браун Бояак
- 13 Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Наманчлал**
- 14 Сүмийн мэдээ**
- 40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 80 Биднийг дахин уулзтал: Гэртээ харих зам**
Хээдэр Витл Ригли



- 44 Христийн мэндэлсний баярын амлалт**
 Ахлагч Робэрт Д.Хэйлс
Христийн мэндэлсний энэхүү баярын үеэр та ямар амлалтууд өгөх вэ?



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сануулга: Үүнийг олоход танд үсчин тусална.



- 48 Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь**
 Ахлагч Жэффри Р.Холланд
Бидний эрин үе эцсийнх бөгөөд хамгийн агуу учраас Бурханы Хургыг хүлээн авахад сүмийг бэлтгэх үүрэг бидэнд бий.
- 52 Асуулт, хариултууд**
 Би уруу таталтыг хэрхэн эсэргүүцэх вэ?
- 54 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Замын төгсгөлөөс харагдах байдал**
 Ахлагч Брэдли Д.Фостэр
Та наманчилж чадна. Та наманчилбал бүх зүйл сайжирна.
- 56 Дахиад донтохгүй: Порнографыг даван туулсан миний замнал**
 Нэрийг нууцлав
Би залуу эмэгтэйн хувьд порнографтай тэмцэлдэнэ гэж хэзээ ч бодож байгаагүй.
- 58 Зүгээр нэг туслагч биш**
Та гэрийн багшилалт хийхдээ өөрийгөө хамтрагчийнхаа зүгээр л нэг туслагч гэж боддог уу? Дахиад нэг бодоод үз дээ.
- 60 Ариун газруудад зогсох нь**
Дэлхийн өнцөг булан бүрээс цуглуулсан зургууд өсвөр үеийнхэн ариун газруудад хэрхэн зогсож байгааг харуулж байна.
- 64 Христийн мэндэлсний баярын дуртай дуу**
 С. Г.Линдстром
Нэг эгч дуулахаар гарч ирэх үед би дуу нь сайхан байх болов уу гэж бодсон нь буруу байлаа.



- 66 Миний ах номлогч**
 Кэвин В.
Би одоо өөрийн гэсэн унтлагын өрөөтэй боллоо. Би ахыгаа ер нь санахгүй байх болов уу?
- 67 Онцгой гэрч: Гэр бүлтэйгээ хамт цагийг өнгөрөөх нь бидэнд яагаад маш чухал вэ?**
 Ерөнхийлөгч Боид К. Пакэр
- 68 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Би Есүс Христ дахин ирнэ гэдгийг мэднэ**
- 71 Бидний хуудас**
- 72 Есүсийг хүлээсэн нь**
 Маттью Д.Флиттон
Бяцхан Есүс хаана байсан бэ? Бид түүнгүйгээр Христийн мэндэлсний баярыг тэмдэглэж чадсангүй.
- 74 Аян замд: Тэр газар энэ байна!**
 Энни Бийр
- 76 Бага насны хүүхдүүдэд зориулав**
- 81 Бошиглогчийн хөрөг: Иосеф Фийлдинг Смит**

2013 ОНЫ АРВАНХОЁРДУГААР САРЫН ДУГААР 14 NO. 6
ЛИАХОНА 10792 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон

Зөвлөхүүд: Мэрвин М.Арнольд, Шэйн М.Боуэн,
Стэйтли Г.Эллис. Бага Кристоффэл Гюлдэн

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гаррфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр,

ЛаРин Портер Гаунт

Редакцийн баг: Сюзан Баррэт, Бриттани Бийти, Дэвид
Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая
Фрийдман, Лори Фүллэр, Гаррэт Х.Гаррфф, Жэннифер
Грэйс Жөүнс, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджерк,
Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни,
Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрссон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрыос, Фэй
П.Андрус, С.Кимбалл Ботт, Том Чайлд, Нэйт Гайнс, Колийн
Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан Лодгрэн, Скотт М.Моой,
Марк В.Робисон, Брад Тиэри, П.Никол Вокзорст

Оюуны өмчийн зохицуулагч: Жэин Анн Петрс

Хэвлэлийн захирал: Жейн Анн Петерс

Хэвлэх баг: Кевин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли
Бурдетт, Браян У.Ги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаяагаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаяагаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаши, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалоог, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаяагаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаяагаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

December 2013 Vol. 14 No. 6. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to
Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг
оруулсан. Дор хоёр жишээ өгөгдсөн болно.



ДЕВИД СТОКЭРИЙН АВСАН ГЭРЭЛ ЗУРАГ, АЛБАН ХААГЧИЙН ӨР

“Хүүхдүүдэд Ариун Сүнсийг танин мэдэхэд туслах нь,” 10-р хуудас: Энэхүү өгүүллийг уншсаны дараа Ариун Сүнс бидэнд хэрхэн ярьдгийг хүүхдүүддээ заахын тулд сонсох, харах болон биеэр гүйцэтгэх үйл ажиллагаануудыг төлөвлө. Та Христийн мэндэлсний баярын түүхийг уншаад жүжигчилсэн тоглолт хийж болно. Мөн та Аврагчийн төрөлтийн тухай сүмийн дуулал болон Хүүхдийн хэсгийн дууг сураад найз болон хөршүүддээ дуулж өгч болно. Та нар хамтдаа Аврагчийн зургийг харж эсвэл гэрийнхээ хамгийн сайн харагдахуйц газарт Христийн төрөлтийн чимэглэлийг тавьж болно. Та гэр бүлийн үйлчлэлийн үйл ажиллагаа төлөвлөж болно. Юу ч хийлээ гэсэн хүүхдүүддээ Ариун Сүнсийг мэдэрч, танихад нь тусал.

“Бусад сүмийн хүмүүстэй хамтран ажилласнаар илүү сайн гэгээнтэн болох нь,” 26-р хуудас: Христийн мэндэлсний энэ удаагийн баярын үеэр бусад сүмийн хүмүүстэй хамтран ажиллах нэг арга замыг олох талаар бодож үзээрэй. Та Христийн өөр сүмийн гэр бүлтэй хамт Христийн мэндэлсний баярын түүх уншиж эсвэл үйлчлэл хийж болно. Та эсвэл Христийн бус шашинтай нэг гэр бүлийг гэр бүлийн үдэштээ урьж, ээлжлэн бие биенийхээ итгэл, ёс заншлаас суралцаж болно. Хүүхдүүд тань таны найз нараас сурсан зүйлээ дараа нь ярилцдаг байхад анхаараарай.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон сүмийн бусад материалуудыг олон хэлээр үзэж болно.
languages.lds.org.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Африк, 32, 34
Ёс суртахуун, 56
Анхдагчид, 34, 74
Ариун Сүнс, 10
Ариун сүмийн ажил, 22
Багшлалт, сургаал, 10
Бишопууд, 54
Бошиглогчид, 34, 48
Бошиглол, 44
Гэмшил, гэм буруугаа хүлээх, 54
Гэр бүл, 10, 66, 50
Гэр бүлийн түүх, 22

Гэрийн багшлалт, 58
Гэрээнүүд, 44
Есүс Христ, 7, 8, 16, 48, 68
Наманчлал, 13, 16, 54, 56
Номлолын ажил, 4, 32, 34
Порнограф, 56
Смит, Иосеф Фийлдинг, 81
Сонгох эрх, 52
Уруу таталт, 52, 56
Уучлал, 54
Хоёр дахь ирэлт, 8, 48, 68, 72

Христийн мэндэлсний баяр, 4, 16, 40, 41, 43, 44, 64, 72, 76
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 56
Хүүхдийн хэсэг, 71
Хүүхдүүд, 10
Хөгжлийн бэрхшээл, 64
Шүүмжлэл, 80
Эрин үеүд, 48
Эрх чөлөө, 16
Үйлчлэл, 26, 32, 58
Өрөвч сэтгэл, 80



Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч
Хэнри Б.Айринг

ГЭР БҮЛ БА НАЙЗУУД ҮҮРД МӨННХ

Та хаана ч амьдардаг бай, танд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээгээр амьдрах үед ирдэг агуу аз жаргалыг эрж буй найзууд байдаг. Энэхүү аз жаргалыг үгээр дүрслэх боломжгүй ч хэрэв тэд үүнийг таны амьдралаас харвал таньж чадна. Тэд энэхүү аз жаргал юунаас эхтэйг мэдэх их хүсэлтэй байх болно, ялангуяа тэд таныг өөрсөдтэй нь адил бэрхшээлүүдийг даван туулдгийг харах болно.

Та Бурханы зарлигуудыг дагаснаараа аз жаргалыг мэдэрдэг байсан. Энэ бол сайн мэдээгээр амьдарсны төлөө танд амлагдсан адислал юм (Мозая 2:41-р шүлгийг үзнэ үү). Та бусад хүмүүст харагдах гэж Их Эзэний зарлигуудыг итгэлтэйгээр дагадаггүй харин таны аз жаргалыг харсан хүмүүс сайн мэдээний сэргээлтийн баярт мэдээг сонсохын тулд Их Эзэнээр бэлтгэгддэг билээ.

Танд өгөгдсөн адислалууд өөрт тань гайхалтай боломж мөн үүрэг хариуцлагуудыг бий болгодог. Та Есүс Христтэй гэрээ байгуулсан шавь нь учраас бусдад, ялангуяа найзууд болон гэр бүлийнхээ гишүүдэд улам аз жаргалтай амьдрах боломжийг олгох үүрэгтэй.

Их Эзэн таны боломжийг харж, “сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө сэрэмжлүүлэх” гэсэн зарлигаар Сургаал ба Гэрээ 88:81-р шүлэгт үүргийг тань тайлбарласан билээ.

Хэрэв та Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, үүгээр амьдарвал Их Эзэн зүрх сэтгэлд тань гарах

өөрчлөлтөөр дамжуулан дээрх зарлигийг дуулгавартай дагахыг хөнгөвчилж өгнө. Үр дүнд нь бусдыг хайрлах хайр тань өсөн нэмэгдэж, өрөөл бусдыг өөрсдийнхөө адил аз жаргалтай байлгахыг хүсдэг болно.

Энэхүү өөрчлөлтийн нэг шийшээ нь Их Эзэний номлолын ажилд туслах боломжийг та хэрхэн баяртай хүлээж авах явдал юм. Бүрэн цагийн номлогчид жинхэнэ ёсоор хөрвөсөн нэгнээс найрсаг хариу авахыг хүсэн хүлээж болно гэдгийг удалгүй ойлгодог. Харин хөрвөгч нь найз нар болон гэр бүлийнхээ гишүүдэд өөрийн мэдэрсэн аз жаргалыг хуваалцахыг хүсдэг.

Танай тойргийн номлолын удирдагч эсвэл номлогчид заах боломжтой хүний нэрийг танаас асуувал энэ нь таны хувьд агуу нэр төрийн хэрэг юм. Найз нар тань таны аз жаргалыг харсан учраас тэд сайн мэдээг сонсож, хүлээн авахаар бэлтгэгдсэнийг номлогчид мэддэг. Мөн тэд найз нар нь хаант улсад ирэхэд та тэдэнд хэрэгтэй гэдэгт итгэлтэй байдаг билээ.

Та найз нараа номлогчидтой уулзахад урьсан бол тэднийг алдана гэхээс айх хэрэггүй. Номлогчидтой уулзахаас татгалзсан найзууд надад бий л дээ. Гэвч би тэдэнд өөрийнхөө хувьд эрхэм үнэ цэнэтэй зүйлийг санал болгосны төлөө тэд олон жилийн турш надад талархалтай байдаг билээ. Учир нь миний санал болгосон зүйл надад маш чухал болохыг тэд мэддэг байсан юм.



Та хүмүүст сайн мэдээг санал болгосноор тэдэнтэй үүрдийн найзууд болж чадна. Учир нь сайн мэдээ танд аз жаргал авчирсныг тэд мэддэг. Найзыгаа, ялангуяа гэр бүлийн аль нэг гишүүнээ аз жаргалын төлөвлөгөөг дагахаар сонгоход урих боломжийг хэзээ ч бүү алдаарай.

Ариун сүмд урих тэрхүү урилгаас илүү агуу боломж гэж үгүй. Тэнд Их Эзэн авралын ёслолуудыг амьдралдаа авч чадаагүй бидний өвөг дээдэст тэдгээрийг санал болгож чадна. Тэд дээрээс хайр болон итгэлээр таныг харан, хүлээж байдаг билээ. Тэд Их Эзэний хаант улсад орох боломжтой хэмээн Тэрбээр амласан (Сургаал ба Гэрээ 137:7-8-р шүлгүүдийг үзнэ үү) бөгөөд тэднийг хайрлах хайрыг та нарын зүрх сэтгэлд суулгасан юм.

Та нараас олон нь номлогчдод уулзаж ярилцах боломжтой хүмүүсийн нэрийг өгөхдөө мэдэрдэг шиг тийм баяр баяслыг ариун сүмийн ёслолуудыг бусдад санал болгохдоо

мэдэрч байсан байх. Та нар өвөг дээдсийнхээ төлөө ёслолууд гүйцэтгэхдээ бүр ч илүү баяр баясгаланг мэдэрч байсан шүү дээ. Бид гагцхүү ариун сүмийн төлөөлөн гүйцэтгэх ёслолуудаар дамжуулан өвөг дээдсээ адислах арга замыг санал болгосноор л бидний мөнхийн аз жаргал боломжтойг бошиглогч Иосеф Смитэд илчилсэн билээ (Сургаал ба Гэрээ 128:18-р шүлгийг үзнэ үү).

Христийн мэндэлсний баярын үе бидний зүрх сэтгэлийг Аврагч руу болон Түүний бидэнд өгсөн сайн мэдээний баяр баясал руу эргүүлдэг. Бид тэрхүү аз жаргалыг бусдад санал болгосноор Түүнд талархлаа хамгийн сайнаараа илэрхийлдэг билээ. Бид номлогчдод нэрс санал болгож, ариун сүмд өвөг дээдсийнхээ нэрсийг авч очсоноор талархал нь баяр баясал болж хувирдаг. Бидний талархлын энэхүү нотолгоо нь найз болон гэр бүлүүдийг үүрд мөнх болгодог билээ. ■

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Бид бусадтай сайн мэдээг хуваалцсанаар Аврагчид талархлаа харуулдаг гэж ерөнхийлөгч Айринг тайлбарлажээ. Та заадаг хүмүүстэйгээ сайн мэдээний бэлэг тэдний амьдралыг хэрхэн адисалсан талаар ярилцаж болно. Сайн мэдээний бэлгийн талаар хуваалцахыг хүсч байгаа хүмүүсийн нэрс болон үүнийг тэдэнтэй хэрхэн хуваалцаж болохыг залбирч тогтооход тэднийг уриарай.

Гэрчлэлээ хуваалцаарай

Та найз эсвэл хөршдөө дотор нь гэрчлэлээ бичсэн Мормоны номыг өгч, Христийн мэндэлсний энэ баярын сайн мэдээний бэлгийг тэдэнтэй хуваалцаж болно. Үүнд бэлтгэхийн тулд дараах алхмуудыг хийнэ үү:

1. Хуудас цаасан дээр 11,5 x 16,5 см тэгш өнцөгт зураад үүнийгээ хайчилж авахад насанд хүрсэн хүнээр туслуул.
2. Хуудасны дээд талд өөрийнхөө зурсан зураг эсвэл фото зургийг оруул.
3. Зурагнахаа доор гэрчлэлээ бич.
4. Цаасаа Мормоны номын хуудасны дотор талд байрлуулахдаа насанд хүрсэн хүнээр туслуул.



ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Би Мормоны номыг хуваалцаж чадах болов уу?

Жош Арнэтт

Ахлах сургуулийн эхний жил семинарын багш маань манай ангийнхныг гишүүн бус найзууддаа Мормоны ном өгөхөд урьсан юм. Хэдийгээр би туйлын ичимхий байсан ч гэсэн уг урилгыг хүлээн авлаа.

Надад хангалттай урам зориг төртөл хоёр хоног өнгөрөв. Гэвч эцэст нь би үдийн хоолныхоо цагаар найз Бритнидээ номоо өгөөд гэрчлэлээ хуваалцлаа. Бритни намайг ном өгсөнд талархлаа илэрхийлэв.

Тэр хичээлийн жилийн төгсгөлөөр Бритни шилжсэн ч бид холбоотой хэвээр байлаа. Тэр надад шинэ сургуулийнхаа тухай болон бараг

бүх найз нар нь сүмийн гишүүд болохыг ярьсан. Гэхдээ л тэр надтай ямар нэг сүнслэг зүйлийн тухай огт ярьдаггүй байлаа.

Энэ нь намайг номлолд явахаас өмнө өөрчлөгдсөн юм. Би Бритнигээс надад чухал мэдээ дуулгасан мэссэж авлаа. Тэр баптисм хүртэх гэж байгаа бөгөөд намайг түүний сайн найз байгаагийн төлөө бас түүнд сайн үлгэр жишээ үзүүлдэгт талархлаа илэрхийлжээ.

Бурхан номлол хийх туршлагагүй, 15 настай ичимхий хөвгүүнийг сонгож, Өөрийн сайн мэдээг хүлээн авна гэдгийг нь мэдсэн нэгэнтэй үүнийг хуваалцуулахаар

түүнийг чиглүүлсэн ажээ. Бид бүгд Сүнсийг сонссоноор сайн мэдээг хүлээн авахаар хүлээж байгаа эргэн тойрныхоо хүмүүсийг олж чадна гэдгийг би мэднэ. Хэрвээ бид ганцхан бодгалийг Их Эзэнд авчрах юм бол, “[бидний] Эцэгийн хаант

улсад түүнтэй хамт [бидний] баяр хөөр хэчнээн агуу байх билээ!” гэдгийг би мэддэг. (С ба Г 18:15).

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Вашингтонд амьдардаг.



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд эрэлхийлж хай. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн өсгөж, айлчлагч багшаар дамжуулан өөрийн тань харж хандан, анхаарал тавьдаг хүмүүсийн амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг: reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Бурханы Төрсөн Ганц Хүү, Есүс Христийн тэнгэрлэг зорилго

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын хэсэг юм.

Бидний Аврагч, Есүс Христ Төрсөн Ганц Хүү хэмээн нэрлэгддэг. Учир нь Тэрээр энэ дэлхий дээр мөнх бус эх, мөнхийн Эцэг хоёроос төрсөн цорын ганц хүн юм. Тэр Өөрийн Эцэг, Бурханаас бурханлаг хүчийг өвлөн авсан бол эхээсээ өлсөх, цангах, ядрах, өвдөх болон үхэх зэрэг мөнх бус шинжүүдийг өвлөн авсан билээ.¹

Есүс Христ Эцэгийн Төрсөн Ганц Хүү учраас Өөрийн амийг өгч мөн эргүүлээд авах боломжтой байв. Судруудад бид “Христийн Цагаатгалаар” “амилуулалтыг олж болно” (Иаков 4:11) хэмээн заасан байдаг. Түүнчлэн хэрэв бид “итгэсэн” бол “үхэшгүй байдалд мөнх амьдралд босч болох бөлгөө” (С ба Г 29:43) гэдгийг мэддэг.

Бид Есүс Христ Эцэгийн Төрсөн Ганц Хүү гэсэн нь юу гэсэн утгатайг илүү бүрэн ойлгосон үед Христэд итгэх итгэл маань өсөх болно. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон “Есүс



Христэд итгэх итгэл нь (1) Тэр бол Бурханы Төрсөн Ганц Хүү болох нь Түүний жинхэнэ байдал, (2) Түүний хязгааргүй цагаатгал болон (3) Түүний амилалтын үнэмшил ба баталгаа мөн” гэж хэлжээ.² Энэ үеийн бошиглогчид “[Есүс Христ] . . . бие махбодод Төрсөн Ганц Хүү, дэлхийн Цагаатгагч байсан” хэмээн гэрчилдэг.³

Судруудаас

Иохан 3:16; Сургаал ба Гэрээ 20:21–24; Мосе 5:6–9

ЭШЛЭЛ

1. *Сайн мэдээний зарчмууд* (2009), 52–53-ыг үзнэ үү.
2. Д.Тодд Кристоффэрсон, “Христэд итгэх итгэлийг хөгжүүлэх нь,” 2012 оны 9-р сарын *Лиахона*, 13.
3. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл *Лиахона*, 2000 оны 4-р сар, 2–3-р .



Итгэл, гэр бүл, халамж

Бидний түүхээс

Бид Шинэ Гэрээнээс Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлсэн; Түүний сургаалуудыг судалж, тэдгээрийн дагуу амьдарсан; Түүний үйлчлэл, гайхамшгууд болон сүр жавхланг гэрчилсэн нэрийг нь мэдэх болон үл мэдэх эмэгтэйчүүдийн тухай уншдаг. Эдгээр эмэгтэйчүүд авралын ажлын үлгэр жишээ шавь нар, чухал гэрчүүд болсон юм.

Жишээ нь: Марта Аврагчийн бурханлаг чанарын тухай хүчтэй гэрчлэлээ хуваалцан, “Та бол Бурханы Хүү болох Христ, ертөнцөд ирэх Нэгэн мөн гэдэгт би итгэсэн” (Иохан 11:27) гэжээ.

Аврагчийн бурханлаг чанарыг гэрчилсэн анхны гэрчүүдээс Түүний эх Мариа болон үеэл Елизабетийг нэрлэж болно. Тэнгэр элч Габриел Мариа дээр айлчилсны дараа удалгүй Елизабетийнд очжээ. Елизабет Мариагийн мэндийг сонсонгуутаа “Ариун Сүнсээр дүүрч” (Лук 1:41), Мариаг Бурханы Хүүгийн эх болно хэмээн гэрчлэв.

Би юу хийж чадах вэ?

1. Есүс Христийн үүргүүдийг ойлгох нь бидэнд яагаад чухал вэ?
2. Гэрээнүүдээ сахиснаар бидний итгэл хэрхэн өсдөг вэ?

ИХ ЭЗЭН АЛДАР СУУНДАА ДЭЛХИЙД ЭРГЭЖ ИРНЭ

Сүмд бидний хийдэг бүхэн— номлолын ажил, гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил, сайн мэдээг заах, Христийнхтэй адил амьдралаар амьдрах зэрэг нь биднийг болон бусдыг мөнх амьдрал ба Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэдэг.¹

Түүний анхны ирэлт, мөнх бус амьдралыг харьцангуй цөөхөн хүн гэрчилсэн билээ. Харин Түүнийг “сүр хүч хийгээд агуу алдар суундаа” (С ба Г 29:11) эргэж ирэхэд бүх хүн төрөлхтөн харах болно. Хоёр дахь ирэлт Мянган жилтэй давхцах бөгөөд Аврагч “дэлхий дээр зөв шударга ёсоор хүмүүнтэй хамт мянган жил оршин сууна” (С ба Г 29:11).

Судрууд Хоёр дахь ирэлтийн өмнө олон үйл явдал тохиолдохыг дүрсэлдэг. Тэдний заримаас дурдвал:

- Их урвалт буюу үнэнээс нүүр буруулсан явдал (2 Тесалоник 2:1–3; 2 Тимот 4:3–4-р шүлгүүдийг үзнэ үү).
- Сайн мэдээ болон санваарын сэргээлт, Мормоны Номын ирэлт (Исаиа 29:4–18; Үйлс 3:19–21-р шүлгүүдийг үзнэ үү).
- Сайн мэдээг дэлхий даяар номлож байна (Матай 24:14-р шүлгийг үзнэ үү).
- Дайн, ёс бус явдал болон байгалийн гамшгуудын үе (Матай 24:6–7; 2 Тимот 3:1–7-р шүлгүүдийг үзнэ үү).
- Тэнгэр ба газар дээрх гайхамшгууд (Иоел 2:30; мөн Матай 24:29–30; С ба Г 29:14–16; 49:23-р шүлгүүдийг үзнэ үү).

Хэдийгээр бид Түүний Хоёр дахь ирэлт ойрхон байгаа гэсэн тэмдгүүдийг хардаг боловч Их Эзэн

яг хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй: “Тэрхүү цаг хийгээд өдрийг мэдэх хүмүүн үгүй, тэрчлэн тэнгэрт буй тэнгэр элчүүд ч үгүй бөгөөд, тэд түүнийг иртэл мэдэх нь үгүй” (С ба Г 49:7).

Зарим хүмүүс Аврагчийн ирэлтэд бэлтгэгдээгүй байх болно. Энэ нь ёс бусчуудад аймшигтай үе байх ч зөв шударга хүмүүсийн хувьд амар амгалан хийгээд ялалтын цаг байх болно. Тийнхүү судрууд болон хожмын үеийн бошиглогчид Аврагчийг ирэх үед биднийг Түүнтэй уулзахад бэлтгэгдсэн байхаар амьдрахыг бидэнд заадаг. Их Эзэн

“Мөн намайг алдар суундаа залран ирэх тэр өдөр арван онгон охины талаар миний ярьсан сургаалт зүйрлэл хэрэгжих болно.

“Учир нь мэргэн хийгээд үнэнийг хүлээн авсан, мөн Ариун Сүнснийг зам заагчаа болгон авсан, мөн мэхлэгдээгүй тэд—үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдан мөн галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно” (С ба Г 45:56–57; Матай 25:1–13-р шүлгүүдийг үзнэ үү) хэмээн заасан юм. ■

Дэлгэрэнгүй мэдээллийг Лук 21; 2 Петр 3-р бүлэг; Сургаал ба Гэрээ 45:16–52; 88:87–107; 133:17–56-р шүлгүүдээс үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Жишээ нь: Дэвид А.Бэднар, “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 28; Нийл Л.Андэрсэн, “Дэлхийг Хоёр дахь ирэлтэнд бэлтгэх нь,” *Лиахона*, 2011, 5-р сар, 52 дахь хуудсыг үзнэ үү.




“[Есүс Христ] нэгэн цагт дэлхийд эргэж ирнэ гэдгийг бид гэрчилж байна. ‘Дараа нь Эзэний алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ’ (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан болж удирдан, Эздийн Эзэн болж хаанчлах болно. Тэгээд Түүнийг шүтэн биширч, өвдөг бүхэн сөгдөж, хэл бүхэн ярих болно. Бид бүгд ажил үйлс болон зүрх сэтгэлийнхээ хүслийн дагуу шүүгдэхээр Түүний өмнө зогсох болно.”

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл *Лиахона*, 2000 оны 4-р сар, 3-р хуудас.



Хоёр дахь ирэлтийн өмнө газар хөдлөлт, хар салхи, аянга, цахилгаан ба хүчтэй шуургууд болж, далайн давалгаа өөрсдийгөө “зааг хязгаараасаа халин” шидлэх болно (С ба Г 88:89–90-р шүлгүүдийг үзнэ үү).



“Эзэний агуу, аймшигт өдөр ирэхийн өмнө нар харанхуйлж, сар цус болж хувирна” (Иоел 2:31).



Аврагч алдар суундаа эргэж ирэх болно: “Мөн түүний оршихуйн алдар суу нь, нар ичингүйрч нүүрээ нуух . . . болно” (С ба Г 133:49).

Аврагчийг Чидуны уулан дээр зогсоход иудейчүүд “Таны гар мөн хөл дээрх эдгээр шархнууд чинь юу вэ?” гэж асууна. Тэрээр “Эдгээр шархнууд бол найз нарынхаа гэрт миний шархадсан тэрхүү шархнууд болой. . . . Би бол цовдлогдсон Есүс болой” гэж хариулах болно. (С ба Г 45:48–52-р шүлгүүдийг үзнэ үү.)

Зөв шударга хүмүүс амилуулагдан, Аврагчийг угтахаар үүлэнд дээш аваачигдана (С ба Г 88:95–97-р шүлгүүдийг үзнэ үү).



ХҮҮХДҮҮДЭД АРИУН СҮНСИЙГ ТАНИН МЭДЭХЭД ТУСЛАХ НЬ

Мэррили Браун Бояк

Бид хүүхдүүдээ гэрчлэлээ хөгжүүлэхэд нь туслахын тулд Ариун Сүнс бидэнтэй харилцдаг олон өөр аргуудыг ашиглаж болно.

Нөхөр бид хоёр дөрвөн хөвгүүний эцэг эхийн хувьд хүүхдүүдээ Сүнсийг мэдэрч, гэрчлэлтэй болоход нь туслах арга замуудыг үргэлж хайдаг билээ. Бид энэ зарчмыг ер бусын арга замаар ойлгоход чухал амжилт олсон юм. Сүнсний өдөөлт ирэхэд би дэлгүүрт байлаа.

Том хүүгийн маань нийгэм судлалын хичээлийн дүн буурсан байв. Энэ талаар бид түүнтэй ярьж, улам шаргуу суралцахад нь тусалж дэмжсэн ч сурлага нь сайжирсангүй. Бид түүнд тусалж болох санаа олж мэдэхийн төлөө залбирсаар байв. Нэг өдөр намайг номын дэлгүүрт байх үед хямдрал зарласан номуудаас нэг ном худалдаж авах хэрэгтэй гэсэн хүчтэй сэтгэгдэл төрлөө.

Тэр номд бид сурах арга барилаараа хэрхэн өөр өөр байдаг тухай өгүүлсэн байлаа. Ихэнх хүмүүс харж суралцдаг суралцагчид байдаг. Энэ нь тэд харсан зүйлээсээ хамгийн их юм сурдаг гэсэн үг. Ийм суралцагчид нь ихэвчлэн уран зурагт болон уншихад дуртай байдаг. Зарим хүмүүс сонссон зүйлээ хамгийн сайн сурдаг. Тэд мэдээллийг сонсож, ойлгон, ой тойндоо хадгалснаар сайн сурч чаддаг ажээ. Ийм хүмүүс ихэвчлэн хөгжимд дуртай байдаг. Эцэст нь, зарим хүмүүс юмсын хөдөлгөөнийг хараад эсвэл өөрсдөө хөдөлж байж, сайн суралцдаг байна. Тэд хөдөлгөөн эсвэл үйл ажиллагаанд оролцож байж, хамгийн сайн



сурдаг ажээ. Ийм суралцагчдыг багш нар нь хөдөлгөөнгүй суулах гэж зарим үед шахдаг учраас сургуульд сурах нь бэрхшээлтэй байдаг. Тэд хааяагүй хөдөлж, явж байхдаа хамгийн сайн сурдаг байна.

Хариулт нь үүнд л байлаа! Хүү маань яахын аргагүй сонсож, сурдаг.

Тэр хөгжимд болон ярилцахад дуртай байлаа! Бид түүнийг нийгэм судлалын хичээл дээр өөр зүйл хийж байхад нь багш нь ихэнхдээ ангиас гарган, хичээлээ гэртээ унш гэдэг байсныг мэдсэн юм. Ангиараа ярилцах ярилцлагыг сонсож чадахгүй байсан учраас түүнд хэцүү байж.

Бид үүнийг нэгэнт ойлгосон болохоор түүнийг даалгавраа чанга уншаад дараа нь бидэнтэй ярилцахад нь урамшуулан дэмжсэнээр түүний сурлага хурдан сайжирсан юм.

Сүнслэг туршлагыг дэмжих нь

Суралцах хэв маягийн тухай бидний ойлголт тэгээд зогсоогүй билээ. Бид үүнийг илүү ихээр судалж, хүүхдүүдээ ажигласнаар Ариун Сүнс хүүхдүүдэд маань тэдний хамгийн сайн сурч чадах аргаар заадгийг ухаарсан юм. Сүнс бидэнд бидний ойлгож чадах аргаар, бидний хэлээр бидэнтэй ярьдаг болохыг бошиглогч Иосеф Смит заасан. Ариун Сүнс Өөрийнхөө хэлээр хүн бүгдэд, тэр ч байтугай бяцхан хүүхдүүдэд хүртэл ойлгомжтой байхаар тохируулан ярьдаг. “Бидний Тэнгэрлэг Эцэг бидэнд үргэлж нээлттэй байдаг. Тэрээр бидний ойлголтын түвшинд тохируулан ярьдаг. ‘Хэрэв Тэр бяцхан хүүхэд дээр ирвэл, Өөрийгөө тэр бяцхан хүүхдийн хэл болон чадварт тохируулан өөрчлөх болно’ (Иосеф Смит, *History of the Church*, 3:392).”¹

Сүнс бидэнд тохируулан харьцдаг. Үүнийг мэдэх нь эцэг эхчүүдийг хүүхдүүдийнхээ хувьд Ариун Сүнсний заах зүйлсийг хамгийн сайн ойлгож чадах аргаар сонсох боломж бий болгоход урамшуулан дэмждэг. “Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” (Исаиа 54:13).

Өмнө нь дурдсанчлан, том хүүгийн маань суралцах үндсэн арга нь сонсох байв. Том болон гурав дахь хүү хоёр маань хоёулаа хөгжимд дуртай, тиймээс бид гэртээ Мормоны Табернеклын найрал дуу болон сонгодог хөгжмийг ихэвчлэн тоглодог байлаа. Тэд ийм орчинд Сүнсийг маш сайн мэдэрдэг байлаа.

Бид түүнчлэн сайн мэдээний талаар олон удаа ярилцсан бөгөөд энэ нь тэдэнд Сүнсээр баталгаажсан үнэнүүдийг сурахад тусалсан билээ.

Бас нэг хүү маань голдуу харсан зүйлээ сайн сурдаг байв. Манай тэр хүү унших дуртай байсан бөгөөд судар болон сайн мэдээнд төвлөрсөн номуудаас уншихдаа Сүнсийг хамгийн сайн мэдэрдэг байсан. Бид түүнд унших олон ном өгнө. Энэ нь түүнд Сүнс мэдэрч, гэрчлэлтэй болоход нь тусалсан. Түүнчлэн бид сайн мэдээг тусгасан зураг болон хэллэгүүдийг ханан дээрээ байрлуулснаар гэр маань харж суралцах хангалттай орчин болсон юм.

Хоёр дахь хүү маань харж мөн хөдөлгөөнөөр сурдаг байлаа. Манай тэр хүү үнэхээр их хөдөлгөөнтэй. Тэр аавтайгаа ууланд дугуйгаар эсвэл явган явахдаа жинхэнэ жаргалаа эдэлдэг байлаа. Бид түүнийг гадаа байж, явж, хөдөлж байхдаа Сүнсийг хамгийн их мэдэрдгийг олж мэдсэн юм. Бид гэр бүлээрээ олон удаа зугаалж, зугаалгынхаа үеэр Есүс Христ, бүтээлт болон авралын төлөвлөгөөний талаар ярилцдаг байлаа. Эдгээр үйл ажиллагаануудын үеэр захиасууд хоёр дахь хүүд маань илүү хүчтэйгээр хүрдэг байсан.

Нөхөр бид хоёр хөдөлгөөнөөр сурах арга нь үйлчлэл хийж байхад мөн илэрдгийг анзаарсан. Тиймээс хүүхдүүд маань харж, сонсож, оролцож болохын тулд бид үйлчлэлийн олон үйл ажиллагаа зохиодог болсон. Энэ нь манай бүх хөвгүүдэд энэрэл үзүүлэх болон Христийнхтэй адил үйлчлэл хийж сурах гайхалтай орчныг бүрдүүлсэн бөгөөд эдгээр бүх төслүүд ялангуяа хоёр дахь хүүд маань илүү их нөлөөлсөн юм.

Сонсох ба ойлгох нь

Бид түүнчлэн хүмүүс олон янзын арга замаар Ариун Сүнсийг



“сонсдог” болохыг мэдсэн. Би шинэхэн хөрвөгчдөд ням гарагийн ангийн хичээл зааж байхдаа тэднээс “Та Ариун Сүнсийг яаж мэдэрдэг вэ?” гэж асуудаг байлаа. Тэдний хариулт үнэхээр санаа авууштай байлаа. Нэг нь “Би бодол санаандаа маш тодорхой мэдэрдэг” гэлээ. Өөр нэг нь “Би дотроо дулаахан мэдрэмжийг мэдэрдэг” гэхэд бас нэг нь “Би амар амгалангийн гүн гүнзгий мэдрэмжийг мэдэрдэг” гэсэн. Гишүүн болоод хэдхэн сар болж байгаа нэг эмэгтэй “Би бүх биеэрээ хатгуулж байгаа юм шиг болдог” гэлээ. Мөн нэлээд хэдэн хүн тэд заримдаа өөрт нь хандан ярих дуу хоолойг “сонсдог” эсвэл тэдэнд шинэ санаанууд төрдөг гэж хэлэв.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс: “Илчлэл болон сүнслэг удирдамж нь үгсээр эсвэл оюун ухаантай нэгдэн нийлсэн бодол санаагаар илүү танил хэлбэрээр (Инос 1:10; С ба Г 8:2–3-р шүлгүүдийг үзнэ үү), гэнэтийн гэгээрлээр (С ба Г 6:14–15-р шүлгүүдийг үзнэ үү), төлөвлөсөн үйлдлийн тухай эерэг буюу сөрөг мэдрэмжээр эсвэл сүнслэгээр нөлөөлөх үзүүлбэр ба урлагийн тоглолтоор дамжин ирдэг.



... “Сүнслэг удирдамж нь дуу хоолой гэхээсээ илүү мэдрэмжээр ирдэг” гэж заасан юм.²

Бидний хүн нэг бүр Ариун Сүнсний харилцааг янз бүрийн арга замаар сонсож, мэдрдэг нь тодорхой. Бид хүүхдүүдээ дулаан мэдрэмжийг мэдрүүлэхийн тулд энгийнээр заах хэрэгтэй, эсвээс тэд уг мэдрэмжийг мэдрэхгүй өнгөрч магадгүй. Хүүхдүүд сүнслэг удирдамжийг өөр өөрөөр хүлээн авч болно.

Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн асан ахлагч Жэй И.Жэнсэн нэгэн номлолоор ирсэн Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын нэг гишүүний тухай дараах түүхийг ярьжээ. Тэр Төлөөлөгч бүсийн чуулгануудын хооронд, өмнөх чуулган

дээр үг хэлсэн Далын гишүүнд хандаж, “Би таныг өөрөө ч шийдэж чадахааргүй улам олон асуудлыг бий болгосон нэгэн санааг номлогчдын оюун бодолд үлдээсэн юм биш үү гэж бодож байна. Би сүм даяар аялах үедээ цээжин бие дотроо шатах лугаа адил мэдрэмжийг мэдрсэн цөөн хүнтэй таарч байсан. Хэрэг дээрээ олон хүн надад удаан хугацааны турш мацаг барьж, залбирсан ч тийм мэдрэмжийг огт мэдэрдэггүйдээ бухимддаг тухайгаа ярьсан” гэж хэлжээ. Ахлагч Жэнсэн цааш нь: “Би олон жилийн турш Их Эзэний Сүнс ажилладаг өөр өөр арга замуудыг сурахыг хичээсэн. Бурхан үнэхээр тэнгэрээс ярьдаг гэвч Тэрээр гэрчлэл, баталгаа эсвэл

удирдамжийг олон янзын арга замаар өгдөг” гэж ярьжээ.³ Бид хүүхдүүдээ Сүнсний тэдэнд хандан ярьдаг арга замуудаар Түүнийг сонсож сурах хэрэгтэй гэдгийг заах нь маш чухал юм.

Бид хүүхдүүдээ заахдаа итгэл, наманчлал, баптисмын зарчмууд ба Ариун Сүнсний бэлгийн талаар хуваалцдаг. Тэдэнд ирдэг сүнслэг өдөөлтүүдийг хэрхэн сонсож, ойлгохыг заах нь тэдний сүнслэг байдлын өсөлтөд туйлын чухал юм. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910-2008): “Тэд тантай хамт байгаа үед [хүүхдүүдээ] өөрийн тань өгч чадах бүх хүч чадал, итгэл тэдэнд хэрэгтэй байх болно. Мөн тэдэнд илүү дээд хүчнээс ирдэг илүү агуу хүч чадал бас хэрэгтэй байх болно” хэмээн зөвлөсөн билээ.⁴

Ариун Сүнсээр дамжуулан Тэнгэрлэг Эцэгээсээ удирдамж, чиглүүлэл авах нь бидний амьдралд агуу адислал болдог. Бид эдгээр өдөөлт, мэдрэмж болон зааварчилгаануудыг хэрхэн хүлээн авч, анхаарал хандуулахыг хүүхдүүдээ заах үед тэд өөрсөд нь ирээдүйд хүч чадал өгөх хувийн гэрчлэлтэй болдог. Ариун Сүнс тэдний байнгын хамтрагч байснаар тэд Түүнийг илүү бүрэн дүүрэн сонсох боломжтой болно. Эцэг эхчүүд бид энэхүү үйл явцаар дамжуулан, хүүхдүүдээ адислахад тусалж чадна. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Калифорнид амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Жэральд Каусэ, “Бүр хүүхэд ч гэсэн ойлгож чадна,” *Лиахона*, 2008-оны 11-р сар, 39-р хуудас.
2. Даллин Х.Өүкс, “Иачлэлтийн найман шалтгаан,” *Лиахона*, 2004 оны 9-р сар, 8-р хуудас.
3. Жэй И.Жэнсэн, “Have I Received an Answer from the Spirit?” *Ensign*, 1989 оны 4-р сар, 21-22 -р хуудасууд.
4. Гордон Б.Хинкли, “Бидний эдгээр бяцхан үрс,” *Лиахона*, 2007 оны 12-р сар, 7-р хуудас.

НАМАНЧЛАЛ

Аврагч Есүс Христийн цагаатгал наманчлалыг боломжтой болгосон бөгөөд хүн бүр наманчлах ёстой.

Зарим ноцтой гэм нүгэл нь бишоп, салбарын ерөнхийлөгчдөө гэм буруугаа хүлээх алхмыг шаарддаг учраас заримдаа бид үүнээс айдаг хэмээн Далин ахлагч Брэдди Д.Фостэр энэ сарын Лиахонагийн 54–55-р хуудсан дээрх өгүүлэлдээ тайлбарлажээ. Гэсэн ч “Наманчлалын замаар аялсан хүмүүс танд хэлэх болно, аялал нь боломжтой зүйл төдийгүй та тэнд очоод эргээд харвал энэ бол таны харах зүйл:

“Та үүнийг хийж чадна. Тэгээд та үүнийг хийвэл бүх зүйл сайжрах болно. . . .

“Та хийж эхэлмэгцээ тусламжийг мэдрэх болно. . . .

“Бишоп тань энэхүү үйл явцын туршид туслах болно. Та түүнийг хайрладаг болж, тэгээд хэзээ ч мартахгүй.”

Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

Өсвөр насны хүүхдүүдтэйгээ наманчлалын тухай *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос уншиж, цагаатгалаар дамжуулан, бидний хүлээн авдаг адислалууд болон наманчлал нь эдгээрийг хэрхэн боломжтой болгодог тухай ярилц.

Түүнчлэн та наманчлал болон цагаатгал мөн тэдгээр нь таны амьдралд ямар утга учиртай тухай гэрчлэлээ хуваалцаж болно. Та өсвөр насны хүүхдүүдээсээ наманчлалын тухай гэрчлэлээ хуваалцахыг хүсч болно. Боломжтой бол та өсвөр насны хүүхдээрээ дүү нартаа дараах үйл ажиллагааг хийхэд нь туслууц болно.

Хүүхдүүдэд заах зөвлөмж

Их Эзэн биднийг дага хэмээн тушаасан зам дээр үлдэх гэсэн нь юу гэсэн утгатайг тайлбарлахын тулд тоглоомон машиныг (эсвэл онгоц, завь юм уу галт тэрэг) хичээлдээ ашигла. Газрын зураг ашиглан, хүүхдээсээ газрын зургийн нэг цэгээс нөгөө рүү уг машиныг явуулахыг хүс. Тэгээд “Хэрэв машин замаасаа хазайх хэрэгтэй болбол юу шаардлагатай вэ?” гэж асуу.

Хэрэв машин замаасаа хазайсан бол үүнийг зөв чиглэлд нь буцаах ёстой, энэ нь наманчлалтай хэрхэн адил болохыг асуу. Бид амьдрал дундуур аялах үедээ заримдаа зөв замаар явахын тулд чиглэлээ өөрчлөх хэрэгтэй болдгийг тайлбарла. Заримдаа бид үүнийг өөрсдөө хийж чадна. Гэвч заримдаа бидэнд тусламж хэрэгтэй болдог. Хүүхдүүдээсээ өмнө нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ тэдэнд тусалж чадах зүйлийг тэд өөрсдөө хийсэн эсвэл бусад хүмүүс



НАМАНЧЛАЛЫН ТАЛААРХ СУДРУУД

Сургаалт Үгс 28:13

Исаиа 1:16–18

Инос 1:2–8

Мозая 4:1–3; 26:30–31

Алма 34:32–34

Хиламан 12:23

3 Нифай 9:20–22

Сургаал ба Гэрээ 18:10–13;

58:42–43

тэдэнд тусалсан тухай ярихыг хүс. Энэ сэдвийг заахдаа наймаас доош насны хүүхдүүд хариуцлага хүлээх чадваргүй бөгөөд наманчлах хэрэггүй, гэхдээ тэд наманчлалын зарчмыг сурах нь чухал гэдгийг санаарай.

Тэдний хариултуудын тухай болон наманчлал нь хэрхэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын бидэнд өгсөн бэлэг бөгөөд биднийг Тэдэн рүү буцаж очих боломжтой болгодог талаар яриарай. ■

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын талаар news.lds.org-аас үзнэ үү.

Ахлагч М. Рассэлл Баллард Европ дахь гэгээнтнүүдэд хандан, үг хэлэв

Бурханы хаант улс болон сүмийг хөгжүүлэх Хожмын үеийн гэгээнтнүүдийн хүч чармайлтад Европын эхэн үеийн анхдагчдын үзүүлж байсан итгэл өнөө үед шаардлагатай байна хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М. Рассэлл Баллард Швед, Дани, Финлянд болон Норвеги дахь сүмийн гишүүдэд зориулсан шууд нэвтрүүлгийн үеэр хэлжээ.

“Одоогоос 20 жилийн дараа танай оронд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм ямар байх вэ?” хэмээн ахлагч Баллард асуужээ. “Хэрэв бидний итгэл, урам зориг,

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М. Рассэлл Баллард зургаадугаар сард Швед дэх уулзалтын дараа сүмийн гишүүдтэй хамт байгаа нь



үйлдэл тэднийх шиг биш байгаа бол, хэрэв бид сүмийн тойрог, салбар, гадас, дүүрэг бүрийг хүчирхэгжүүлэхийн төлөө чадах бүхнээ хамгийн сайнаар хийсэн хэмээн сүнсний дэлхий дэх Скандинавын анхны гишүүдэд тайлагнаж чадахгүй юм бол бид тэдэнд юугаа хэлэх билээ дээ?”

Энэхүү нэвтрүүлэг нь Шведийн Стокгольм, Английн Лондон мөн Францын Парист хийсэн ахлагч Баллардын саяхны айлчлалын нэг хэсэг байв.

Ахлагч Баллард Шведэд үйлчилж буй номлогчидтой уулзан, Стокгольмын ганц бие залуучуудад хандан үг хэлсэн юм. Энэхүү цуглааныг Европын бүс дэх 402 цуглааны байранд нэвтрүүлэн үзүүлжээ. Тэрээр гэрлэлтийн ач холбогдлын тухай ярьж, сайн мэдээний зарчмуудаар амьдрахаар залуучуудын хийдэг сонголт сүмийн ирээдүйг тодорхойлох болно гэдгийг онцлон тэмдэглэжээ. Тэрээр энэ жилийн эцэс гэхэд хүн бүр хэн нэгнийг сүмд нэгдэхэд нь эсвэл дахин идэвхтэй болоход нь туслах хэрэгтэй хэмээн уриалан дуудсан юм.

Түүнчлэн ахлагч Баллард Швед, Дани, Финлянд болон Норвегийн бүх цуглааны байруудад үзүүлсэн шууд нэвтрүүлгээр Скандинавын чуулганд оролцсон сүмийн гишүүдэд хандан үг хэлжээ. Скандинавын орнуудад сүмийн гишүүнчлэл 23 000-аас давсан бөгөөд тэд 123 нэгжид цугларч байна.

Английн Лондонд ахлагч Баллард болон Европын бүсийн ерөнхийлөгч Хосе Тэйксэйра нар Лондон ба Өмнөд Лондоны номлолуудад үйлчилж буй номлогчидтой уулзлаа. Олон зуун номлогч ахлагч Баллардын гэрчлэлийг сонсож, номлолын ажлын төлөөх түүний урам зоригийг мэдэрчээ.

Ахлагч Баллард Францын Версаль дахь номлогчидтой уулзав. Түүнчлэн тэрээр 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулганаар зарлагдсан Францын Парисын ариун сүмийн газар дээр очиж үзжээ. ■

Сүмийн мэдээ, Сара Жэйн Вийвэрийн өгүүлээс.

Мормоны Ном малай хэлээр

Сүм Мормоны Номыг малай хэлээр хэвлэгдэн гарсныг зарлалаа. Энэ судар ийнхүү 109 хэлээр хэвлэгдээд байна. Мормоны Ном энэ оны гуравдугаар сард словак хэлээр орчуулагдан гарчээ. Малайз, Сингапур, Индонези, Энэтхэг зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудад малай хэлээр ярьдаг.

Малай хэл дээрх Мормоны Номыг орон нутгийн сүмийн хангамжийн төвүүд, store.lds.org (зүйлийн дугаар 35607 348) болон scriptures.lds.org дээрх онлайн дэлгүүрээс авах боломжтой.

Хүүхдүүдэд заах материалуудыг LDS.org-оос үзнэ үү

Багш, удирдагчид болон эцэг эхчүүд сайн мэдээг заахдаа *Friend* ба *Лиахона* сэтгүүлүүдийг хэдэн арван жил ашиглаж байгаа билээ. Өнөөдөр эдгээр материалуудын заримыг нь онлайнгаар LDS.org-оос үзэх болсон тул та хайж буй хичээлийн материалаа хялбархан олж болно.

Та материалуудыг сэдэв, төрөл зүйл мөн англи хэл дээрх Хүүхдийн хэсгийн хичээлийн дугаараар LDS.org дээрх хайлтын цонхонд “Resources for Teaching Children” хэмээн бичин, хайж болно. Та бас Хүүхдийн хэсгийн гарын авлагын хуудсаас энэ хуудас руу нэвтрэн орж болно.

Хүүхдүүдэд заах материалуудыг мөн испани, португал хэлээр үзэх боломжтой бөгөөд LDS.org болон *Лиахона*-ийн үндсэн хуудсанд байгаа.

Материалуудад түүх, үйл ажиллагаа, *Лиахона*-ийн өгүүллүүд болон хүүхдүүдэд гэрт нь эсвэл сүм дээр заах, сүмээс зөвшөөрөгдсөн хэвлэл мэдээллийн бусад материалууд багтсан байгаа. Сар бүр тодорхой сэдвүүд нэмэгдэнэ.

LDS.org Мэдээ ба үйл явдлууд,
Камилл Вэстийн өгүүллээс.

Хүүхдийн хэсэг 135 жилийн ОЙГОО ТЭМДЭГЛЭВ

135 жилийн өмнө АНУ-ын Ютагийн Фармингтонд бишоп Жон В.Хэсс тойргийнхоо хүүхдүүдийн зан байдалд санаа нь ихэд зовдог байв. Тэрээр тойргийнхоо эхчүүдийг цуглуулан уулзаж, бага насны хүүхдүүдийг сүнслэгээр хөгжүүлэхийг удирдан чиглүүлэх нь хэчнээн чухал болох тухай ярьсан ажээ.

Аурэлиа Спэнсэр Рожэрс үүнийг сонсоод Элиза Р.Снөүтэй энэ талаар ярилцсан бөгөөд Снөү эгч 1878 оны хавар Фармингтонд очжээ. Тэгээд Снөү эгчийг сүмийн ерөнхийлөгч Жон Тэйлортэй уулзахад ерөнхийлөгч бишоп Хэсс тойрогтоо хүүхдүүдэд зориулсан бүлэг байгуулах эрх мэдэл олгосон аж. Фармингтон

тойргийн Хүүхдийн нийгэмлэг 1878 оны 8-р сарын 11-нд албан ёсоор байгуулагдаж, Рожэрс эгч ерөнхийлөгчөөр нь дуудагджээ.

Өнөөдөр дэлхий даяар долоо хоног бүр ойролцоогоор нэг сая хүүхэд Хүүхдийн хэсэгт явж байна. Хүүхдийн хэсгийн удирдагчид ба багш нар Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ мөн сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болоход нь хүүхдүүдээ туслах эцэг эхчүүдийн үүрэгт дэмжлэг үзүүлэхийг хичээдэг. ■

Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл, Рөүзмэри М.Виксом, Жийн А.Стийвэнс, Чэрил А.Эсплин нарын өгүүллээс авав.



Хүүхдийн нийгэмлэгийн анхны цуглаан, Лин Фаусэтт, Гордон Кеуп нар.



Хүүхдийн хэсгийн удирдагчид болон багш нар хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ мөн сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болоход нь туслахыг хичээдэг.





ИРЦГЭЭ, ТҮҮНИЙГ ШҮТЭН БИШИРЦГЭЭ

*Биднийг нүгэл, нөхцөл байдал
эсвэл өнгөрсөн үйл явдлууд гээд юу ч
хүлсэн бай Их Эзэн, Агуу Иммануел
биднийг чөлөөлөхөөр ирсэн.*

Есүс Христийн төрөлтөөс 700 гаруй жилийн өмнө Исаиа Түүний тухай бошиглож байсныг Фридрих Хэндэл *Мессиа* магтуу дуундаа “Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд Хүү өгөгдөнө: Засаглал Түүний мөрөн дээр байх болно: Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна” (Исаиа 9:6) хэмээн оруулжээ.

Хэндэлийн *Мессиа* магтуу дуу нь түүнчлэн Исаиа 40:9-р шүлгэн дээр тулгуурлан, агуу хөгжмийн амьдралд “Сайн мэдээг үүрэгч Сион оо! Өндөр уулан дээр гарагтун. Сайн мэдээг үүрэгч Иерусалим аа! Дуугаа чанга өргөгтүн. Өргөгтүн! Бүү айцгаа. “Та нарын Бурхан энд байна” хэмээн Иудагийн хотуудад хэлэгтүн” гэсэн анхааруулгыг өгдөг.¹

Бетлехемд өлгийтэй бяцхан хүүхэд болж мэндэлсэн өөрсдийн Бурханаа болгоогтун. Энгийн хүмүүсийн дунд энгийнээр алхаж болохын тулд энгийн ядуу төрсөн өөрсдийн Бурханаа болгоогтун. Өөрийн бүтээсэн дэлхий дээр амьдарч болохын тулд махан биеэр ирсэн хязгааргүй хийгээд мөнхийн Гэтэлгэгч болох өөрсдийн Бурханаа болгоогтун.

Их Эзэнийхээ төрөлтийг тунгаан бодохоор надтай хамт Бетлехем дэх анхны ариун Христийн мэндэлсний баярт очицгооё. Тэрбээр цаг хугацааны голчид шөнийн нам гүмд ирсэн Иммануел (Исаиа 7:14), Иессийн хожуул (Исаиа 11:1-р шүлгийг үзнэ үү), Мандах нар (Лук



1:78-р шүлгийг үзнэ үү), Төгс Хүчит Эзэн (2 Коринт 6:18-р шүлгийг үзнэ үү) билээ. Түүний төрөлт Бүтээгчийн дэлхий дэх амлагдсан айлчлал, хүмүүнд хандах Бурханы хүлцлийг тэмдэглэсэн юм (1 Нифай 11:16–27-р шүлгийг үзнэ үү). Уг үйл явдлын талаар Исаиа: “Харанхуйд алхаж яваа хүмүүс агуу их гэрлийг үзнэ. Харанхуй газарт амьдарч байгаа хүмүүс дээр гэрэл тусна” (Исаиа 9:2) гэж хэлжээ.

Орчин үеийн илчлэлтээс бид урьдаас томилогдсон Израилын Хаан дэлхийд хаврын цагт ирснийг мэддэг (С ба Г 20:1-р шүлгийг үзнэ үү). Мика Түүнийг Бетлехемд “Иудагийн бүлүүдийн дунд” (Мика 5:2) төрөх болно гэж бошигложээ. Түүний төрсөн тосгон нь Иерусалимын сүүдэрт, үүнээс 8 км-т, умардад байрладаг. Иерусалим нь Иудейн нийслэл хот, ариун сүмийн суудал, Ромын эзэнт гүрний хэрэм байсан билээ. Бетлехем нь газар тариалан, гар нэхмэл, хөдөө аж ахуйн тосгон байлаа. Энэ нь Христийн төрөх угсаа болох Израилын эртний хаан Давидын төрсөн нутаг гэдгээрээ алдартай байв. Иймээс энэхүү бяцхан тосгоныг Давидын хот хэмээн нийтээр нэрлэдэг байжээ. Энэ нь еврей нэр бөгөөд *Бэт Лэхэм* гэдэг нь “Талхны гэр”² гэсэн утгатай юм. Амьдралын талх хэмээгдэх Нэгэн ирэх хүртэл энэ нэр онцгой утга учиргүй байлаа.

Бетлехемийн эргэн тойрон дахь талбай нь тоо томшгүй олон хонин сүргийн бэлчээр байсан бөгөөд хаврын эхэн үе бол мал төллөх үе юм. Хоньчид ихэвчлэн

Аврагч амьдралыг бүх талаас нь, өнцөг бүрээс нь, дээгүүр ба доогуур хоёулангаар нь мэддэг билээ. Хамгийн Агуу Нэгэн атлаа Өөрийгөө хамгийн доогуурт тавьсан Тэнгэрлэг Хоньчин Тэрбээр Хурга болжээ.

шөнөдөө унталгүй болор шөнийн тэнгэрийн дор хонио хариулдаг байв; тиймээс Аврагчийн төрөлтийг зарласан тэнгэр элчүүд тэднийг сэрээх хэрэггүй байжээ.

Бурханы Хурга

Мал төллөх цагаар ирсэн эрэгтэй хүүхэд “Бурханы Хурга” (Иохан 1:29; 1 Нифай 11:31; С ба Г 88:106) байсан юм. Энэ нь гүн утга учир агуулсан нэр байв, учир нь Тэрээр хургануудтай хамт мөндэлж, нэгэн өдөр “алагдахаар хөтлөгдөх хурга шиг” (Исаиа 53:7) байх болсон юм. Гэвч хачирхалтай нь, Тэрбээр Хургануудаа халамжилдаг Сайн Хоньчин (Иохан 10:11-р шүлгийг үзнэ үү) байсан юм. Ийнхүү Түүний амьдралын энэ хоёр бэлгэдэл нь үйлчлэх болон үйлчлүүлэх хүмүүсийг төлөөлдөг билээ. Энэ хоёр үүргийг биелүүлэх эрхтэй нь ганцхан Христ байлаа, учир нь Тэрээр амьдралд “бүх зүйлийн доор бууж ирсэн” (С ба Г 88:6) бөгөөд үүрд мөнхөд “бүх зүйлийн дээгүүр” мөн бүх зүйлийн дотор мөн “эргэн тойронд байдаг” (С ба Г 88:6, 41). Тэрбээр амьдралыг бүх талаас нь, өнцөг бүрээс нь, дээгүүр ба доогуур хоёулангаар нь мэддэг байсан. Хамгийн Агуу Нэгэн атлаа Өөрийгөө хамгийн доогуурт тавьсан Тэнгэрлэг Хоньчин Тэрбээр Хурга болжээ.

Түүний ирэлт нь агуу бошиглогчийн төрөлт, хаан сэнтий амлагдсан өв залгамжлагчийн ирэлт, бүр дэлхий дээр алхах цорын ганц төгс хүний ирэлтээс

илүү энгийн байлаа. Энэ нь “бараг хүн шиг байж, өөрийн хөлийн гишгүүр дээр алхах” тэнгэрийн Бурханы ирэлт байлаа.³

Есүс Христ бол дэлхийг Бүтээгч бөгөөд Хуучин Гэрээний Агуу Иехова билээ. Синайн ууланд дуудсан нь Түүний дуу хоолой, израилчуудын аялалд тэднийг хамгаалсан нь Түүний хүч мөн ирэх зүйлсийн алдар сууг Енох, Исаиа болон бүх бошиглогчдод илчилсэн нь Түүний оршихуй байсан юм. Үүнд л Христийн төрөлтийн хамгийн агуу гайхамшиг оршино. Газар тэнгэрийг Бүтээгч, Бурхан Өөрийгөө дэлхийд анх өөрийн биеэр илчлэхдээ Тэрбээр бусдаар тэтгүүлдэг арчаагүй нэгэн нялх хүүхдийг сонгожээ.

Эртний Еврейд ам дамжсан яриагаар Мессиа Дээгүүр өнгөрөх баярын үеэр мэндэлнэ гэдэг байв. Цаг хугацааны голч дахь Април хэмээх дөрөвдүгээр сар нь үнэхээр Дээгүүр өнгөрөх баяр—Египетийн ууган хөвгүүдэд үхлийг авчирсан устгагч тэнгэр элчээс эсэн мэнд үлдсэн израилчуудын авралыг тэмдэглэх Иудейн ариун баярын долоо хоногийн үеэр таарсныг бид мэднэ. Израилын гэр бүл бүр хурга тахилд өргөл болгож, модон хаалганыхаа тогтон дээр цусыг нь түрхэн аврагдсан юм (Египетээс гарсан нь 12:3-30-р шүлгүүдийг үзнэ үү). Христийн төрөлтөөс хойш 33 жилийн дараа Дээгүүр өнгөрөх баяраар Өөрийн хүмүүсийг үхэл ба нүглийн устгагч тэнгэр элчээс аврахаар Түүний цус модон загалмайд нялагдсан билээ.

Дээгүүр өнгөрөх баяр нь Мариа, Иосеф хоёрт дэн буудалд өрөө олодоогүйн шалтгаан болсон байж магадгүй. Иерусалимын хүн ам Дээгүүр өнгөрөх баярын үеэр хэдэн арван мянгад хүрдэг учраас аянчид ойролцоох тосгодоор орон байр хайдаг байлаа. Мариа, Иосеф хоёр Иосефын өвөг дээдсийн нутаг Бетлехемд Цезарь Августын зарлигаар явуулдаг байсан эзэнт гүрний хүн амын тооллогын шаардлагыг биелүүлэхээр очжээ. Тооллогын шаардлагаар тэд жилийн аль ч үед Бетлехемд

очиж болох байв. Гэвч тэд Дээгүүр өнгөрөх баярын үеийг сонгосон нь уг баяраар бүх эрэгтэйчүүд Мосегийн хуулийн дагуу Иерусалимд цугладаг байсантай холбоотой аж.⁴ Бетлехем нь Ариун хоттой (Иерусалим) ойрхон байсан учраас Назарын хосууд энэхүү хоёр үүрэг хариуцлагыг нэг дор биелүүлж болох байв.

Түүхэн талаас нь авч үзвэл, дэн буудлын эзнийг муухай зантай гэгцгээдэг байжээ. Гэсэн ч Дээгүүр өнгөрөх баярын үеэр тэр хавиар хүн ихтэй байсан учраас бид түүнийг Назараас ирсэн хосуудад өрөө гаргаж өгөөгүй хэмээн буруутгаж болохгүй. Дээгүүр өнгөрөх баяраар ирсэн аянчдын ихэнх нь Иерусалимын эргэн тойронд мянга мянгаараа майхан босгон, түүндээ байдгаас гадна бусад мянга мянга нь орон нутгийн дэн буудлуудад буудаг байв. Бетлехем дэх дэн буудал зочдоор дүүрэн байсан нь тодорхой бөгөөд харин дэн буудлын эзний санал болгосон малын хашаа түүний сайхан сэтгэлийн илрэл ч байж болох юм.

Хосууд дэн буудалд өрөө олсон ч энэ нь ая тух муутай байх байв. Тэр үеийн дэн буудлууд ихэвчлэн гурван ханатай, нэг талдаа задгай жижиг өрөө бүхий чулуун барилга байсан аж. Харин малын хашаа нь зочдын унаа хөсгийг хашдаг

Эртний Еврейд ам дамжсан яриагаар Мессиа Дээгүүр өнгөрөх баярын үеэр мэндэлнэ гэдэг байв. Цаг хугацааны голч дахь Април хэмээх дөрөвдүгээр сар нь үнэхээр Дээгүүр өнгөрөх баярын долоо хоногийн үеэр таарсныг бид мэднэ.



ханан хашаатай эсвэл шохойн чулуун агуй байсан юм.⁵ Малын дундах Христийн төрөлт нь малын хашаа, агуй эсвэл толгой хоргодох газар ч байна уу ялгаагүй, энэ нь хүн ихтэй дэн буудлаас нэг илт давуу талтай байсан нь юу вэ гэвэл, тэнд амар амгалан мөн тав тухтай, дажгүй байлаа. Үүнээс харвал малын хашааг санал болгосон нь адислал байж, хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн ариун төрөлт нь хүнгүй зэлүүд газар тохиожээ.

Олзлогдогсдод эрх чөлөө

Анхны Христийн мэндэлсний баяраас долоон зуун жилийн өмнө бошиглогч Исаиа, хожим нь Аврагч назарчуудад уншиж өгсөн Мессиагийн тухай дараах бошиглолыг бичсэн ажээ: “Эзэн Бурханы Сүнс миний дээр байна. Учир нь Эзэн Намайг зовогсдод сайн мэдээг дэлгэрүүлэхийн тулд томилсон юм. Тэр намайг шаналсан зүрхтэй хүмүүсийг эдгээн, олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хүдээстэй хүмүүсийг чөлөөлөхийн тулд илгээсэн юм” (Исаиа 61:1; Лук 4:18-19-р шүлгүүдийг үзнэ үү).

Бид олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хоригдлуудад шоронг онгойлгож өгөх Христийн номлолын тухай уншихдаа сүнсний ертөнц дэх нас барагсдын дундах Түүний үйлчлэлийг эхлээд бодох ёстой байх. *Гэвч бид бүгдээрээ олзлогдогчид мөнх бус бие махбодын ялзрал болон сул дорой байдлын боолчлол мөн сул дорой байдалд махан биеийн уруу таталтуудад өртөж, эцэст нь үхдэг билээ, тиймээс бид бүгд чөлөөлөгдөх хэрэгтэй.*

Биднийг нүгэл, нөхцөл байдал эсвэл өнгөрсөн үйл явдлууд гээд юу ч хүлсэн бай, Их Эзэн, Агуу Иммануел биднийг чөлөөлөхөөр ирсэн юм. Тэрээр олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хэнэггүй байдал, бардамнал, алдаа дутагдал, нүглийн шорон хийгээд үхлийн хүлээснээс чөлөөлсөн билээ. Хоригдлуудад “Гарагтун” (Исаиа 49:9) гэж хэлсэн Түүний үг бошиглогдсон юм. Бид эрх чөлөөтэй болох цорын ганц нөхцөл нь Түүний хүслийг биелүүлэхийг хичээн, наманчилж; харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр Түүнд ирэх юм.

Би бараг 30 жилийн өмнө танилцсан нэг эрэгтэйг Томас гэе. Намайг түүнтэй танилцах үед тэр 45-тай байсан юм. 20 жилийн өмнө эцэг эх нь сүмд нэгдсэн ажээ. Эцэг эхийнхээ шинэ сүмийг Томас огт сонирхдоггүй байв. Гэхдээ эцэг эх нь түүнийг хайрлаж, хэзээ нэгэн өдөр хүү нь сэргээгдсэн сайн мэдээний үнэнийг мэдэх болно гэсэн найдварыг сэтгэлдээ тээж явжээ. Цаг

хугацаа өнгөрсөөр тэд хүүгээ ядаж номлогчидтой уулзаж, захиасыг нь сонсохыг олон удаа ятгав. Хүү нь удаа дараа эсэргүүцсэнээр барахгүй, эцэг эхийнхээ сүсэг бишрэлээр доог тохуу хийдэг байлаа.

Нэгэн өдөр цөхрөнгөө барсан ээж нь “Томас, хэрвээ чи номлогчдын ярилцлагыг ганцхан л удаа авчихвал би чамд сүмийн тухай дахин хэзээ ч ярихгүй” гэжээ. Томаст энэ нь сайхан тохиролцоо байсан учраас тэр номлогчидтой уулзахыг зөвшөөрөв. Эхний гурван ярилцлагын үеэр тэрээр тун ч ихэмсэг байдалтай сууж, заримдаа хичээл зааж буй ахлагчдаар тоглоом наргиа хийдэг байлаа.

Дөрөв дэх ярилцлагын үеэр Есүс Христийн цагаатгал болон сайн мэдээний анхдагч зарчмуудын талаар заах үед Томас ер бусын дөлгөөн болж, анхааралтай сонсов. Ахлагчид хичээлийн төгсгөлд Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцлаа. Тэгэхэд номлогчдын нэг нь Библээ гарган, доорх үгсийг уншихад сүнслэгээр өдөөгдсөнөө мэдэрсэн ажээ:

“Эцэг туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно” (Матай 11:28–29).

Томасын нүднээс гэнэт нулимс урсаж эхэллээ. “Та нар Христ *миний* нүглийг уучилж чадна гэх гээд байна уу?” гэж тэр асуулаа. “Миний амьдрал аймшигтай муухай байсан. Би олон гэм нүглээ санахаар сэтгэл шархиран өвддөг. Би гэм буруугийнхаа мэдрэмжээс салахын тулд юуг ч болов хийхэд бэлэн байна” гэлээ.

Түүний бардамнал гэм нүгэлд боолчлогдсон сэтгэлийн зовлонгоо нуусан халхавч байжээ. Хэрэв Томас наманчилж, баптисм хүртэн, гишүүнээр батлуулбал Христ түүнийг гэм буруугийн мэдрэмжээс нь чөлөөлж, уучлах болно гэдгийг ахлагчид түүнд итгүүлжээ. Дараа нь тэд Цагаатгалын хүчний талаар гэрчлэлээ хуваалцлаа. Тэр мөчөөс эхлэн Томасын амьдралд бүх зүйл өөрчлөгдөв. Түүнд даван туулж, наманчлах зүйл их байсан ч Их Эзэний адислалаар дамжуулан, баптисм хүртэх боломжтой болсон юм.

20 гаруй жилийн дараа намайг Германы Франкфуртын ариун сүмийн өрөөнд сууж байхад миний өмнө сууж байсан буурал үстэй нэгэн эрэгтэй арагшаа эргээд “Та Ахлагч Портэр биш биз?” гэх нь тэр. Би агуу баяр хөөртэйгөөр, Есүс Христийн хүчээр гэм нүглийн хүлээснээсээ чөлөөлөгдөж, Их Эзэний сүмд одоог хүртэл итгэлтэй хэвээр байгаа нөгөөх эр Томасыг танилаа.



Христийн мэндэлсний энэ удаагийн баярын үеэр бид Тэнгэр дэх Эцэгтээ даруухнаар залбиран, бидний өдөр тутмын амьдралд Түүний Хайрт Хүүгийн хүч бидэнтэй хамт байж; их, бага аль ч бай биднийг боолчлолоос чөлөөлөхийн тулд Түүнээс гуйцгаая.

Ай, Ариун шөнө

Би 1987 онд Христийн мэндэлсний баяраас хоёр долоо хоног орчмын өмнө Израил руу ажлаар явав. Харамсалтай нь, тэр үед Ариун нутагт энх тайван цаг байгаагүй юм. Баруун Эрэгт эсэргүүцлийн жагсаал болж, хуучин Иерусалимын гудамжууд эзгүйрэн, дэлгүүрүүд хаагдсан байлаа. Улс төрийн хурцадмал байдал газар авснаас асуудал улам дордон, долоо хоногийн ихэнх өдрүүдэд хүйтэн бороо шивэрч байлаа. Хүчирхийлээс айж болгоомжилсон жуулчид энэ бүс нутагт ирэхээ больжээ. Гэсэн ч намайг Иерусалимаар явж байх үед энэ бол Гэтэлгэгчийн маш ихээр хайрладаг байсан хот гэдгийг мэдсэнээс зүрх сэтгэл минь амар амгалангаар дүүрэв.

Би Христийн мэндэлсний баярын өмнөх тав дахь өдрийн орой Нэгдсэн Улсад эргэж ирлээ. Хоёр хоногийн дараа хүндэтгэлийн өдрийн өглөө сэрүүлэгтэй цаг намайг “Ай, ариун шөнө” дуугаар сэрээв.

Бидний бүхий л зовлон зүдгүүрт найз маань байхаар мэндэлсэн, Хаадын Хаан тийнхүү тэжээлийн тэвшинд хэвтэнэ.⁶

Христийн мэндэлсний энэ удаагийн баярын үеэр бид Тэнгэр дэх Эцэгтээ даруухнаар залбиран, бидний өдөр тутмын амьдралд Түүний Хайрт Хүүгийн хүч бидэнтэй хамт байж; их, бага аль ч бай биднийг боолчлолоос чөлөөлөхийн тулд Түүнээс гуйцгаая.

“Ай, ариун шөнө” дууны хөгжим болон захиас нь миний сэтгэлийг догдуулж, буурай нэгний найз, дорой нэгний найдвар болохоор мэндэлсэн Израилын Цагаатгагч—Түүний амьдрал ба алдар суут золиослолыг тунгаан бодох зуур нүдийг минь нулимс бүрхлээ. Иерусалим дахь туршлагаа эргэн бодоход бид бүгдийн ачааг Өөр дээрээ авахаар дэлхийд ирсэн Түүнийг хайрлах хайраар бие сэтгэл минь бялхаж байв. Тэр намайг найзаа хэмээн үздэг гэж бодоход сэтгэл ихэд догдолж байлаа. Би тэр ням гарагийн өглөө өөрийн хүлээж авсан төгс гэрч болох хайрын торгон мэдрэмжийг хэзээ ч мартажгүй.

Би Дэлхийн Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцья. Тэр амьдыг би мэднэ. Тэрбээр олзлогдосдоод эрх чөлөөг тунхаглахаар дэлхийн бүтээлтээс өмнө урьдчилан томилогдсоныг би мэднэ. Би Түүний төрөлт болон амьдралын тухай “Ай, ирцгээ, түүнийг шүтэн биширцгээе” хэмээн гэрчилж байна.⁷ ■

2008 оны 12-р сарын 9, Бригам Янгийн Их Сургууль дахь онцгой цугларалт дээр хэлсэн үг, “A Child Is Born” англи хэл дээрх бүрэн эхнийг speeches.byu.edu-аас үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. *The Messiah*, хянан тохиолдуулсан, Т.Тэртиус Нобель (1912), vi.
2. Судруудын удирдамж, “Бетлехем,” scriptures.lds.org-ийг үзнэ үү.
3. “Мөнхийн Эцэг, Бурхан минь,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 18-р хуудас.
4. Bible Dictionary, “Feasts”-ийг үзнэ үү.
5. Рассэл М.Нэлсон, “Аврагч амьд гэдгийг мэдсэнээс ирдэг амар амгалан ба баяр баясал,” *Лиакхона*, 2011 оны 12-р сар, 21-р хуудас.
6. “Cantique de Noël” (“Ай, ариун шөнө”), *Recreational Songs* (1949), 143-р хуудас.
7. “Ирцгээ, ирцгээ, гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 2-р хуудас.

ИНДЕКСЖҮҮЛЭХ НЬ МАШ ЧУХАЛ

Индексжүүлэх нь илүү олон бүртгэлийг онлайнаар ашиглан, улмаар гишүүд гэр бүлийнхнийхээ нэрсийг олж, ариун сүм рүү авч явах боломжтой болгодог.

Жэннифэр Грэйс Жонс

Сүмийн сэтгүүлч

Компьютерын гар дээр “Энэ компьютерийг Самуэл өглөөний 5:00 цагт захиалсан” гэсэн жижиг зурвас байв. Гадасны ерөнхийлөгчийн гадсандаа нэг сая нэр индексжүүлэх уриалгын хариуд Ютагийн 14 настай Самуэл Б. өглөөний 5:00 цагт босдог болсноор хичээлээсээ өмнө индексжүүлэх боломжтой болсон аж. Гэртээ нэг компьютертой мөн гэрийн даалгавраа хийх зургаан ах дүү байдаг учир Самуэл компьютер ашиглахын тулд нойроо золиослох хэрэгтэй болжээ.

Гэвч Самуэлийн идэвх зориг гэр бүлийнх нь үлдсэн гишүүдэд “тархав.” Удалгүй ах Нэтэн нь сагс тоглох, эмэгтэй дүү Айвилин нь ном унших цагаа индексжүүлэхэд зориуллаа. Самуэлийн аав “Би хүүхдүүдээсээ хэзээ ч ийм их урам дэмийг хүлээн авч байсангүй. Тэднийг индексжүүлэхэд оролцож эхлэхээс өмнө би үүнийг их хэцүү ажил гэж бодож байлаа. Хүүхдүүд маань надад индексжүүлэх нь хялбар бөгөөд хөгжилтэй болохыг заасан юм” гэжээ. Дараагийн шинэ жилийн өмнөх үдэш хүүхдүүд нь шөнө болохоос өмнө индексжүүлэх жилийн зорилгоо дуусгахаар яарцгаав.

Олон мянган километрийн чанад дахь Гватемала дахь Ланузагийн гэр бүлд мөн ийм идэвх зориг өрнөжээ. Таван хүүхэд, ээж, аав, эмээ, өвөө гээд энэ гэр бүлийн есөн хүн дундаа нэг компьютертой ажээ. Хүүхдүүд нь компьютер дээр гэрийн даалгавраа хийж, ээж нь их сургууль дахь хичээлээ дуусгах гэж шамдан, аав нь ажлаа хийх ба компьютер байнга өндөр ачаалалтай байдаг бөгөөд гэр бүлийн гишүүн бүр индексжүүлэхээр ээлжлэн суудаг байв. 2011 онд эднийхэн хамтдаа 37,000 гаруй бүртгэл индексжүүлжээ.

Эдгээр хүүхдүүд болон тэдний гэр бүлийнхэн 2011 оны 10-р сард сүмийн өсвөр үеийнхэнд Арванхоёр

Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын өгсөн урилгыг биелүүлсэн юм.

Та нарын ихэнх нь гэр бүлийн түүхийн ажлыг насанд хүрсэн хүмүүс л хийх ёстой гэж боддог байж магадгүй. Гэхдээ судар болон сүмийн удирдагчдын заавруудад энэ чухал үйлчлэлийг зөвхөн насанд хүрэгчид хийх ёстой гэж заасан байхыг би үзээгүй. . . .

“Елиагийн Сүнсний талаар сурч, үүнийг мэдрэхийг сүмийн залуучуудаас би хүсч байна.”¹

Гэр бүлийн түүхийг хурдан бөгөөд хялбар хийх нь

Индексжүүлэх нь хүн бүрийн хувьд гэр бүлийн түүхийг эхлэх болон Елиагийн Сүнсийг мэдрэх хялбар арга юм. Засгийн газар болон сүмүүд олон зууны турш хүмүүс ба гэр бүлүүдийн бүртгэлийг хадгалж ирсэн, гэвч эдгээр бүртгэлүүд нь ашиглахад хэцүү, хайлт хийхэд цаг их зарцуулдаг байна. Саяхан өвөг дээдсийнхээ нутгаас алс хол амьдардаг хүмүүс ядаж нэг ч гэсэн гэр бүлийн нэр олно гэсэн баталгаагүйгээр тэдгээр газрууд руу очиж, бүртгэлүүдийг хайдаг байлаа.

2006 оны FamilySearch индексжүүлэлтийн удиртгал нь гэр бүлийн түүхийн хайлтын ажлыг эрчимжүүлсэн юм. Гараар бичсэн бүртгэл болон агуулахад хадгалагдсан нэрсүүдийг одоо хуулан бичиж (индексжүүлж), компьютероос түргэн шуурхай хайж олох боломжтой болсон. Үүнийг хийж гүйцээхийн тулд сайн дурын индексжүүлэгчид гэрийнхээ компьютер дээр 10-50 нэр багтаасан “багц” бүртгэлүүдийг татаж оруулна. Тэд нэр, огноо болон бусад мэдээллийг FamilySearch-ийн мэдээллийн санд оруулснаар хайх боломжтой цахим индексийг үүсгэдэг.

FamilySearch индексжүүлэлт хэрэгжиж эхлэхээс өмнө нэрс гарган авах техникийг ашиглан, зөвхөн ганцхан багц бүртгэлээс хайх боломжтой индексийг бий

болгоход л хэдэн жил зарцуудаг байв. FamilySearch-ийн индексжүүлэлтийг хариуцсан менежер Майкл Жадсон чөлөөлөгдсөн хүмүүсийн банкны бүртгэлүүдийг (Нэгдсэн Улсын банкинд данс нээлгэсэн, чөлөөлөгдсөн боолуудын бүртгэлүүд) индексжүүлэхэд 11 жил болсон гэж хэллээ. Харин одоо тэр үүнд хэдхэн сар л шаардагдана гэж үзэж байна.

Дэлхий даяарх сайн дурынхан 2006 оноос хойш нэг тэрбум гаруй нэрийг индексжүүлсэн ч дахиад хийх ажил маш их байна. Дахиад хэдэн тэрбум бүртгэл Ютагийн Солт Лэйк хотын Боржин уулын бүртгэл хадгалах агуулахад индексжүүлэхээр хүлээгдэж байна. Үүнээс гадна дэлхий даяарх архивуудад бусад бүртгэлүүд байгаа бөгөөд Гэр бүлийн түүхийн алба сар тутам 35 сая орчим зураг авч байна.

Тодорхой нөхцөл байдал, онцгой адислалууд

Тэргүүн Зөвлөл “Гишүүдийг гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажилд маш чухал зүйл болох FamilySearch индексжүүлэлтэд оролцоход уриалж байна” хэмээн мэдэгджээ.² Дэлхийн даяарх гишүүд энэхүү зөвлөмжид хариулснаар гайхалтай адислалуудыг хүлээн авч байна.



Украин дахь гэгээнтнүүд Зүүн Европ дахь гэр бүлийн түүхийн хайлтын ажилд дөхөм үзүүлэх цахим индексүүд үүсгэхээр шаргуу ажиллаж байна. Киев дэх Рүдэнкогийн гэр бүл онцгой жишээ үзүүлж байгаа аж. Тэд хүүхдүүдийнхээ хамт интернетийн төлбөр төлж, золиослол хийснээр нэрсийг индексжүүлэх боломжтой болжээ. Рүдэнко эгч гэрийнхээ зөөврийн компьютерыг гал тогооньхоо ширээн дээр тавьсан гэнэ. Тэгснээрээ тэр өдрийн чөлөөт цагаараа индексжүүлэх ажлыг хийх боломжтой байдаг. Тэр бяцхан хүүхдээ нэг гартаа тэврэн, нөгөө гараараа компьютер дээр бичдэг байна. Тэдний 16-тай хүү, 12-той охин хоёр нь мөн байнга индексжүүлэлт хийдэг болжээ. Тэд бас заримдаа гэр бүлээрээ улсын архив орж, гэр бүлийн нэрсээ хайдаг. Рүдэнкогийн гэр бүл ариун сүмд нэрс тогтмол илгээн, тэдгээр нэрсээр ёслолуудыг нь гүйцэтгэдэг бөгөөд заримдаа долоо хоногт бүр хэд хэдэн удаа ариун сүмд очдог аж.

Рүдэнко эгч гэр бүлийн түүхийн ажлаар дамжуулан, хүлээн авсан адислалуудынхаа тухай “Индексжүүлэлт болон гэр бүлийн түүхийн ажил нь биднийг хамгаалдаг гэдэгт би итгэдэг. Миний патриархын адислалд энэ ажлыг хийснээр би хүүхдүүдийнхээ хамт хамгаалагдана хэмээн надад амласан. Хүүхдүүдийн минь оюун санаа цэвэр байж, энэ дэлхийн муу нөлөөнүүдийг даван туулах

боломжтой байх болно. . . [Хүүхдүүд маань] энэхүү ажлаас Бурханы хүчийг хүлээн авах болно” гэжээ.

Индексжүүлэх нь ур чадвар эсвэл нөхцөл байдлаас үл хамааран, үйлчлэх боломж олгодгийг олон гишүүд мэддэг болж байна. АНУ-ын Юта дахь Малинда Пэрри 24 настайдаа машины осолд орж, хүзүүнээсээ доош мэдээ алджээ. Пэрри эгч амьдралын шинэ хэв маягт дасахдаа үйлчилж болох арга замын талаар залбирчээ. Гадасны Нийгмийн Халамжийн ерөнхийлөгчийн зөвлөлийн Рэйлин Андэрсон тэднийд ирж, түүнд хэрхэн индексжүүлэхийг зааснаар тэр залбирлын хариугаа авсан гэнэ. Пэрри эгч одоо өдөр бүр компьютерын ард хэдэн цаг суудаг бөгөөд гартаа савх барин, дөнгөж шивж чаддаг болжээ. Тэр өдөр бүр нэг багц нэрс индексжүүлдэг.

Пэрри эгч “Би өөртөө анхаарал тавьдаг байсныхаа оронд одоо анхаарлаа бусдад үйлчлэхэд хандуулсан. Би Их Эзэнд хайртай бас индексжүүлэлтээр дамжуулан, Түүний адислалуудыг бусдад хүргэхдээ ч дуртай” гэж ярилаа.

Английн Чорли дахь гадасны ерөнхийлөгч Дэвид Пикап гэр бүлийн түүхийн танилцуулгыг сонсоод, индексжүүлэх нь гадасныхаа гишүүдийн ариун сүмд шүтэн бишрэх хүслийг нэмэгдүүлэх болно гэдгийг мэдэрчээ. Гэвч тэр нийтлэг нэг өгөгдөл оруулах нь хүмүүсийг ариун сүм рүү хэрхэн хөтлөх билээ? хэмээн гайхсан гэнэ.



Тэр өөрөө индексжүүлэхийг хичээхээр шийдсэн нь түүний амьдралд Елиагийн Сүнсийг илүү ихээр мэд- рүүлжээ. Түүний хувьд индексжүүлэх нь “цэвэршүүлэх” ажил болов. “Та зөвхөн индексжүүлж буй нэрсээ бус харин өөрийнхөө гэр бүлийн нэрсийг бодохгүйгээр индексжүүлэх ажлыг хийж чадахгүй” гэж тэр хэлжээ.

Ерөнхийлөгч Пикап гадасныхаа гишүүдэд гэр бүлийн түүхийн ажилд оролцох арга болгож, индексжүүлэлтийг ашиглахыг уриалжээ. Тэрээр гадасныхаа бусад удир- дагчдын хамт богино хугацааны дотор ариун сүмийн эрхийн бичиг авахуйц зохистой байхад мөн ариун ёслолын цуглааны ирцэд бодит өсөлт гарч эхэлснийг ажигласан байна. Индексжүүлэхэд оролцсон гишүүд гэр бүлийнхээ нэрсийг ариун сүмд аваачих хүсэл нь нэмэг- дэж байгааг тэд ажиглав.

17 настай Мэкэнзи Х. ерөнхийлөгч Пикапын уриалгыг чин сэтгэлээсээ хүлээн авч, индексжүүлж эхлэн, эгч дүүс, эцэг эх болон эмээ өвөөдөө бас оролцоход нь тусалжээ. Мэкэнзи 2 жил хүрэхгүй хугацаанд 44 000 гаруй нэр индексжүүлсэн байна. Хамгийн чухал нь, Мэкэнзи болон түүний гэр бүлийнхэн нь өөрийнхөө гэр бүлийн нэр- сийг хайж, тэднийг ариун сүмд аваачин, авралын ёсло- луудад оролцохоор сүнслэгээр нөлөөлөгдсөн явдал юм.

Индексжүүлэлт нь Чорли гадасны гишүүдэд амьд- ралдаа Сүнсийг илүү их мэдэрч, гэр бүлийнхээ нэрсийг ариун сүмд аваачихад шаардлагатай тоног төхөөрөмж- тэй болоход тусалсан. Ерөнхийлөгч Пикап “Та индекс- жүүлэхийн тулд ариун сүмд орохоор зохистой байх шаардлагагүй, гэвч индексжүүлж эхлэхэд энэ нь таныг ариусгаж, та ариун сүмд орохоор зохистой байхыг хүсэх болно. Мөн та ариун сүмд очиж, өвөг дээдсийн- хээ төлөөх ажлыг хийхийг хүсэх болно. . . . Би үүнийг мэднэ, учир нь энэ нь надад тохиолдсон юм” гэж ярилаа.

Индексжүүлэх нь хүн бүрд тусалдаг

Их Эзэн “Болгоогтун, бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” (С ба Г 88:73) хэмээн ам- ласан билээ. Индексжүүлэлт нь Их Эзэн энэ амлалтаа биелүүлж байгаа нэг арга зам юм. Индексжүүлэх нь хүн бүрд гэр бүлийн түүхийн хайлтыг хялбарчилж, хурдас- гадаг бөгөөд энэ нь тэдэнд болон бусдад өвөг дээдсээ олох боломж олгодог. “Их Эзэн нэрс олж тогтоох агуу боломж олгогч технологийг бидэнд өгсөн.” “Та одоо зөвхөн өөрийн гэр бүлийн түүх дээр ажиллаж байгаа бус, индексжүүлэх нь Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүү- дэд туслах хамтын хичээл зүтгэл юм” хэмээн Жадсон ах хэллээ. ■

ЗҮГЭЭР НЭГ ӨГӨГДӨЛ ОРУУЛАХААС ИЛҮҮ ЧУХАЛ АЖИЛ

Эхэндээ индексжүүлэх нь иргэний өгөгдөл оруулах- тай төстэй харагдаж магадгүй, гэвч туршлагатай индексжүүлэгчид ихэнхдээ индексжүүлэлтийг хөшиг- ний хоёр талд буй амьдралыг адислах сүнслэг эрэл хайгуул хэмээн гэрчилдэг.

Доорх зөвлөмжүүд нь индексжүүлэлтийг сүнслэгээр биелүүлэх туршлага болоход тусална:


1. Залбирлаар эхэлнэ үү. Та Елиагийн сүнсийг мэд- рэхээр тодорхой залбирч болно, тэгснээр таны зүрх сэтгэл өвөг дээдэс рүү тань эргэх болно.
2. Анхаарал сарниулах болон Сүнсээс холдуулах зүйлс зурагт, хөгжим зэргээ унтраана уу.
3. Гэр бүл эсвэл найзуудтайгаа хамт индексжүү- лэлт хийнэ үү. Энэ нь хэцүү гар бичмэлүүдийг уншихад тань туслахаас гадна танд өөрийнхөө гэр бүлийн түүхийн талаар ярилцах үүд хаалгыг нээж өгнө.
4. Таны индексжүүлж байгаа нэр бүр нь амьд үр удамтай бөгөөд ариун сүмд төлөөлөн хийх ёс- лолуудыг хүлээн авах боломжтой хүмүүс гэдгийг санагтун.
5. Их Эзэн таныг адисална гэдгийг санагтун. Та индексжүүлэх ажил хийх үед тулгарах аливаа бэрхшээлийг Аврагчаар дамжуулан даван туулж чадна (2 Коринт 12:9-10-р шүлгүүдийг үзнэ үү).

Индексжүүлэлтийг англи, герман, испани, итали, нидерланд, орос, польш, португаль, франц, швед, япон хэлээр хийх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээл- лийг familysearch.org/indexing-аас үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Дэвид А.Бэднар, “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 28-р хуудас.
2. Тэргүүн Зөвлөлийн захидал, 2012 оны 2-р сарын 29.

Ютагийн Солт Лэйк хот дахь ариун сүмийн талбайн Табернеклд Юнис Кэннеди Шривэрийн Халамжийн Нийгэмлэгийн Үндэсний Төвийн гүйцэтгэх захирал Дэвид Р.Паркэр "Let There Be Peace on Earth (Дэлхий дээр энх амгалан байг)" дууллыг үзэгчид дуулах үеэр дохионы хэлийг ашиглажээ. 2012 оны 2-р сард болсон энэхүү үйл ажиллагаа Солт Лэйкийн шашин хоорондын дугуй ширээний ярилцлагын удирдлаган дор явагджээ.



Бусад сүмүүдтэй хамтран ажиллахад оролцох замаар

УЛАМ САЙН ГЭГЭЭНТЭН БОЛОХ НЬ

Бид бусад сүмийн хүмүүстэй хамтран үйлчилснээр зөвхөн эв нэгдлийг бий болгож, тэдэнтэй харилцаагаа сайжруулаад зогсохгүй бас улам сайн шавь нар болдог.

Бэтси Вандэнбэрг

Сүмийн удирдагчид гишүүдийг шударга хүмүүстэй тэдний шашин шүтлэгийг үл харгалзан, үйлчлэл болон ёс суртахууны асуудалтай холбоотой зүйлсэд хамтран оролцохыг байнга урьдаг билээ. Мөн сүмийн удирдагчид ихэвчлэн өөрсдөө үлгэр жишээ болдог. Саяхан ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф эхнэр Харриэтын хамт Католик Шашны Нийгмийн Үйлчлэл байгууллагын “Оны Энэрэнгүй Үйлсэн” шагналыг хүртсэн билээ. Тэрээр “өмнө нь Лютерийн шүтлэгтэй байсан хоёр герман хүн эдүгээ бат итгэлтэй мормончууд болж, Америкийн Нэгдсэн Улс дахь католикчууд тэдэнд хүндэтгэл үзүүлснийг” хошигнон, тэмдэглэжээ.¹

Дэлхий даяарх гишүүд бусад байгууллагуудтай мөр зэрэгцэн үйлчлэх урилгыг сайшаан дэмжиж, хариулсан юм. ХҮГ тойргууд нийтийн эзэмшлийн цэцэрлэгүүдийг байгуулан, ёс суртахууны эрхэмлэх зүйлсийн талаар бусад сүмүүдтэй хамтран хурал чуулган зохион байгуулж, олон нийтийг хамарсан цэвэрлэгээ хийдэг тухай түүхүүдийг сонсоод миний сэтгэл их хөдөлдөг.

Бусад сүмүүдийн хүмүүстэй хамтран үйлчлэх тухайд, Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Квинтин А.Күкийн “Өөр сүмийн хүмүүстэй хамтран хүндэтгэлтэй, чин сэтгэлийн үйлчлэл хийх нь бидний эв нэгдлийг хөгжүүлээд зогсохгүй бас бидэнд хамтдаа болон хувиараа Бурхан ба Түүний хүүхдүүдийг хайрлах хайрыг өсгөн нэмэгдүүлэх боломжийг олгодог” гэсэн урам хайрласан үгс үнэн гэдгийг би мэдсэн билээ.²



Холладэй дэх үйл явдал (АНУ, Юта, Холладэйд) нь хөршүүдийн төсөл болон үйл ажиллагаанд бүх шашны болон шашингүй хүмүүсийг урихаар зохион байгуулагджээ. Зураг дээр уг байгууллагыг үндэслэгч гишүүд ба өөр өөр шашны эмэгтэйчүүд.

Дэлхийг сайжруулах нь

Хэдэн жилийн өмнө Пресбитериан шашны нэг үйлчлэгч манай бүсэд нүүж ирсэн юм. Тэр зөвхөн өөрийнхөө сүмийнхэнд төдийгүй бүх хөршүүддээ туслахыг хүсдэг байв. Тэр эмэгтэй ихэнх нь ХҮТ гэр бүлүүдээс бүрддэг манай хөршүүдэд нөхөрсгөөр хандаж, хөршүүддээ урилга болон тусламж хүргэхэд тойргийн гишүүд түүний сүмийн үйлчлэлийн төслүүдэд оролцдог болсон байна. Тэр эмэгтэй болон өөр шашин шүтлэгтэй хөршүүд нь хандив цуглуулж, эмчилгээний зардлаа яаралтай төлөх шаардлагатай болсон ХҮТ нэг гэр бүлд тусалжээ.

Төлөөлөгч Оорсон Ф.Витни (1855–1931) “Бурхан өөрийн агуу хийгээд гайхамшигт ажлыг гүйцэлдүүлэхийн тулд зөвхөн нэг бүлэг хүмүүсийг биш харин илүү олон бүлгүүдийг ашигладаг. . . . Энэ нь ганц хүнээс хэтэрхий ахадсан, хүнд ажил юм” хэмээн хэлжээ.⁵ Сайн хүмүүс хүч чармайлтаа нэгтгэсэн үед агуу зүйлс гүйцэлдэх боломжтой юм. Манай хөрш үйлчлэгчийн хичээл зүтгэл, манай гадасны Нийгмийн Халамжийн бүлгийг бусад сүмүүдтэй холбоо байгуулан, дүрвэгчдийн байгууллагуудыг ариун цэврийн иж бүрдэл болон номоор хангах асуудлаар эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулахад хүргэсэн юм. Шашин хоорондын эдгээр хэлхээ холбоо дүрвэгчдийн томоохон бүлгийг хоолоход өөр нэг сүмийнхэнд туслахын зэрэгцээ орон гэргүй нэг хүнийг орон байртай болгоход нэмэлт сайн дурынхан хэрэгтэй болсон өөр нэг сүмд туслах боломжийг гадасны гишүүдэд олгосон ажээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид бусад сүм болон байгууллагуудтай хамтран ажиллах . . . үүрэгтэй” гэж гишүүдэд хандан хэлсэн⁴ бөгөөд түүний энэ үг дэлхийг хүмүүнлэгийн үйлчлэлээр чамгүй адисалсан билээ. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р. Холланд Нэгдсэн Улс дахь Христийн шашны удирдагчдад хандаж үг хэлэхдээ Бригам Янгийн Их Сургууль дээр болсон ХҮТ гишүүд болон Эвангелист Христийн



2011 оны 12-р сард, Нью Жерси дэх Цэвэр ариун үр хөврөлийн Католик Сүмийн хүүхдүүд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хүүхдүүдтэй хамт Христийн мэндэлсний баярын хөтөлбөр үзүүлж байна. Буяны хандивын тоглолтын орлогоор орон нутгийн хүнсний агуулахад хүнс цуглуулахад тусалсан ажээ.

шашинтны хамтарсан цуврал ярилцлагуудыг тайлбарлажээ.⁵ Эдгээр чуулгануудын нэг үр дүн нь олны танил нэгэн шашны удирдагч өөрийнх нь сүмийн зарим хүмүүс Мормоны шашны тухай буруугаар тайлбарладаг байсны төлөө ХҮТ Сүмээс уучлал гуйсан явдал юм.⁶ Ийм хэлхээ холбоо бий болгох талаар ахлагч Холланд “Би тусалж чадахгүй ч өнөөгийн хүнд бэрх цагт энэ нь үйл ажиллагаануудын тэнгэрлэг бүтцийн хэсэг байхад итгэдэг” гэж хэлжээ.⁷

Харилцаагаа сайжруулах нь

Бид бусадтай хамтран үйлчлэхдээ бидний харилцааг илүү утга учиртай болгож, бусдыг гомдоохоос зайлсхийхэд тодорхой удирдамжууд бидэнд тусалж чадна. Би урьд нь нэгэн том хотод амьдарч байсан бөгөөд орон нутгийн сүмийн олон нийтэд нээлттэй багшлах хөтөлбөрт сайн дураараа бүртгүүлэв. Энэ нь тус хөтөлбөрийг хариуцсан хүн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд миний гишүүн байгаа нь уг хөтөлбөрт багшлахад тохирохгүй гэж үзсэнийг мэдэх л гэсэн байжээ. Тэр явдал хэн нэгний хувь нэмрийг ямар шашин шүтдэгийг нь (эсвэл шашин шүтдэггүйг)



үл харгалзан, үнэлдэг байхад намайг итгүүлсэн. Сүмийн тухай мэдэх гэсэн хэний ч бай сонирхлыг би талархан хүлээж авахын сацуу хожмын үеийн гэгээнтнүүд бид тусламж хүлээн авагч болон бидэнтэй хамт үйлчилдэг хүмүүсийг сүмд хөрвөхийг нь хүсэн хүлээлгүйгээр хөршөө хайрлаж, нүцгэнийг хувцаслан, өлссөнийг хооллож, хоригдсоныг эргэж оч гэсэн Есүсийн тушаалд нухацтай ханддагийг би бас мэднэ (Матай 25:34–36-р шүлгүүдийг үзнэ үү). Шашин хоорондын харилцаан дахь чин сэтгэлийн, хүндэтгэлтэй байдал нь аливаа бүлгээс, түүний дотор манай сүмээс, итгэлээ орхих буюу үгүйсгэхийг хэзээ ч шаардаггүй. Харин энэ нь оролцогчдыг “сүмийн эсрэг бүү тэмц” (С ба Г 18:20), “өөрсдийгөө энэрлийн холбоогоор хувцаслагтун” (С ба Г 88:125) хэмээн уриалдаг.

Өөр нэгэн ашиг тустай удирдамжийг ХҮТ-үүд зонхилдог нутгийн нэгэн гадасны ухаалаг удирдагч санал болгосон юм. Тэр бусад сүмийнхэнтэй хамт үйлчилдэг гишүүддээ шийдвэр гаргах болон удирдахад давамгайлахгүй харин зөвлөлдөж, “тэгш боломжтой байх” (С ба Г 88:122) боломжийг бүх хүмүүст олгож ажиллахыг

зөвлөжээ. Бусад сүмүүдтэй харилцах асар их туршлагатай энэ удирдагч түүнчлэн гишүүдээ сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд урамшуулан дэмжжээ. Хожмын үеийн гэгээнтнүүдтэй хамтарч ажилласан зарим хүмүүс тэднийг ажилч хичээнгүй, сайхан зантай хүмүүс гэдгийг мэддэг ч тэдэнтэй харилцаагаа хөгжүүлэхээсээ илүү ажлаа шалавхан дуусгах сонирхолтой байдгийг тэр олж мэдсэн.

Олон нийтийн болон боловсролын салбар дахь туршлага минь янз бүрийн хүмүүс зөв зорилгод нэгдсэн үед Сүнс хүчтэй байдгийг ойлгуулсан юм. Ах дүүсэг ёсны хайр, эрүүл саруул сэдэл нь ажилд дэмжлэг болохоосоо илүү бидний үйлчлэлд тусалдаг.⁸

Өөр сүмийн чуулган дээр үг хэлсэн нэгэн ХҮТ бусадтай хэлхээ холбоо бий болгох нь биднийг илүү сайн ойлгоход нь бусад сүмийн гишүүдэд тусалдгийг ажигласан байна.⁹ Өөр шашны нэг эрдэмтэн Америкийн нэгэн алдартай их сургуулийн семинарт Мормоны шашны тухай хичээл заадаг байв. “ХҮТ Сүм бол үндсэндээ . . . хэт туйлширсан, уламжлалт биш шашин гэдэгт итгэж өссөн ч Мормон найз нар болон хамт ажиллагсдынх нь зан байдал тэдний тухай хэвшмэл ойлголттой тохирдоггүй учраас” оюутнууд нь энэ сүмийн тухай мэдэхийг хүсдэгийг тэр багш олж мэджээ.¹⁰

СУРГААЛЫН ЗААЛТУУД

- Бурхан бүх шашны шударга хүмүүсийг дэлхий дэх Өөрийн ажилд ашигладаг.
- Зөв зорилгын төлөө бусад сүмүүдийн хүмүүстэй хамтран ажиллах нь бид өөрсдөө дангаараа хийж чадахаас илүү их сайн зүйлийг хийх боломжийг бидэнд олгодог.
- Шашин хоорондын хүндэтгэлтэй, нөхөрсөг харилцаа буруу ойлголтыг залруулж, ах дүүсэг ёсны мэдэрэмжийг бий болгон, биднийг Эцэгт маань илүү ойртуулдаг.

*2013 оны 3-р сард
Бразилын Сан Паулод
болсон олон шашны
чуулганд оролцогчид
шүтэн бишрэх эрх чөлөөг
хамгаалах тухай
ярилцжээ.*



Доор, зүүн талаас: 2010 оны 2-р сард Солт Лэйкийн Табернеклд болсон олон шашны хөгжмийн үйл ажиллагаанд Энэтхэгийн бүжигчид бүжиглэж байгаа нь. Үзэгчид тоглолтыг ихэд сонирхон үзжээ. Мормоны захиасуудын видео бичлэгт янз бүрийн шашны залуучууд бэлгийн харьцааны цэвэр ариун байдлын ач холбогдлын талаар ярилцав. АНУ-ын Техасын Хьюстонд болсон Олон шашны Энэрлийн Уран Зөгий жил тутмын үйл ажиллагаанд оролцогчид тусламж хэрэгтэй гэр бүлүүдэд зориулан, хөнжил хийжээ.

Өөрсдийгөө сайжруулах нь

Бусадтай хамт үйлчлэх нь биднийг ойлгоход тэдэнд туслаад зогсохгүй түүнчлэн тэднээс суралцаж, Бурхан “хүмүүсийг ялгаварлан нүүр тал харагч биш” (С ба Г 1:35) гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг. Тэрбээр бүх шашин болон соёлын сайн хүмүүст Түүний хүүхдүүдийн амьдралыг сайжруулах хүч чармайлт гаргахад нь тусалдаг билээ.

Ийнхүү бусад хүмүүсээс сайн зүйлсийг олж харах нь сүнслэг байдлын хувьд бардам зан гаргасных нь төлөө Есүсийн буруушаасан фарисайчууд (Матай 23-р бүлгийг үзнэ үү) эсвэл Мормоны Ном дахь зорамчуудын бусдыг хавчин гадуурхдаг дээрэнгүй занг дүрсэлсний (Алма 31-р бүлгийг үзнэ үү) эсрэгээр биднийг даруу байхад тусалдаг. Бусдад байгаа сайн зүйлийг мэдэж, түүнээс суралцах нь бидэнд илүү сайн хүмүүс болох боломжийг олгодог билээ.

Бид зөвхөн гэр бүлийнхээ гишүүд, найз нарыгаа төдийгүй, бүх хөршүүд, тэр ч бүү хэл дайснуудыг ч хайрлах ёстой. Дэлхийн II дайны дараахан Япон дахь Америкийн цэрэгт алба хааж байсан сүмийн нэг гишүүн япончуудыг үзэн ядах хорсолтойгоо хэрхэн тэмцсэн тухайгаа ярьжээ. Түүнийг япон тосгоны хүмүүсийн ариун дуганд урьж, элэгсэг дотноор хүлээн авснаас хойш тэрээр

“тэдний сүнс өөрт нь нөлөөлж, япончуудын талаарх үзэл бодолд нь гайхалтай өөрчлөлт гарсныг мэдэрсэн” байна. Үзэн ядалт нь арилж, алга болсон гэнэ. . . . Би тэр дуганд болсон явдал болон тэндхийн хүмүүсийн талаар мэдэрсэн гайхалтай өөрчлөлтийн тухай боддог болсон.”¹¹

Үүн лүгээ адил, бид өөрсдийнхөө дунд бусдыг чин сэтгэлээсээ урихад тэд ч бас өөрчлөлтийг мэдрэх болно. Бригам Янгийн Их Сургуулийг төгссөн нэгэн Протестант Христийн шашинтан ХҮТ оюутнуудаас өөрийгөө анх хэрхэн хамгаалж байсан тухайгаа тайлбарлаж, нэг өгүүлэл бичжээ. Гэвч эцэстээ утга учиртай нөхөрлөл бий болсны дараа тэр эмэгтэй талархан, “Хожмын үеийн гэгээнтнүүд даруу байдлаараа Бурханд ойр байдгийг би мэдэрсэн. Би Бурханы агуу мөн чанарыг оюун санаандаа хадгалах гэж хичээснээрээ Бурханыг өөртөө ойр байлгахыг үл ойшоож байснаа ойлгож эхэлсэн бөгөөд энэхүү ойлголт надад гүнзгий нөлөөлсөн юм” гэжээ.¹²

Ахлагч Холланд Христийн шашны удирдагчдад хандан хэлсэн үгэндээ “ямар нэг шинэ зүйлийг сурч мэдэхтэй холбоотой эрсдлийг хүлээн зөвшөөрч, шинэ ойлголт нь хуучин үзэл бодолд нөлөөлснөөр дэлхийг ойлгох бидний ойлголтыг шинэчлэн,





2012 оны 2-р сард Солт Лэйкийн Табернеклд үг хэлсэн Олон шашны дугуй ширээний ярилцлагын удирдагч Алан Бачман.



Хожмын Үеийн Гэгээнтэн гурван эмэгтэй АНУ-ын Вашингтон, Спокэйнд янз бүрийн соёл заншлын зоог буюу Итгэлийн найранд оролцож байгаа нь. Тэд мөн бусад оролцогчдын хамт орон нутгийн Лалын шашны хийд, Сих (Нэг Бурханд итгэдэг шашин) шүтээний дуган болон Пресбитериан сүмд айлчилжээ.

эрэмбэлж, шинэ байдлаар эргэцүүлэн бодоход зайлшгүй хүргэдэг” гэжээ.¹³ Би бусад сүмийн хүмүүстэй нөхөрлөхдөө ихэвчлэн тэдэнд байдаг аливаа ариун журамтай юм бүхэнд, тэдний санал болгодог сайн сайхан зүйлсэд талархахын зэрэгцээ бидний хоорондын болон сургаалын ялгаанаас соёл заншлын ялгаанд дүн шинжилгээ хийхийг олонтоо хичээдэг. Үнэндээ, хичээл зүтгэл нь заримдаа эрсдэлтэй мэт санагдавч ашиг тустай зүйл юм. Би юмсын учир начрыг ялгаж, салган авч үзэх явцдаа өөрийн соёлын чиг хандлагын зарим хэвшсэн зүйлийг орхин, сайн мэдээний мөн чанарт илүү ойр байх болсноо ухаарсан билээ.

ХҮТ-ийн нэлээд хэдэн бүлэг шашны ажилтан нэг найзыг минь “Шашны ялгааг үл харгалзан, хөршөө хайрлах нь” сэдвээр үг хэлэхэд урьсан бөгөөд ярилцлагад оролцсон олон хүн түүнийг хүлээн зөвшөөрсөн юм. Хариуд нь тэрээр намайг болон өөр хэдэн хожмын үеийн гэгээнтнүүдийг өөр шашны цуглаанууд дээр мөн дээрх сэдвээр ярихыг урив. Үүний дараа цуглаанд оролцогчид надтай ярилцахыг хүсч, намайг тэврэн, чин сэтгэлийн хайр болон харилцан ойлголцсондоо бүр нулимс дуслуулж байлаа. Би иймэрхүү туршлагаудаас ахлагч Холландын дараах дүгнэлт үнэн болохыг мэдсэн юм:

Бид хүмүүсийн арьс, өнгө, угсаатны болон нийгмийн бүлэг, сүм, синагог, лалын шашинтны сүм хийд, итгэл үнэмшил ба сүсэг бишрэлээс цаашлуулан харах үед,

мөн тэднийг чухам хэн болохыг буюу нэг Бурханы хүүхдүүд гэдгийг харахыг хичээснээр эрхэм болоод үнэ цэнэтэй зүйлс бидэнд тохиож, үүгээр бид бүгдийн Эцэг, Бурханд илүү ойртодог билээ.”¹⁴ ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, Маржори Кортээийн өгүүлэл, “Catholic Community Services honors Uchtdorfs, Eccles as humanitarians of the year,” 2012 оны 11-р сарын 7, deseretnews.com.
2. Квинтин А.Кук, “Partnering with Our Friends from Other Faiths,” 2010 оны 8-р сарын 9, patheos.com-ыг үзнэ үү.
3. Орсон Ф.Витни, Conference Report, 1928 оны 4-р сар, 59.
4. Томас С.Монсон, “The Mormon Ethic of Civility,” 2009 оны 10-р сарын 16, mormonnewsroom.org
5. Жэффри Р.Холланд, “Standing Together for the Cause of Christ,” *Лиахона*, 2012 оны 8-р сар, 24-26-р хуудсуудыг үзнэ үү.
6. Жозеф Вокэр, “Evangelical leader says LDS Church is not a cult,” 2011 оны 10-р сарын 10, deseretnews.com.
7. Жэффри Р.Холланд, “Standing Together,” *Лиахона*, 24.
8. Майкл А.Нийдар, “The Voice of the People,” *Ensign*, 2012 оны 10-р сар, 38-40-р хуудсуудыг үзнэ үү.
9. Блэйр Д.Хожэс, “Mormons, Methodists meet to consider similarities, compare cultures, theology, music,” 2012 оны 2-р сарын 25, deseretnews.com-ыг үзнэ үү.
10. Жозеф Вокэр, “University of Virginia Chair in Mormon studies named for Richard L. Bushman,” 2012 оны 10-р сарын 12, deseretnews.com.
11. Фэррон А.Олсон, “Forgiveness at Wakayama,” *Ensign*, 2011 оны 12-р сар, 57-р хуудас.
12. Сара Тэйлор, “An Evangelical Student’s Experience at BYU,” *Meridian Magazine*, *Idsmag.com*.
13. Жэффри Р.Холланд, “Standing Together,” *Лиахона*, 29-р хуудас.
14. Жэффри Р.Холланд, “Standing Together,” *Лиахона*, 29-р хуудас.

Зүнгүгээс Найздаа

Ахмад номлогчдын энгийн үйлчлэл хүмүүсийн сэтгэлд хоногшин үлджээ.

Дэвид Диксон

Сүмийн сэтгүүлүүд

Зүнгү модон дээр байна уу? Зүнгү модон дээр юу хийж байсан юм бол? Тэр модны мөчрийг маш хурдан тасдахад ямар багаж ашигласан юм бол?

Гадаад хүн (зүнгү) зайгаар ажилладаг ир нь хоёр тийшээ хөрөөддөг хөрөөгөөр аварга том сүүдэрт модноос өмхөрсөн мөчрийг нь тайрч байхыг харсан угандачуудын оюун санаанд дээрх асуултууд төрнө. Уг багаж нутгийнханд гайхмаар зүйл байлаа. Тэднээс олон нь ийм зүйл өмнө нь огт харж байгаагүй ажээ.

Гэвч тэдэнд илүү гайхалтай нь зүнгү байлаа. АНУ-ын Ютагаас ирсэн ахмад номлогч ахлагч Роналд Харрис модны оройн хэсгээс өмхөрсөн мөчрийг ар араас нь тайрна. Доор зогсох хүмүүс гадаад хүн тэдний нэгд нь ийм ажил хийж өгч байгаад гайхаж байв.

Эцэст нь, Ахлагч Харрисын энгийн үйлчлэл нь сүм болон түүний хүмүүстэй харилцахыг хүсдэггүй хэн нэгэнтэй нөхөрлөх эхлэлийг тавьсан.

Годфритэй танилцсан нь

Ахлагч Роланд Харрис, Жанэт Харрис эгч хоёр 23 сарын номлолоор Угандагийн Кампала номлолд үйлчилж байв. Харрис эгч мэргэшсэн сувилагч бөгөөд номлогчдын эрүүл мэндийн зөвлөгчөөр дуудагдсан ажээ. Ахлагч Харрис хорвоогийн бараг бүх юмсыг засч чадах ур чадвартай, тэтгэвэрт гарсан барилгын хянагч бөгөөд сүмийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон номлолын тээврийн хэрэгслийг хариуцдаг байв.

Ахлагч Харрис, Харрис эгч хоёр Угандад ирээд удаагүй байхдаа орон нутгийн сүмийн гишүүн Мэриг гэрээ цэвэрлэхэд туслуулахаар хөлсөлжээ.

Мэри гурван жилийн өмнө баптисм хүртсэн байв. “Бид түүнд улам хайртай болж байгаа.” “Тэр бидэнд



Угандад юмс ямар байдгийг заасан” гэж Харрис эгч ярилаа.

Мэритэй лавхан танилцахын хэрээр тэдний нөхөрлөл гүнзгийрч байлаа. Тэд түүний нөхөр Годфригийн талаар ч бас мэдэж авсан гэнэ. Тэр сайн хүн хэдий ч сүмийн гишүүд, ялангуяа номлогчдоос зай барьдаг байв. “Тэр номлогчдыг гэртээ оруулдаггүй” гэж Харрис эгч хэллээ. Гэсэн ч Мэри нөхрөө тэдэнтэй уулзуулахыг хүссэн хэвээр байлаа.

Мэри Харрисынхныг гэрээрээ нэг ороод гарахыг урьжээ. “Бид ямар нэг юм хүсэн хүлээгээгүй. Бид Годфрид Мэри бол бидний хайртай найз, тиймээс түүний гэр бүлтэй танилцмаар байна гэж л хэлсэн” гэж Харрис эгч хэлжээ. Годфри тэдэнтэй уулзсан ч зөвхөн танил байхаас цааш тэдний талаар мэдэхийг хүсэхгүй байлаа.


Харин ахлагч Харрис цахилгаанаар ажилладаг багаж, шат авчирч, үйлчлэх саналаа хэлэхэд бүх зүйл өөрчлөгдсөн гэнэ.

Эргэлтийн цэг

Годфри, Мэри хоёрын гэрийг дээвэр дээр нь хэзээ хэзээгүй унаж мэдэх өмхөрсөн илүү гарсан мөчрүүдээр дүүрэн өндөр моднууд хүрээлсэн байв.

Ахлагч Харрис шууд л ажилдаа орлоо. Тэр 25 см хүртэл диаметртэй мөчрүүдийг тайран, 4 цагийн турш модны орой дээр байлаа. Мөчир тайрах ажлыг бүр эртнээс хийх хэрэгтэй байжээ. “Би газраас хамгийн багадаа л 6 метрийн өндөрт ажиллаж байлаа” гэж ахлагч Харрис хэлэв. Хажуугаар нь өнгөрсөн хүмүүс харсан зүүлдээ итгэж ядан байлаа.

Годфри ч бас мэл гайхсан гэнэ. “Тэр бидэнд дахин дахин талархсан” гэж Харрис эгч хэллээ. Мод тайрах зэрэг харьцангуй энгийн ажил томоохон аз туршилт байж



болно. “Тэдэнд эрүүл мэнддээ анхаарал тавьж, үүндээ зориулах мөнгө байдаггүй” гэж Харрис эгч тайлбарлав.

Жишээ нь: Хэрвээ хэн нэг нь модноос унаад хөл, гараа хугалчихвал өөрсдөө л эдгээдэг.

Газар дээрх модны овоолоостой тайрдаc дотны нөхөрлөлийн суурийг тавьсан юм. Ахлагч Харрис “Годфри түүнээс хойш гэрээсээ гарч ирэн, бидэнтэй мэндэлдэг болсон” гэв. Годфри, Мэри хоёр бас сүмийн бусад гишүүдийг гэртээ урьдаг болжээ.

Нил мөрнийг гаталсан нь

Цаг хугацаа өнгөрөх тусам ахлагч Харрис, Харрис эгч хоёр Годфри, Мэри хоёрт улам дассаар байлаа. Эцэст нь энэхүү нөхөрлөл номлолынх нь хугацаа дундаа ороод байсан үед Харрисынханд тохиодсон гэнэтийн гай зовлонд хүч чадал, дэмжлэг тулгуур болсон юм. Тэд хүү Брэд нь хурдны зам дээр ослоор нас барсан гэсэн мэдээг хүлээн авчээ.

Мэри, Годфри хоёр үүнийг сонсмогцоо хамгийн сайхан хувцсаа өмсөөд голын нөгөө талд байдаг хайрт найзууд руугаа очихоор аюултай замд гарсан гэнэ.

Угандад хэдхэн хүн л хувьдаа машинтай ажээ. Тэд нэг бол явган явдаг, нэг бол такси хөлсөлдөг. Тэнд хамгийн өргөн хэрэглэгддэг такси нь *бода бода* хэмээх хамгийн сайндаа зургаан хүн суулгах багтаамжтай мотоцикл байлаа.



“Харанхуйд *бода бода* унах нь аюултай шүү” гэж Харрис эгч сануулав. Тэд харанхуйд *бода бода*-гаар Нил мөрнийг гаталж наашаа ирсэн юм.

Годфри, Мэри хоёр шөнө дунд аюултай замыг гатлан, “гашуудах тэдний хамт гашууда[ж]” мөн “тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах[аар]” (Мозая 18:9) хүрч ирсэн аж. Тэр орой тэд өрөвч сэтгэл ба хайр энэрлээр үнэхээр дүүрэн байлаа. Тэдэнд үйлчлэл үзүүлсэн хүмүүс бол Мэри, Годфри хоёр байв. Харрис эгч “тэдний үйлчлэл үнэхээр гайхалтай байсан” гэж хэллээ. Мэри бүгдээрээ өвдөг сөгдөн хамт залбирах санал гаргажээ. Годфри өчүүхэн ч эргэлзэхгүйгээр залбиралд нэгдсэн гэнэ.

Ахлагч Харрис, Харрис эгч хоёр Брэдийн оршуулгад оролцохоор АНУ-ын Калифорни руу буцжээ. Дараа нь тэд номлолоо дуусгахаар Угандад эргэж ирэв. Роланд Харрис, Жанэт Харрис хоёр одоо Ютад гэртээ эргэж ирсэн ч Мэри, Годфри хоёртой ойр дотно хэвээр байгаа ажээ.

Үйлчлэл бол бидэнд хаалттай байдаг хаалгыг онгойлгох түлхүүр лүгээ адил юм. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Амин хувиа үл хичээсэн үйлчлэл нь хар амиа бодсон чармайлтыг биш, харин Бурханы зорилгыг биелүүлэх хүчийг” гэсэн билээ. (“Үйлчлэх хүсэлтэй мөн зохистой байх нь,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 74-р хуудас). ■



Африк

Өөдрөг найдварын тив



Ричард М.Ромни
Сүмийн сэтгүүлүүд

*Африк болон
Мадагаскар дахь
хожмын үеийн
гэгээнтнүүдийн
итгэл ба
дуулгавартай
байдал газар бүрийн
сүмийн гишүүдэд
үлгэр жишээ болж
байна.*

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Либер, Гана, Сиерра Лионд хийсэн айлчлалынхаа үеэр “Африкийн хүмүүсийг хайрлах маш амархан”¹ хэмээн Сиерра Лионы Фритаунд байхдаа хэлжээ.

Тэрээр Африкийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сайн мэдээг хайрлах хайраасаа олж авсан итгэл ба дуулгавартай байдал нь сүмийн бүх гишүүдэд үлгэр жишээ болж байна гэжээ.



Баптисмын гэрээ олон адислалд үүд хаалгыг нээж өгдөг бөгөөд энэ нь сайн мэдээнээс итгэлээр суралцахад ч мөн адил юм.



Ахлагч Холланд хэлэхдээ “Сайн мэдээ тэдэнд хэчнээн чухал зүйл болохыг, тэд сайн мэдээгээр хэрхэн амьдардаг болон үүнийг хэрхэн хайрладгийг мөн тэд аравны нэг төлөх болон үйлчлэлдээ хэчнээн үнэнч шударга байдгийг харсан нь жинхэнэ гайхамшиг байв. Миний бодлоор ариун сүмд явах нь тэдний хамгийн эрхэм дээд зорилго юм. Эцэст нь тэд үр хүүхдүүдээ сүмд өсгөж; хөвгүүд, охидоо номлолд явуулж байгааг харсан нь үнэхээр гайхалтай байлаа. Энэ бол тэдний итгэл бишрэлийн гайхамшигтай нотолгоо мөн” гэжээ.²

Таны нүдний өмнө

Ахлагч Холланд дурдахдаа Өмнөд Африкийг эс тооцвол (тэнд 1970 онд анх гадас зохион байгуулагджээ) сүм Африкт бий болоод 30 хүрэхгүй жил болж байна. Тиймээс Африкийн сүм “таны нүдний өмнө, маш богинохон хугацаанд өсөн өндийж байгаа” бөгөөд “Африк нь таны хувьд Их Эзэний алдар суу, сэргээлтийн гайхамшиг ба гайхалтай зүйлс шууд таны нүдний өмнө бий болж байгааг харж болох газруудын нэг юм” гэжээ.³

Тэр ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) тэнд ариун сүм барих тухай зарлах үед түүнтэй хамт Ганын Акрад байснаа үргэлж дурсан, санаж явах болно. “[Хүмүүс] баярлацгаан, уйлж, бүжиглэн, бие

биенээ тэвэрч байлаа. Тэрхүү баяр талархлын сүнс одоо ч гэсэн үргэлжилсээр байна. Энэ бол африкчуудыг хайрлах миний хайр, энэ бол сайн мэдээнд хязгааргүй баярласан тэдний хөөр баясал юм. Тэдний ихэнх нь ядуу тарчиг амь зуулгатай ч сайн мэдээг бүрэн хүлээн авч дагасан юм. . . . Тэд одоо ч, бүр өнөөдрийг хүртэл тийм хэвээрээ байна” гэжээ.⁴

Бошиглолууд биелэгдсэн нь

Африкт ажил үүргээ биелүүлж, тэнд очсон бусад бошиглогч, төлөөлөгчид энэ тивийг Их Эзэний бошиглолууд жинхэнэ ёсоор биелэгдэж байгаа газар гэж хэлсэн юм.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт Нигери болон Мозамбик дахь сүмийн гишүүдтэй хийсэн уулзалтынхаа үеэр “Африкчууд сайхан сэтгэлтэй, тэвчээртэй хүмүүс. Тэдэнд зарим зүйлсийг хийх хангалттай орлого байдаггүй эсвэл санхүүгийн эх үүсвэр дутагддаг, тиймээс тэд ийм зүйлсийг ердөө бор зүрхээрээ л хийдэг. Тэд Ариун Сүнсээр өдөөгдсөн ямар нэг зүйлийг хийхийн тулд, энэ ажлыг урагш ахиулахын тулд маш олон, бүр үй олон километрийг алхах болно” гэжээ.⁵

Сайн мэдээг энэ оронд номлолын тулд ахлагч Скотт 1999 онд Мозамбикийг онцгойлон адислах үед тэнд ердөө 40 гишүүн байсан бөгөөд энэ улс Өмнөд Африкийн Иоханнэсбург Номлолд харьяалагддаг байжээ. 2011 оны нэгдүгээр сард түүнийг хоёр дахь удаагаа айлчлахад Мозамбик дахь сүм 5 000 гаруй гишүүн, 2 дүүрэг, 19 салбартай болж, улс даяар өссөн байв. Мозамбик нь түүнчлэн Ангол улсыг багтаасан

Мозамбикийн Мапуто Номлолын удирдах газар юм.⁶

Залуу байгаа ч гэсэн өсөж байна

“Сүм энд залуугаараа байна”⁷ гэж Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М. Нэлсон Мадагаскар, Малави, Кенид айлчлах үедээ хэлжээ. Тэрээр “Бид Их Эзэн энэхүү агуу Африк тивд хүмүүсийг . . . өргөмжлөл ба авралын ёслолуудыг багтаасан сайн мэдээний гэрэл ба үнэнээр адислахаар ажиллаж байгааг харж байна.”⁸ Би Африкийн орон нутгийн сүмийн удирдагчдын хүч чадалд үнэхээр гайхширсан шүү. Бид эдгээр хүмүүсийн амьдралыг адислахаар Их Эзэний үйлчлэлд цаг зав, авьяас чадвараа зориулж буй орон нутгийн удирдагчдад маш их талархаж байна”⁹ гэсэн билээ.

Ахлагч Нэлсон Африк ба Мадагаскар дахь хүмүүс болон сүмийн ирээдүйн талаар “үнэхээр өөдрөг” сэтгэгдэлтэй байна. Учир нь тэдний итгэл сорилт бэрхшээлээс нь илүү хүчирхэг байна. “Та нар үнэхээр Их Эзэн Есүс Христ болон Бурхан, бидний Мөнхийн Эцэгтэй уулзаж, Тэдний оршихуйд гэр бүлтэйгээ хамт амьдрахаар бэлтгэгдсэн Израилын гэрээт хүүхдүүд, Бурханы хүүхдүүд юм”¹⁰ хэмээн Мадагаскар дахь нэгэн уулзалт дээр хэлжээ. Ахлагч Нэлсон бас “Эдгээр хүмүүс бол агуу чадавхтай хүмүүс. Тэд итгэлтэй болжээ. Тэдэнд Их Эзэний хайр болон хүмүүсийг үнэхээр хүчирхэг болгоход шаардлагатай бүх зүйл байна” гэжээ.¹¹

Кенийн Найробид болсон нэг ярилцлагын үеэр ахлагч Нэлсон “Бидэнд хожмын үеийн гэгээнтнүүдийн цуглааны байрууд байна. Бид Найробид нэг гадастай боллоо.





**Аврагчийг санахыг үргэлж хичээдэг
гишүүд ариун ёслолоос хүртсэнээр
итгэл нь бэхжин, шинэчлэгддэг.**



Өнөөдөр бид гадасны чуулганаа хийж байна. Хүмүүстэй уулзах нь сэтгэл догдлом сайхан байлаа. Мянга гаруй хүн цуглажээ. Тэд их хүндэтгэлтэй байв. Тайзан дээр гайхалтай сайхан найрал дуу, онцгой сайн гадасны зөвлөл бас патриарх байлаа. Би ийм их өсөлт хөгжлийг хараад баяр хөөрөө хэрхэн илэрхийлэхээ мэдэхгүй байна!” гэж хэллээ.¹²

Бэрхшээлийг эс хайхран

Африк дахь сүм нь олон сорилт бэрхшээлтэй тулгарсан ч хөгжин дэвшиж байна хэмээн ахлагч Холланд хэлжээ. Тухайлбал: Тэрээр “Зааны Ясан Эрэг улсад иргэний дайн дэгдсэн ч хожмын үеийн гэгээнтнүүд . . . ариун сүмд ирсээр байна. Энэ нь тэдэнд агуу хүндэтгэл, нэр төрийн хэрэг болж байлаа. Би үнэхээр бишрэн, гайхсан шүү” гэжээ.¹³

Сиера Лион, Либер хоёрын талаар ахлагч Холланд хэлэхдээ “Энэ хоёр орон саяхан цус урсгасан хэрцгий дайнд нэрвэгдсэн учраас энэ нь сайн мэдээ ийм гайхалтай хурдаар дэлгэрсэн шалтгаануудын нэг болсон юм. Тэд амьдрал ямар байж *болохгүйг* харсан бөгөөд одоо тэд номлогч болон гишүүдийн гэрчлэлтэйгээр тэд амьдрал ямар байж *болохыг* харсан. Тэнгэр тэдний зовлон бэрхшээлийг адислал болгон хувиргаснаар тэд өөрсдийгөө улс төрийн тодорхойгүй байдал болон иргэний зөрчилдөөнөөс гаргаж байна” гэжээ.¹⁴

Түүнээс гадна, ахлагч Холланд Зимбабве дахь

сүм ойрын жилүүдэд хүнд үеийг туулсан ч өсөж хөгжсөөр байгааг онцгойлон, “Сүм хөгжин дэвжлээ. Бид өсөлт хөгжлийг мэдэрч, харж байна. Бид гадас, номлолуудтай боллоо. Энэ бол Африк даяар болж байгаа үйл явц юм” гэж хэллээ.¹⁵

Сайн мэдээг номлох нь

“Африк дахь сүмийн амжилтын нэг түлхүүр нь бид улс төр, нийгмийн асуудлуудад илэрхий оролцдоггүйд оршино. Бид сайн мэдээг номлодог бөгөөд шуударга ёс, нийгмийн тэгш байдал ба адил тэгш боломжийн төлөө санаа тавьдаг. Гэвч бид эдгээр асуудлуудын хариулт сайн мэдээнд байдаг гэж боддог учраас зөвхөн сайн мэдээг л номлодог. Хүмүүс сайн мэдээний ойлголт, адислал ба гэрлийг амьдралдаа хүлээж авснаар юмс тэр даруй өөрчлөгдөж эхлэн, амьдрал нь адислагддаг нь хаана ч гэсэн үнэн бөгөөд Африкт ч мөн адил юм” хэмээн ахлагч Холланд хэлжээ.¹⁶

Их Эзэний амлалт

Ахлагч Холланд “сүүлчийнх нь эхнийх болж, эхнийх нь сүүлчийнх байх болно” (Матай 20:16) гэсэн Аврагчийн үгийг эш татав.

“Зарим талаар сайн мэдээ Африкт оройтож ирсэн ч бид үүнийг Их Эзэний цагт л амжуулж чадсан. Үнэхээр Их Эзэний цагт хэмээн би баталж чадна шүү. Африкчууд номлол ба номлогчид, санваарын адислал гэх мэт зүйлстэй болж эхэлсэн нь харьцангуй саяхан юм. Африк бол том тив бөгөөд бидний туулах зам урт байна. Гэхдээ Африкт бидний харж байгаа өсөлт хөгжилт Их Эзэний амлалтын биелэлтийн хэсэг гэдэгт

би итгэдэг. Африкийн хожмын үеийн гэгээнтнүүд итгэлээр жигүүрлэн, урагшилж байна. Тэд замдаа явж байна. Тэд сайн мэдээг хүлээн авч, үр дүнг нь амьдралдаа харагдахуйц болгоход сорилт бэрхшээлтэй тулгарч байгаа” гэж тэрбээр ярилаа.¹⁷ ■

ЭШЛЭЛҮҮД

1. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa,” www.lds.org/prophets-and-apostles/unto-all-the-world/emerging-with-faith-in-africa.
2. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
3. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
4. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
5. Ричард Г.Скотт, “Mormons in Africa: A Bright Land of Hope,” mormonnewsroom.org/article/mormons-africa-bright-land-hope.
6. “Jesus Christ Lives’ Elder Scott Testifies in Mozambique,” lds.org/prophets-and-apostles/unto-all-the-world/jesus-christ-lives-elder-scott-testifies-in-mozambique-г үзнэ үү.
7. Рассэлл М.Нэлсон, “Learn of the Savior, Saints in Madagascar and Malawi Are Told,” lds.org/prophets-and-apostles/unto-all-the-world/learn-of-the-savior-saints-in-madagascar-and-malawi-are-told.
8. Рассэлл М.Нэлсон, “Elder Nelson Completes Trip to Africa in Kenya,” lds.org/church/news/elder-nelson-completes-trip-to-africa-in-kenya.
9. Рассэлл М.Нэлсон, Хэдр Витл Риглигийн видео бичлэг, “Elder Nelson Visits Madagascar, Dedicates Malawi,” 2011 оны 10-р сарын 28, lds.org/church/news/elder-nelson-visits-madagascar-dedicates-malawi.
10. Рассэлл М.Нэлсон, “Learn of the Savior, Saints in Madagascar and Malawi Are Told.”
11. Рассэлл М.Нэлсон, “Elder Nelson Visits Madagascar, Dedicates Malawi.”
12. Рассэлл М.Нэлсон, “Family Success Comes from Following the Savior,” lds.org/prophets-and-apostles/unto-all-the-world/family-success-comes-from-following-the-savior.
13. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
14. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
15. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
16. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”
17. Жэффри Р.Холланд, “Emerging with Faith in Africa.”



ЗҮҮН ӨМНӨД БА БАРУУН АФРИКИЙН БҮСҮҮД*

Гишүүд: 381,417

Гадас: 70

Тойрог: 508

Номлол: 22

Дүүрэг: 60

Салбар: 646

Удирдах алба: Өмнөд Африкийн Иоханнесбург, Ганын Акра

*2013 оны 4-р сарын байдлаар.

АРИУН СҮМ

Ажиллаж байгаа:

Акра Гана, 2005 оны 8-р сарын 7-нд онцгойлон адислагдсан

Аба Нигери, 2004 оны 1-р сарын 11-нд онцгойлон адислагдсан

Өмнөд Африкийн Иоханнесбург, 1985 оны 8-р сарын 24–25-нд онцгойлон адислагдсан

Зарлагдсан:

Өмнөд Африкийн Дурбан

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс

ХАМГИЙН АГУУ ГАЙХАМШИГ

Есдүгээр сарын нэгэн цэлмэг өдөр манай бага охин Эрика машины ноцтой осолд орсон юм. Түүнийг нисдэг тэргээр эмнэлэгт хүргэсэн ч олон цаг үргэлжилсэн мэс заслын дараа бид эмгэнэлт мэдээ сонслоо. Гоо үзэсгэлэнтэй, сэргэлэн цовоо 17 настай охин минь хорвоог орхижээ.

Үүнээс хойших хэдэн сар бидэнд туйлын хүнд байлаа. Бид түүний төрсөн өдөр болон Талархлын баярыг тэвчин өнгөрүүлж, Христийн мэндэлсний баярыг анх удаа түүнгүйгээр угтав. Хүмүүс бидэнд баяр тэмдэглэх нь хэцүү байх болно гэдгийг анхааруулж байсан боловч хэчнээн ч олон анхааруулга нь биднийг сэтгэлзүйн бэлтгэлтэй болгож чадаагүй юм.

Дааж давшгүй уй гашуу, цөхрөл гутралаас гадна би баяраа хамтдаа жаргалтайгаар тэмдэглэж байгаа гэр бүлүүдэд атаархдаг байлаа. “Яагаад бидэнд ийм явдал тохиолдов? Яагаад бидэнд бусдын ярьдаг шиг гайхамшиг тохиодоггүй юм бэ?” хэмээн би гомдолтойгоор боддог байлаа.

Би уй гашуу болон цөхөрч явахдаа манай тойрогт болсон “Бетлехем дэх Христийн мэндэлсний баяр” сэдэвт үйл ажиллагааг саналаа. Тойргийн гишүүд Есүсийг төрөх үед хүмүүсийн өмсдөг байсантай адил хувцас өмсөж ирсэн байлаа. Тэр үед дөрвөн настай байсан Эрика маань хуучин урт хувцас өмсөөд толгойгоо хүзүүний ороолтоор ороосон байв. Тэр үдшийн оргил хэсэг нь тэвш болон бухал өвсөөр чимэглэсэн малын хиймэл хашаан дахь Христийн төрөлтийн үзэгдэл байлаа. Нэг залуу хос саяхан төрсөн хүүхэдтэйгээ хамт Мариа, Иосеф мөн бяцхан Есүсийн дүрд тоглосон.

Бид уг үзүүлбэрийг үзэхээр тойрон цуглах үед би Эрика хажууд минь

байхгүй байгааг харлаа. Би түүнийг үзүүлбэрийн ойролцоо цагаан хувцастай байхад нь олж харах хүртлээ айн сандарч билээ. Би өмнө нь охиныхоо төлөө тэвдэн сандарсан бол одоо үзүүлбэрийг үзэхэд нь бусдад саад болох вий гэхээс айх болов. Би охиноо дуудах гэснээ түүнийг малын тэвш рүү явахыг нь хараад болив.

Эрика Мариагийн хажууд өвдөглөн суугаад түүнээс зөвшөөрөл хүсэх мэт түүн рүү харав. Тэгээд Эрика унтаж буй бяцхан хүүхэд рүү дөхөж очин, түүнийг зөөлхөн иллээ. Үүнийг ажигласан хүн ганц би биш байлаа. Бусад хүмүүс удалгүй чимээгүй болж, түүнийг бяцхан хүүхдийн дэргэд өвдөглөн суухыг харцгаав. Эрикагийн хувьд тэр бяцхан хүүхэд Христ болохыг хүмүүс ойлгоод, зүрх сэтгэл нь хайрын энхрийхэн мэдрэмжээр дүүрсэн нь лавтай.

Би уй гашуугийнхаа хажуугаар бяцхан охиныхоо гүнзгий итгэл

Эрикагийн хувьд тэр бяцхан хүүхэд Христ болохыг хүмүүс ойлгоод, зүрх сэтгэл нь хайрын энхрийхэн мэдрэмжээр дүүрсэн нь лавтай.

бишрэлийг эргэн санах агшинд Христийн мэндэлсний баярын энэхүү дурсамж надад амар амгалан ба тайтгарлын мэдрэмжийг авчирлаа. Оюун бодол минь Эрикаг хорвоог орхихоос хаа хамаагүй өмнөх үеийн өдий төдий асуулт, амьдрал ба үхлийн тухай олон асуултаар дүүрэв. Би Христийн амиалалт ба цовдлолтын тухай тунгаан бодоод Мариаг ойлгосон юм шиг санагдлаа. Тэр дөнгөж саяхан мэндэлсэн Хүүдээ хэчнээн их хайртай байсан бол? Харин тэр хожим нь Түүний зовлон шаналал, үхлийг хараад аймшигтайгаар тарчлан шаналж, сэтгэл нь шархалсан юм. Христ загалмай дээрх өвдөлтөөс аврагдаагүй, Мариа ч бас уй гашуугаас чөлөөлөгдөөгүй юм.

Бид Христийн мэндэлсний баярыг дэлхий дээр Аврагчийн амьдрал эхэлснийг бэлгэдэн тэмдэглэдэг. Харин миний хувьд төрөлт, Түүний зовлон шаналал, үхэл ба амиалалт нь цагаатгалтай ямагт холбоотой юм.

Аврагч үхлийн хүлээсийг тасалсан учраас Эрикагийн үхэл эцсийнх биш гэдгийг би мэднэ. Энэ бол талархалтай байхын гайхамшиг, бүх цаг үеийн хамгийн агуу гайхамшиг юм. ■

Эллэн Нэлл,
Юта, АНУ



ТҮҮНИЙ ЗАЛБИРЛЫН ХАРИУ

Би Христийн мэндэлсний баярын буур амьсгалыг мэдэрсэнгүй. Би ахлах сургуулийнхаа сүүлчийн жилийн арванхоёрдугаар сард коллежид элсэх өргөдлөө бөглөж, явуулах, Лаурэлын сүүлчийн төслөө бичиж дуусгах хэрэгтэй байлаа. Би Лаурэл ангийн төсөлд оролцсон тухайгаа мөн энэ төслөө коллежид элсэх өргөдөлдөө оруулж, ашиглахын тулд сайн дурын туслагч олж чадна гэдэгт итгэлтэй байлаа. Аз болоход, манай сурагчдын зөвлөлийн зөвлөх миний найз Жэссика бид хоёроос орон нутгийн энэрлийн нэг байгууллагад сургуулиас тоглоом хандивлах ажлыг зохион байгуулахыг хүсэв.

Би төслийн хороонд ихэнх ажлыг хариуцуулав. Тэднээр би хандивласан тоглоомын тоог заах том термометрийг дүрсэлсэн зарлалын самбар хийлгэлээ. Бид үүнийг хангалттай сурталчилгаа гэж үзэн, өдрийн цайны цаг бүрийг хандив цуглуулахад зориулдаг байв. Сурагчид цөөн тоглоом хандивласан болохоор термометрийн заалт доогуур байлаа.

Хачирхалтай нь, манай зөвлөгч зарим тоглоомуудыг ялгаж эхлэв. Жэссика бид хоёр түүнээс яах гэж байгааг асуухад тэр бидэнд сургуулийн нэг багш саяхан хорт хавдраар өвчилсөн гэлээ. Эмчилгээнийхээ хажуугаар хичээл заах нь хүнд байсан учраас тэр ажлаасаа чөлөө авахаар шийдсэн гэнэ. Баяр дөхөж, түүний эмчилгээний хөлс бөөгнөрсөн учраас гэр бүл нь Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх зүйл багатай байлаа. Зөвлөгч маань биднийг тэдэнд зориулж, тусад нь бэлэг боохыг зөвлөв.

Миний сэтгэл их догдоллоо. Би үйлчлэлийн төслөө бусдад биш зөвхөн өөртөө үйлчлэх юм шиг бодож байсан юм. Би хандивын тоглоомын тоо хэмжээг гурав дахин

их болгохоор шийдэн, багш болон түүний гэр бүлд зориулж, мөнгөн хандив цуглуулж эхэллээ.

Жэссика бид хоёр ангиудаар явж, сэдсэн үйлсээ сурталчлав. Асар их үр дүн гарлаа. Багш, ажилчид болон сурагчид тэр гэр бүлд туслахаар тоглоом, мөнгө хандивлав. Удалгүй бид тоглоом цуглуулах зорилгоо давуулан биелүүлж, энэрлийн байгууллагынхныг гайхшируулсан юм. Бид түүнчлэн уг гэр бүлд зориулж, 1000 гаруй доллар цуглуулсан байв.

Биднийг цуглуулсан болон худалдаж авсан бэлгүүдээ нямбайлан боож байхад миний хүлээн авсан үйлчлэлийн гэрчлэл нь бидний өгөх гэж буй бэлгүүдтэй адил агуу зүйл гэдгийг би ойлгосон юм. Бидний нэрээ нууцлан, довжоон дээр нь үлдээсэн бэлгүүдийг тэр гэр

бүл хэрхэн олж буйг нууцаар харсан үедээ би үгээр илэрхийлэх аргагүй мэдрэмжийг мэдэрсэн юм.

Хэдэн сарын дараа Жэссика бид хоёроос үйлчлэлийн төслийнхөө талаар семинарт хичээл заахыг хүслээ. Бид нөгөөх багшийн нэрийг хэлэлгүй, хийсэн зүйлээ ярьж өглөө. Гэтэл нэг охин гараа өргөн, босоод ярих үед нүднээс нь нулимс урсаж эхэллээ. Тэр багш түүний авга ах нь байсан бөгөөд бидний үйлчлэл түүнд ямар их үнэ цэнэтэй байсныг тайлбарлалаа. Энэ нь түүний залбирлын хариу байсныг тэр охин хэлэв.

Тэр баярын үеэр бид чин сэтгэлийн үйлчлэлд сэтгэл нийлэн цугласан нь том өөрчлөлт авчирсныг мэдэх нь ямар их баяр баясал байсан гээч. ■

Линзи Ливитт, Невада, АНУ

Биднийг бэлгүүдээ нямбайлан боож байхад миний хүлээн авсан үйлчлэлийн гэрчлэл бидний өгөх гэж буй бэлгүүдтэй адил агуу зүйл гэдгийг би ойлгосон юм.



БИ БАПТИСМ ХҮРТЭНЭ!

Христийн мэндэлсний баярын үе байлаа. Зузаан цас газрыг хучжээ. Хамтрагч бид хоёр хэдэн сарын турш Германы хүйтэн өвлийг сөрөн, хаалга тогшиж, Мормоны Номыг тараадаг байв. Дэлхийн II Дайн дуусаад 15 жил өнгөрсөн ч олон герман хүн америкчуудаас цэрвэдэг байв.

Харин тэр орой Ингэборг Бинмүллэр баптисм хүртэх гэж байлаа. Нэгдсэн Улсын Агаарын Цэргийн бааз руу автобусаар явах нь хол ч гэсэн тэр эмэгтэй тайван байлаа. Түүний улам уйтгарлан, гуниглахыг би ажиглалаа.

Биднийг автобусны буудалд ирэхэд Ингэборг бидэн рүү эргэж хараад “Надад хэчнээн хэцүү байгааг та нар мэдэж байна уу? Холбоотны цэргүүд

дайны үеэр нөхрийг минь алсан. Бас тэд агаараас бөмбөгдөж, манай гэр бүлийн бусад олон гишүүдийн амийг хөнөөсөн юм шүү дээ” гэлээ.

Тэр хөлөндөө гараа хүргээд “би хүхрийн бөмбөгний хэлтэрхийнд өртсөн юм. Миний энэ хөл огт эдгэрэхгүй. Би цэргийн бааз руу орох эсэхээ мэдэхгүй л байна шүү” гэх нь тэр.

Бид түүний хэлснийг дотроо эргэцүүлэн бодож, чимээгүй сууж байтал автобус хүрч ирэв. Индэборг суусаар л байв. Миний зүрх түг түг цохилж эхэллээ. Тэр эмэгтэй айдсаасаа болж, шийдвэрээ бүү өөрчлөөсэй хэмээн би залбирлаа.

Гэтэл тэр суудлаасаа босч, “Тэнгэрлэг Эцэг надад сэргээлт

үнэн гэдэг гэрчлэлийг өгсөн. Би Мормоны Ном үнэнийг мэднэ. Би баптисм хүртэнэ! Ахлагч Аткин, явахад минь туслаач” гэв.

Бид хаалга хүртэл удаан алхлаа, тэгээд биднийг харуулуудын дэргэдүүр өнгөрөх үед Ингэборг хүндээр амьсгаадаж байлаа. Бид цагаан хувцсаа сольж өмсөөд зоорийн давхар дахь усан сан руу очлоо. Тэр усан сан бидний хувьд ариун газар болж, амар амгалан бидэнд мэдрэгдэв. Ингэборгийг ус руу орох мөчид түүний нүүрэн дэх уйтгар гуниг баяр баясгалангаар солигдон, тэр баптисм хүртэж, сүмийн гишүүн болсон билээ.


Биднийг гэр рүүтээ буцаж явах үед Ингэборг “Ахлагчид Мормоны Номыг надад үлдээж явсан тэр үдэш миний сэтгэл үнэхээр их догдолсон шүү” гэж хэлэв. “Би орой болтол унталгүй Мозая 18-р бүлгийг хүртэл уншсан. Тэнд Алма хүмүүсийг баптисм хүртэхэд урьж, “Болгоогтун, Мормоны Ус энэ байна . . . мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж . . . мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж . . . баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?” гэж хэлсэн байдаг. (Мозая 18:8, 10).

Тэр аяархнаар цааш үргэлжлүүлэн, “Би эдгээр үгсийг уншиж байгаад унтчихсан. Тэгээд нэг зүүд зүүдэлсэн. Би Мормоны Устай адил нэгэн үзэсгэлэнтэй их усны дэргэд зогсож байх юм. Усны нөгөө талд цагаан хувцастай хүмүүс—гэр бүлийнхэн маань зогсож байна! Дайнд үрэгдсэн нөхөр маань над руу инээмсэглэн хараад намайг баптисм хүрт гэж толгой дохисон” гэлээ.

Тэр орой Бинмүллэр эгч Вүрзбүрг салбарт гишүүн болсноор айдсаа ялж, сүмд нэгдсэн олон германчуудын нэг болсон билээ. ■

Роё Аткин, Калифорни, АНУ

Ингэборг бидэн рүү эргэж хараад, “Надад хэчнээн хэцүү байгааг та нар мэдэж байна уу?” гэв.



БИД БЭЛГЭЭ АВАХААР ИРЛЭЭ

Би дүүргийнхээ ерөнхийлөгчийн зөвлөлд байхдаа гишүүддээ Коломбын Соачад амьдардаг ядуу хүүхдүүдэд зориулсан тоглоомын хандивын үйл ажиллагааг зохицуулахад тусалсан юм. Бүх гишүүд бидэнд гайхалтай хариу үйлдэл үзүүлсэн. Бүх бэлэг цоо шинэ биш ч ихэнх нь бараг л шинээрээ байлаа.

Биднийг хот руу хүргэх автобусанд бэлгүүдээ ачиж дуусч байхад нэгэн жаахан охин маш их элэгдэж, зурагдсан хуванцар бөмбөгтэй над дээр

ирлээ. Би бөмбөгийг гартаа барьж үзээд хэн ингэтлээ элэгдсэн бөмбөгийг хандивладаг байна аа гэж бодлоо. Тэгээд би бага зэрэг дургүйцэн, бөмбөгийг суудал доогуур шидэв.

Биднийг хүрэх газартаа очиход залуус маань Христийн мэндэлсний баярын дуулууд дуулж эхлэв. Тэдний хөгжим болон Христийн мэндэлсний баярын малгай олон хүүхдийн анхаарлыг татлаа. Биднийг бэлгээ тарааж эхэлтэл тэнд байсан хүүхдүүд өөр хүүхдүүдийг дуудаж ирүүлэв. Удалгүй бид бүх бэлгээ тарааж дуусав.

Биднийг явах гэж байтал найм орчим настай нэг хүү бяцхан

Тэр хөвгүүн дүүгээ адисалсан шиг би ч бас бусдыг адислахдаа соргог байх хэрэгтэй юм байна гэж дотроо бодлоо.

дүүгээ хөтлөн, бидэн рүү гүйж ирэхийг би харлаа. Тэд ирээд наймтай хөвгүүн нь “Бид бэлгээ авахаар ирлээ” гэлээ. Түүний гэнэн цайлган зан намайг хэлэх үггүй болгож, сэтгэлийг минь уяраав.

Би түүнд бэлэг дууссан гэж хэллээ. Тэр хариуд нь “Надад бол хамаагүй, бэлэг өгөхгүй ч байж болно, харин дүүд минь бэлэг өгөөч” гэлээ.

Тэгэхэд л би суудал доогуур шидсэн нөгөөх бөмбөгийг саналаа. Би хөвгүүдэд нэг бэлэг байгаа нь ч байгаа, гэхдээ тун даруухан даа гэв.

“Юу ч байсан хамаагүй ээ” гэж хөвгүүн хэллээ. “Энэ л дээ” гэж би хэлээд автобусанд орж, нөгөөх бөмбөгийг гаргаж ирэв. Намайг бяцхан хүүд бөмбөгийг өгөхөд тэр баярлан, сүйд болов. Хүү баярлан дэвхэрч, “Бөмбөг! Бөмбөг! Энэ чинь надад өгөхийг Христээс миний гуйсан бэлэг мөн байна” гэв. Тэр бяцхан хөвгүүн баярлан, харайж, бүжиглэн, дэвхэцсээр үнэ цэнэтэй бэлгээ тэврэн, ахтайгаа хамт аваад явав.

Амар амгалан болон талархлын мэдрэмж намайг эзэмдэн, би тэнд нулимс асгаруулан, зогсож үлдсэн юм. Бяцхан хөвгүүн өөрийгөө үл хайхран, дүүгийнхээ төлөө анхаарал халамж тавьсан нь намайг уярааж орхилоо. Тэр хөвгүүн дүүгээ адисалсан шиг би ч бас бусдыг адислахдаа соргог байх хэрэгтэй юм байна гэж дотроо бодлоо.

Хоёр бяцхан хөвгүүнийг холдон явахад биднийг хайрладаг Аврагчийн хайрыг би саналаа. Тэрбээр Христийн мэндэлсний баяраар бөмбөг гуйсан хөдөөгийн бяцхан даруухан хүүг хүртэл мартаагүй юм. ■

Волтэр Эмилио Посада
Родригез, Коломб





Арванхоёр
Төлөөлөгчийн чуулгын
Ахлагч Робэрт Д.Хэйлс

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР-ЫН АМЛАЛТ

*Аврагч Эцэгийнхээ хүслийг биелүүлсэн шиг
бид энэ удаагийн Христийн мэндэлсний баяр-
рын үеэр Түүний хүслийг биелүүлж, Түүнийг
дагах гэрээгээ шинэчлэх цаг гаргах болтугай.*

Бид Аврагчийн амьдрал, цагаатгал ба амилалтын утга учрыг ойлгохгүй бол Христийн мэндэлсний баярын утга учрыг бүрэн ойлгож чадахгүй. Би Түүний Пилатад хэлсэн “Учир нь би үүнийг гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцөд ирсэн” (Иохан 18:37) гэсэн үгсийг бодохгүйгээр Аврагчийн төрөлтийн тухай бодож чаддаггүй билээ.

Христийн мэндэлсний баяр эхлэх үеэр Аврагчийн тухай судрын бошиглолуудыг анхааралтай авч үзэцгээе. Бошиглолууд нь зүгээр нэг тохиолдлын зүйлс биш харин Түүний амьдрал, зорилго ба амлалт, Тэр бидний хүн нэг бүрийн төлөө юу хийсэн тухай баримтат нотолгоо юм.

Түүний ирэлтийн тухай бошиглолууд

Христийн ирэлтийг мянга мянган жилийн турш зөгнөн хэлсэн юм. Есүс Христийн төрөлтөөс 2000 орчим жилийн өмнө Абрахам авралын төлөвлөгөөн дэх Түүний үүргийн тухай заажээ. Түүний төрөлтөөс 1400 орчим жилийн өмнө Мосе мөн дээрхтэй адил гайхамшигтай үнэнүүдийг зааж байлаа. Түүнийг төрөхөөс 700 орчим жилийн өмнө Түүний төрөлт, амьдрал ба үхлийн нөхцөл байдлыг Исаиа ийн илчилжээ:

“Тийм учраас Эзэн өөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ “Иммануел” гэж нэрлэнэ” (Исаиа 7:14).



“Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт, Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна” (Исаиа 9:6).

“Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд зовлонг мэдсэн. . . .

“Үнэхээр тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав. Харин бид түүнийг Бурханд яллагдаж, цохигдож, зовсон гэж бодов.

“Тэвч Тэр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарчээ . . . Түүний шархаар бид эдгэрсэн. . . .

“ . . . Алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй.

“Хавчлага шүүх Түүнийг аваад явлаа. . . .

“Түүний булш нүгэлт хүмүүстэй хамт байх байсан боловч, Тэр үхэлдээ баян хүнтэй хамт байсан. Тэр хүчирхийлэл үйлдээгүй. Түүний аманд нь ямар ч худал хуурмаг байгаагүй” (Исаиа 53:3–5, 7–9).

Исаиагийн бошиглолын дараа удалгүй бошиглогч Лихай гүн утгатай зүүд зүүдлэн, гэр бүлдээ сурсан зүйлээ заажээ. “Миний эцэг Лихай Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жилийн хойно, Их Эзэн Бурхан иудейчүүдийн дунд нэгэн бошиглогчийг төрүүлэх болно— бүр нэгэн Мессиаг, эсвээс, өөр үгээр, дэлхийн нэгэн Аврагчийг” (1 Нифай 10:4) хэмээн Нифай цэдэглэжээ.

Лихай бас дэлхийн Гэтэлгэгчийн ирэлтийн талаар гэрчилсэн олон бошиглогчийн тухай ярьсан ажээ (1 Нифай 10:5-р шүлгийг үзнэ үү).

Христийн мэндэлсний баярын амлалт

Аврагчийн төрөлтийн өмнө Түүний ээж үеэл Елизабеттэй уулзахаар яаран явсан тухай Лукийн сайн мэдээнд цэдэглэсэн байдаг.

“Елизабет Мариагийн мэндийг сонсмогц хэвлий дэх хүүхэд нь хөдлөв. Елизабет Ариун Сүнсээр дүүрч,

“чанга дуугаар хашхиран, эмэгтэйчүүдийн дундаас ерөөлтэй нь чи мөн. Хэвлий дэх үр чинь ерөөлтэй еэ!” (Лук 1:41–42).

Ариун Сүнс Елизабетэд гэрчилсний адилаар бидэнд ч бас бошиглогчдын үгс гүйцэлдсэнийг гэрчилдэг. Эцэг нь Түүгээр хийлгэхээр илгээсэн ажлыг Аврагч ирж гүйцэтгэсэн юм.

Нифай Аврагчийн тухай:

“Мөн би сайхь онгон бүсгүйг харж, гар дээрээ хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

“Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүг болгоогтун!” хэмээн цэдэглэжээ. (1 Нифай 11:20–21).

Аврагч 12 настай байхдаа ариун сүмд заажээ. Тэрээр санаа нь зовсон эцэг эхдээ Эцэгийнхээ ажлыг хийж байснаа тайлбарласан юм (Лук 2:42–49-р шүлгүүдийг үзнэ үү).

Тэрхүү ажил нь дэлхийд ирсэн зорилгоо гүйцэлдүүлэхээр Түүнийг явахад биелэгдсэн билээ. Аврагч уг зорилгын биелэлтийг дараах сэтгэл догдлом үгсээр тайлбарлажээ:

“Би өөрийнхөндөө ирсэн, гэтэл өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй. Мөн миний ирэлтийн талаарх судрууд гүйцэлдсэн болой.

“Мөн намайг хүлээн авсан болгонд, Бурханы хөвгүүд болохыг би



Бид долоо хоног ариун ёслолоос хүртэхдээ өөрсдийн амьдралд Аврагчийн төрөлтийн амлалтыг шинэчилдэг билээ.

тэдэнд зөвшөөрсөн; мөн бүр миний нэрэнд итгэх болгонд би зөвшөөрөх болно, учир нь болгоогтун, надаар гэтэлгэл ирдэг, мөн надаар Мосегийн хууль гүйцэлдсэн бөлгөө” (3 Нифай 9:16–17).

Бид Аврагчид итгэж, Түүнд итгэх итгэлээ ашиглан, Түүнийг дуулгавартай дагаснаар Түүний хөвгүүд, охид болно гэсэн Түүний амлалт биелэгдэх болно. Тийнхүү бид мөнх амьдралын бэлгийг хүлээн авахад бэлтгэгдэх болно.

Тэрээр хэлэхдээ: “Болгоогтун, өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой. Болгоогтун, бибээр Есүс Христ. . . . Надаар бүх хүмүүн төрөлхтөн амьдралыг, бүр миний нэрэнд итгэх тэд мөнхийн түүнийг хүртэх болно; мөн тэд миний охид, мөн миний хөвгүүд болох болно” (Ифер 3:14) гэжээ.

Христийн мэндэлсний баярын утга учир

Христийн мэндэлсний баяр бол бид бусдад бэлэг өгч, тэднийг хүчирхэгжүүлэн, Бурханы хаант улс дахь ажил үүргээ биелүүлэх үе билээ. Энэ нь түүнчлэн бид бусдад хайраа илэрхийлж, Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцах үе юм.

Бид гэрчлэлээ хуваалцах нэг арга зам бол Их Эзэний төрөлтийн талаар ярилцлага өрнүүлэхийн тулд Христийн төрөлтийг харуулах дүрсүүдийг гэртээ тавих буюу үйл явдлыг дүрслэн үзүүлэх явдал юм. Өөр нэг арга нь Жон Вэймэний *Харш* зэрэг түүхүүдийг ярьж өгөх юм.

Жон Вэймэн амжилттай нэгэн байсан бөгөөд энэрлийн үйлс нь олны анхаарлыг түүнд хандуулж, нэр алдар авчирсан ажээ. Нэг орой

тэр өөрийнх нь өгөөмөр сэтгэлийг магтсан сонин баахан хайчилбар өгүүллүүдийг анхааралтай уншсаны дараа Библээ авлаа. Удалгүй тэрээр “Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж” (Матай 6:19) гэсэн Аврагчийн үгийг уншиж байгаад таг унтчихжээ.

Жон унтаж байхдаа өөрийгөө “тэнгэрийн хотод” очин, бусадтай хамт явж, өөр өөрийн харшийг хүлээн авч байна гэж зүүдэлсэн гэнэ. Хаалганы сахиул хуучин материалаар барьсан нэгэн жижигхэн байшингийн өмнө зогсоод Жонд “Энэ бол чиний харш” гэжээ.

Жон эсэргүүцэн, өөрийнхөө өгсөн өдий төдий хандивыг нотолгоо болгон тоочиж, илүү сайхан харш авах эрхтэй хэмээн мэдэгдсэн гэнэ.

“Энэ бүхэн чинь дэлхий дээр нямбай гэгч нь цэдэглэгдээд чиний алдар нэрэн дээр шагнал болон нэмэгдээгүй гэж үү?” хэмээн хаалганы сахиул асуулаа. “Эдгээрийн төлөө чи шагналаа авчихсан шүү дээ. Чи хоёр дахин төлбөр авмаар эсвэл хоёр дахин шагнуулмаар байна гэж үү?”¹

Энэ удаагийн Христийн мэндэлсний баярын үеэр бидний хүн нэг бүр харамгүйгээр өгөх боломжтой байхад би найдаж байна.

Амлалтыг олж авах нь

Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртэхдээ өөрсдийн амьдрал дахь Аврагчийн төрөлтийн амлалтыг шинэчилдэг билээ. Бид Түүний нэрийг өөрсдөдөө авч, дуулгавартай байдлын гэрээ болон Түүнийг үргэлж санана гэсэн амлалтаа шинэчилдэг.

Сургаал ба Гэрээнд цэдэглэгдсэн сайн мэдээнд:

“Ийнхүү тэрээр, бүр Есүс, дэлхийн төлөө цовдлогдохоор, мөн дэлхийн нүглүүдийг үүрэхээр, мөн дэлхийг ариусгахаар, мөн үүнийг бүхий л шударга бус явдлаас нь цэвэрлэхээр дэлхийд ирсэн бөлгөө;

“Түүгээр дамжин бүгдээрээ аврагдаж болох бөлгөө” (С ба Г 76:41–42) хэмээн өгүүлжээ.

Аврагч Эцэгийнхээ хүслийг биелүүлсэн шиг бид энэ удаагийн Христийн мэндэлсний баярын үеэр Түүний хүслийг биелүүлж, Түүнийг дагах гэрээгээ шинэчлэх цаг гаргах болтугай. Бид ингэснээрээ, Аврагчийн төрөлтөөс 125 жилийн өмнө цэдэглэгдсэн Хаан Бэнжаминь хүмүүсийн дараах үгс бидэнд өнөөдөр биелэгдэх болно: “Ай нигүүлсэж хайрла, мөн бид нүглүүддээ уучлалыг хүлээж авч болохын тулд мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч; учир нь бид Есүс Христэд, тэнгэр ба газар, мөн бүх зүйлийг бүтээсэн Бурханы Хүүд хүмүүний үрсийн дунд доош ирэх түүнд итгэдэг” (Мозая 4:2).

Аврагч цаг хугацааны голчид ирсэн бөгөөд Тэрээр дахин ирэх болно гэдгийг би гэрчилж байна. Түүний сүм бол Түүний Хоёр дахь ирэлтийн өмнөх эцсийн эрин үед сэргээгдсэн, хожмын үеийн гэгээнтнүүд бидний оролцох ёстой “ер бусын ажил мөн гайхамшиг” (2 Нифай 25:17) гэдгийг би гэрчилж байна. ■

ЭШЛЭЛ

1. Хэнри Ван Дайк, “The Mansion,” *Inspirational Classics for Latter-day Saints*, эмхэтгэсэн Жэк М.Лион (2000), 54–57, 62–63-р хуудсууд.



Арванхоёр
Төлөөлөгчийн чуулгын
Ахлагч
Жэффри Р.Холланд

ХОЁР ДАХЬ ИРЭЛТЭД бэлтгэх нь

Өнгөрсөн үеийн агуу эрэгтэй, эмэгтэйчүүд өөрсдийгөө бус харин та нарыг амжилтад хүрнэ гэдгийг мэдэж байсан учраас тэд үргэлж урагшилж, гэрчлэн, бүхнийг хамгийн сайнаар хийхийг хичээж байсан юм.

Бид хүн төрөлхтөнд өгөгдсөн сайн мэдээний хамгийн агуу эрин үед мөнх бус амьдралд ирсэн бөгөөд энэ үеийг хамгийн сайнаар ашиглах хэрэгтэй.

Би бошиглогч Иосеф Смитийн хэлсэн дараах үгэнд дуртай. Эртний бошиглогч, санваартан болон хаад “өдгөө бидний амьдарч байгаа үеийг баяртайгаар хүсэн хүлээж, тэнгэрээс Сүнсээр нөлөөлөгдөн, манай өнөө үеийг үзэлгүйгээр хорвоог орхисон юм.”¹ Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф үүнтэй адилаар нотлон хэлэхдээ: “Бурханы мэлмий болон ариун бошиглогчид биднийг харж байгаа. Энэ бол дэлхийн эхлэлээс яригдаж байсан агуу эрин үе билээ” гэжээ.²

Надад эртний эрин үеүдэд амьдарч байсан удирдагч, гэр бүл болон хүмүүсийн тухай бодит үзэл бодол байдаг. Би тэдний тухай болон тэдэнд тулгарсан сүйрлийн нөхцөл байдлын талаар боддог байсан. Тэд аймшигтэй хүнд цаг үеийг туулсан бөгөөд ихэнх нь өөрсдийн эрин үедээ амжилтад хүрээгүй юм. Үнэндээ энэхүү хожмын өдрүүд дэх сайн мэдээний сэргээлтийн бүхэл үзэл санаа нь сайн мэдээ тэрхүү эртний үеүдэд тэсэн үлдэх боломжгүй байсныг харуулдаг. Тиймээс энэ нь эцсийн ялгуусан эрин зуунд сэргээгдэх ёстой байв.

Ялагдашгүй эрин үе

Товчхондоо, ямар нэг урвалт болон сүйрэл нь цаг хугацааны бүхий л үеийн туршид байсан ерөнхий

эрин үе бүрийн эцсийн хувь тавилан байлаа. Гэвч энд би өөрийн үзэл бодлыг тайлбарлая. Миний үзэл бодол бол өнгөрсөн үеийн агуу эрэгтэй, эмэгтэйчүүд болон удирдагчид *өөрсдийгөө* бус харин *та нарыг* амжилтад хүрнэ гэдгийг мэдэж байсан учраас тэд үргэлж урагш давшиж, гэрчлэн, чадах бүхнээ хийхийг хичээж байсан гэдэг явдал юм. Сайн мэдээ ялан дийлэхийг харах шийдэмгий хичээл зүтгэлтэй, дэлхий даяарх олон зуун мянган залуусын сүр жавхлантай цугларалтаас та нарын авдаг шиг тийм агуу урам зориг, найдварыг тэд өөрсдийн нөхцөл байдлаас тийм ч ихээр авдаггүй байсан гэдэгт би итгэдэг.

Моронай өөрийнх нь нь цэдгийг эцсийн өдрүүдэд хүлээн авах бидэнд хандан хэлэхдээ:

“Болгоогтун, та нарын дунд эдгээр зүйлс гарч ирэх тэр өдөр, удахгүй ирэх ёстой түүний талаар Их Эзэн надад агуу хийгээд гайхамшигт зүйлийг үзүүлсэн болой.

“Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” (Мормон 8:34–35) гэжээ.

Аль ч талаас нь авч үзсэн, *бүх* бошиглогч болон эртний төлөөлөгчид амжилт муутай цаг үедээ тэдэнд урам зориг өгч байсан үзэгдэлд манай өнөө үеийг харж байсан гэж би үнэхээр боддог. Тэдгээр эртний ах нар биднийг гайхмаар үй олуулаа болно гэдгийг мэдэж байжээ.



Моше, Нифай, Жаредын ах зэрэг бошиглогчид хожмын өдрүүдийг үзэгдэлд үнэхээр гайхмаар нарийн тодорхой харсан юм. Тэдний харсан зүйлсийн зарим нь тийм ч таатай байгаагүй ч эртний бүх эрин үеүд эцсийн эцэст ялагдашгүй нэгэн эрин үе байх болно гэсэн мэдлэгээс урам зориг, итгэл найдвар авч байсан юм.

Тэдэнд “тэнгэрлэг, баяр хөөртэй хүсэн хүлээлтийг” өгч, ялалтыг дуулж мөн бошиглоход хүргэсэн тэр өдөр нь тэднийх бус харин бидний өдөр байсан юм. Цаг хугацааны эхлэлээс бид бүгдийн тухай бошиглогчид харсаар ирсэн бөгөөд эртний тэдгээр ах нар биднийг зоригжуулан, дэмжсэн хэвээр байгаа өнөө үе бол бидний үе! Тэд өөрсдийн бүхий л амжилтыг бидний итгэлтэй байдал болон ялалтад нөлөөлөх болно гэж үздэг байсан нь үнэхээр бодитой юм. Алма, Абинадай нар болон тэдний гуйн залбирдаг байсан зүйлсийг бас Петр, Паул хоёр болон тэдний хийсэн золиослолуудыг санан, эцсийн өдрүүдийн тулалдаанд оролцох тухай санаа надад таалагддаг. Түүхийн үйл явдлыг ийм байдлаар дүрсэлсэнд та сэтгэл догдлохгүй байж чадна гэж үү!

Христийн сүмийг Түүний ирэлтэд бэлтгэх нь

Манай эрин үеийн хэтийн төлвийн талаар энэхүү үзэл бодлын өөр нэг талыг би энд дурдья. Бүх эрин үеүдээс эцсийн бөгөөд хамгийн агуу нь манай эрин үе учраас, бүх зүйлс бидний үед төгсгөлдөө орж, биелэгдэх учраас эрт үеийн сүмийн гишүүдийн мөрөн дээр байгаагүй нэг тодорхой үүрэг хариуцлага өнөөгийн сүмийн гишүүд бидэнд ноогдож байна. Абрахам

ба Моше, Исаиа ба Езекиел эсвэл бүр Шинэ Гэрээний Иаков болон Иоханы үеийн сүмтэй адилгүй нь, *Бурханы Хургыг Хаадын Хаан, Эздийн Их Эзэний үүргээ Мянган жилд гүйцэтгэхээр Өөрийн биеэр, ялгуусан алдар суундаа залран ирэхэд нь хүлээн авахын тулд Бурханы Хурганы сүмийг бэлтгэх үүрэг хариуцлага бидэнд ноогдож байна.* Өөр ямар ч эрин үед ийм үүрэг байгаагүй.

Бурханы Хургыг Мянган жил дэх үүргээ гүйцэтгэхээр Өөрийн биеэр, ялгуусан алдар суундаа залран ирэхэд нь хүлээн авахын тулд Бурханы Хурганы сүмийг бэлтгэх үүрэг хариуцлага бидэнд ноогдож байна.

Судруудын хэлээр, бид бол сүйт бүсгүйг Хүргэн хүүгийн ирэлтэд бэлтгэж, хуримын найрын урилгад зохистой байх ёстой, бүх түүхийн туршид томилогдсон хүмүүс билээ (Матай 25:1–12; 22:2–14; С ба Г 88:92, 96-р шүлгүүдийг үзнэ үү). Дүгнэж хэлэхэд, бид өөрсдийн амьдралын үед байна уу эсвэл хүүхэд, ач, зээ нарынхаа амьдралын үед байна уу ялгаагүй, ер нь хэдийд ч гэсэн сүмийн хувьд ч, гишүүдийн хувьд ч, Христ бидэн дээр ирж, мэндчилэн, биднийг тэврэн хүлээн авахаар зохистой байх нь бид бүгдийн үүрэг хариуцлага мөн. Тэрхүү ариун мөчид Түүнд толилуулах бидний амьдрал Түүний хувьд зохистой байх ёстой!

Бид Түүгээр хүлээн авагдахуйц байх ёстой

Би өөрийн амьдралыг (бас чадахынхаа хэрээр сүмийн гишүүдийн амьдралыг бэлтгэхэд туслах) тэрхүү урт удаан хугацааны туршид бошиглогдсоор ирсэн өдрийн төлөө, эрх мэдлийн шилжүүлэлтийн төлөө бид Түүний сүмийг Өөрт нь танилцуулахаар бэлтгэх ер бусын үүрэг хариуцлагынхаа сэтгэл догдлом мэдрэмжээр дүүрэн байна.

Христийг ирэхэд Түүний сүмийн гишүүд үнэхээр Түүний сүмийн гишүүд шиг харагдаж мөн тийн үйлдэх ёстой. Мөн бид Түүнд хүлээн авагдахуйц харагдаж бас тийн үйлдэх ёстой билээ. Бид Их Эзэний ажлыг хийж, сургаалуудын дагуу амьдардаг байх ёстой. Тэгвэл Тэр биднийг үнэхээр Өөрийнх нь шавь нар гэдгийг хурдан бөгөөд хялбар таних болно. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх асан ерөнхийлөгч бага Ж.Рэубэн Кларк (1871–1961) зөвлөхдөө: “Бидний итгэлийг танин мэдэхэд хэцүү байх ёсгүй” гэжээ.³

Тийм ээ, хэрэв бид тэрхүү агуу хийгээд эцсийн хоромд бид итгэгчид хэмээн хэлснээс үүнийгээ үйлдлээр харуулах нь дээр. Хоньчин хонио мэддэг. Харин бид тэрхүү агуу өдөр Түүний дагалдагчид гэдгээ үг хэл ба үйлдлээрээ таниулах ёстой.

Хайрт залуу найз нар минь, энэ бол хожмын өдрүүд бөгөөд та бид бүгдээрээ хамгийн шилдэг хожмын үеийн *гэгээнтнүүд* байх ёстой. *Гэгээнтнүүд* гэдэг үгэнд онцгой анхаарал хандуулна уу.

Өнөөгийн юм бүхэн хэзээ дуусч, Христ хэзээ олон түмэнд ялгууснаар харагдаж, Мянган жил эхлэх вэ? Би мэдэхгүй. Миний мэдэх зүйл бол тэрхүү үйл явдлын



Алма, Абинадай нар болон тэдний гуйн залбирдаг байсан зүйлсийг бас Петр, Паул хоёр болон тэдний хийсэн золиослолуудыг санан, эцсийн өдрүүдийн тулалдаанд оролцох тухай санаа надад таалагддаг. Түүхийн үйл явдлыг ийм байдлаар дүрсэлсэнд та сэтгэл догдлохгүй байж чадна гэж үү!

эхлэлийн агшин 193 жилийн өмнө эхэлсэн нь юм. Тэрхүү Анхны үзэгдэл болон түүний дараа тохиосон зүйлсийн үр дүнд өмнө нь байгаагүй бөгөөд итгэлтэй мөн цэвэр ариунаар амьдрахын тулд бидэнд өгөгдсөн үй олон адислалын үед бид аж төрж байна. Иймээс эцэст нь Хүргэн хүү ялгууснаар ирээд биднийг хуримын найранд зүй ёсоор, Өөрийн биеэр урих болно гэдгийг би мэднэ.

Хайрт залуу ах, эгч нар минь ээ, би та бүхэнд өөрийн хайрыг болон Бурхан зөвхөн амьд төдийгүй бас бидэнд хайртай гэсэн гэрчлэлээ үлдээе. Тэр та нарт *хайртай*. Түүний хийдэг юм бүхэн бидний сайн сайхны төлөө, биднийг хамгаалахын төлөө байдаг. Дэлхий нүгэл хилэнц, гай гамшгаар дүүрэн байдаг бол Түүнд ямар ч гэм

нүгэл, хорон санаа байдаггүй. Тэр бидний Эцэг—төгс эцэг бөгөөд шуурганаас биднийг хамгаалах болно.

Бид чухамдаа нэг зүйлийн талаар л санаа зовох хэрэгтэй гэж би боддог. Бидний хүн нэг бүрд бас бидний нөлөөлдөг хүмүүсийн амьдралд энэхүү агуу эрин үеийн бүх адислалууд ирэхийн төлөө бид хэрхэн илүү бүрэн дүүрэн, илүү их итгэлтэйгээр амьдарч чадах вэ?

“Бүү ай, бяцхан сүрэг. . . . Санаа бодол болгондоо [Христ рүү] харагтун; бүү эргэлз, бүү ай.” “Хэчнээн агуу адислалуудыг Эцэг . . . та нарын төлөө бэлтгэснийг та нар хараахан ойлгоогүй байгаа билээ” (С ба Г 6:34, 36; 78:17).

Бидний эрин үе ялагдахгүй бөгөөд Христийн сургаалуудаар

амьдарч, Түүний ажлыг хийдэг хүмүүс Хүргэн хүүг ирэхэд хуримын найрын урилгад тэнцэхээр зохистой байх болно гэдгийг мөн төлөөлөгчийн хувьд би эдгээр зүйлс үнэн гэдэг гэрчлэлээ, адислал болон хайрынхаа хамт үлдээж байна. ■

“*Terror, Triumph, and a Wedding Feast*,” 2004 оны 9-р сарын 12-нд залуучуудад зориулсан Сүмийн Боловсролын Системийн галын дэргэдэх ярилцлагаас. Англи хэлээрх бүрэн эхийг: speeches.byu.edu-аас үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Иосеф Смит, *History of the Church*, 4:609-610-р хуудсууд.
2. Вилфорд Вудрафф, Жэймс Р.Кларкийн эмхтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. (1965-75), 3:258; мөн Гордон Б.Хинкли, “The Dawning of a Brighter Day,” *Ensign*, 2004 оны 5-р сар, 83-р хуудас.
3. Бага Ж.Рэубэн Кларк., *The Charted Course of the Church in Education*, хянан тохиолдуулсан хувилбар (1994), 7-р хуудас.

“Би уруу таталтыг хэрхэн эсэргүүцэх вэ?”

Сонин сонсогдож болох ч уруу таталт нь бидний сүнслэг байдлын өсөлт хөгжилд шаардлагатай зүйл юм. Хэрэв бид уруу татагддаггүй бол сайныг муугаас ялган, сонгох боломжгүй байхсан (С ба Г 29:39-р шүлгийг үзнэ үү). Хэрвээ бид сонголт хийх шаардлагатай болоход сайныг сонгож чадахгүй бол бид сүнслэг байдлын хувьд өсч чадахгүй (2 Nephi 2:11-30-р шүлгүүдийг үзнэ үү).

Уруу таталтыг эсэргүүцэх нэг түлхүүр нь чанд дуулгавартай байдал юм. Хэрэв та зарим үед бууж өгвөл ирээдүйн уруу таталтуудыг эсэргүүцэхэд улам хэцүү болно. Харин та тууштай эсэргүүцвэл улам хүчтэй болж, ирээдүйд уруу таталтуудыг эсэргүүцэх нь хялбар байх болно. Эсэргүүцэх хүч чадлын ихэнх нь Аврагчийн цагаатгал амьдралд тань хэрэгжсэнээр ирдэг. Та Аврагчийн сургаалуудыг судалж, тэдгээрийг дагахын тулд чадах бүхнээ хийсэн үед Их Эзэн таньг уруу таталтуудын эсрэг зогсоход хүчирхэгжүүлнэ.

Судрууд уруу таталтыг эсэргүүцэх өөр аргуудын талаар заадаг:

“Ялан дийлэгч болж гарахын тулд чи ямагт залбир; тийм ээ, чи Сатаныг ялж гарахын тулд” (С ба Г 10:5).

“Бурханы үгийг анхааран сонсох, мөн үүнээс зууран барих хэн боловч, тэд хэзээ ч эрсдэх нь үгүй; бас хортны уруу таталтууд хийгээд галт сумнууд, тэднийг . . . давамгайлах нь ч үгүй” (1 Нифай 15:24).

“Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно” (Иаков 4:7–8).

Түүнчлэн уруу татагдах нь буруу зүйл биш гэдгийг ойлгох нь чухал. Есүс хүртэл уруу татагдаж байсан шүү дээ.

“Тэрээр уруу таталтуудад орсон хэдий ч тэдгээрт анхаарал тавьсан нь үгүй” (С ба Г 20:22). Та тусалцаа авахын тулд Түүний үлгэр жишээг бас судрууд дахь бусад олон хүмүүсийн жишээг ашиглаж болно.

Хүч чадлын төлөө залбир



Бид уруу таталтыг сөрөн зогсохын тулд эхлээд зөв зүйлийг сонгох чин хүсэлтэй байх хэрэгтэй. Нөхцөл байдлыг урьдаас төсөөлж, дараа нь зөв зүйлийг сонгох нь надад тусалдаг. Надад тусалдаг өөр нэг зүйл бол залбирал. Хэрэв бид хүч чадлын төлөө залбирч, сүнслэг тэжээлийг эрэлхийлэн, хаагуур явахаа болгоомжтойгоор сонговол Ариун Сүнс бидний байнгын хамтрагч байж, биднийг сэрэмжлүүлж чадна.

Истэр Г., 18 настай, Доод Саксон, Герман

Бие биедээ тусал



Бид судруудаас өдөр бүр уншиж, залбиран, өөрийгөө хянаж сурахын зэрэгцээ бошиглогчийн үгсийг дагавал уруу таталтуудыг эсэргүүцэж чадна гэж би боддог. Уруу таталтуудыг эсэргүүцэх нь таны итгэлийг хүчирхэгжүүлж, Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээгээ дагах амлалтыг тань харуулдаг. Сүмд найзуудтай байх нь бас бидэнд тусалдаг, яагаад гэвэл бид бие биеэ тулж, дэмжиж чадна. Үгүй гэж хэлэхэд маш их зориг шаарддаг. “Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн” (2 Тимот 1:7) гэдгийг санаарай. Бид уруу таталтыг эсэргүүцсэн үедээ Есүс Христ болон Тэнгэрлэг Эцэгтэй илүү ойртодог.

Нэнси С., 19 настай, Тултитлан, Мексик

Итгэдэг зүйлээ хуваалц

Ахлах сургуулийн ангийн маань ихэнх хүүхдүүд намайг согтууруулах ундаа ууж, порнограф үзэхэд урьдаг байсан. Би үргэлж үгүй гэдэг, учир нь би Аврагч намайг юу хийгээсэй гэж хүсдэгийг мэднэ. Би Түүнийг санаж, гэрээнүүдээ сахидог. Заримдаа найзууд болон ангийнхан маань намайг уруу татдаггүй, яагаад гэвэл тэд намайг ямар сүмд явдгийг аль хэдийн мэддэг болсон. Итгэдэг зүйлс болон гэрчлэлээ бусадтай, ялангуяа найз нар, ангийнхан, хөршүүд болон гэр бүлтэйгээ хуваалцах нь бидний эргэн тойрон дахь уруу таталтыг багасгадаг. Бид сайн мэдээний дагуу амьдарснаар өөрсдийн амьдрал дахь уруу таталтуудыг ялж чадна гэдгийг би мэднэ.

Ромео Р., 19 настай, Баруун Нэгрос, Филиппин



**ИТГЭЛЭЭ
ЭРТХЭН
ХӨГЖҮҮЛЭХЭЭР
ШИЙД**

“Мөнх амьдралын
замыг сонгохын тулд

Их Эзэн Есүс Христэд итгэх гуйвшгүй бат бөх итгэлтэй байх хэрэгтэй. . . . Энэ нь Бурханы хүслийг биелүүлэх хүч чадлыг төлөвшүүлэх тэрхүү итгэл дээр үйлдсэнээр ирдэг. Мөн бид Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлснээр уруу таталтыг эсэргүүцэж, цагаатгалаар дамжуулан уучлалыг хүлээн авч чадна. . . .

“Уруу таталтыг эсэргүүцэх хамгийн сайн цаг нь эртнээс эхлэх явдал. Харин наманчлах хамгийн сайн цаг нь яг одоо юм. Бидний бодгалийн дайсан биднийг уруу татахаар оюунд минь муу бодлуудыг төрүүлдэг. Чөтгөр өөрийн үйлдлүүдийг хийхээс өмнө бид амжиж, ийм муу бодлыг өөрөөсөө зайлуулахын тулд итгэлээ эртхэн хөгжүүлэхээр шийдэж чадна.”

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, “Spiritual Preparedness: Эрт эхэлж, эхэлсэн зүйдээ тууштай бай,” Лиэхона, 2005 оны 11-р сар, 38, 40-р хуудсууд.

Ариун Сүнснийг сонс

Уруу таталт ирэхэд Ариун Сүнс бидэнд зөв зүйлийг сонго хэмээн анхааруулдгийг би мэдсэн. Сүнснийг өөртэйгөө хамт байлгаж, залбирах, судар унших гэх мэт зүйлсийг хийж, Ариун Сүнс орших боломжгүй газруудаас зайлсхий.

Рахел О., 13 настай, Пенсилвани, АНУ

Ариун газруудад зогсогтон



Ах минь надад “Ариун газруудад зогс” гэж үргэлж хэлдэг. Энэ нь уруу таталт бага эсвэл их биш газар байхыг хэлнэ гэж би ойлгодог.

Манай гадасны ерөнхийлөгч “Уруу таталттай зөвхөн тэмцэх төдийгүй, түүнээс зайлсхий” гэж хэлдэг байсан. Уруу таталттай тэмцэх үе танд тохиолдох ч уруу таталтууд таныг сорихоор хажууд чинь байхгүй бол сайн мэдээгээр амьдрах нь илүү амар хялбар байдаг.

Аарон А., 18 настай, Юта, АНУ

Бид үргэлж шийдэх хэрэгтэй болдог

Ариун Сүнсний бэлэг бидэнд сайн муугийн хоорондох ялгааг ойлгуулж, уруу татагдсан үедээ түүнийг ялган танихад тусалдаг. Уруу таталт бол сорилт бөгөөд энэ нь бид хэзээ зөв мөн буруу зүйл хийж байгааг мэдэхэд тусалдгийг бид санах ёстой. Хэрэв бид Их Эзэнийг дагавал Тэрээр хэр чадлаас минь хэтэрсэн сорилтод биднийг оруулахгүй гэдгийг мэдэх хэрэгтэй (1 Коринт 10:13-р шүлгийг үзнэ үү). Бид үргэлж сайн замыг сонгох уу эсвэл муут нь сонгох уу гэдгээ шийдэх хэрэгтэй болдог.

Жуан Т., 19 настай, Монтэвидео, Уругвай

Зөвийг сонгох жүжигчилсэн тоглолт



Би сонголттой учрахаасаа өмнө юуг сонгохоо шийдэх нь чухал гэж боддог. Би санамсаргүйгээр нэг адармаатай нөхцөл

байдалтай тулгарсан юм. Гэвч би аль хэдийн жишгээсээ ухрахгүй гэсэн шийдвэр гаргасан байсан болохоор үр дүн нь сайн болсон. Хэдийгээр надад заримдаа хэцүү байдаг ч манай гэр бүл тийм нөхцөлд байгаа тухай жүжигчилсэн тоглолт хийж харуулдаг учраас би уруу таталттай тулгарсан үед юу хэлэх, юу хийхээ мэддэг.

Эмили П., 14 настай, Вайомин, АНУ

Сайн найзуудтай бай

Зөвийг сонгодог сайн найзуудтай байх нь уруу таталтыг эсэргүүцэхийн тулд чиний хийх нэг зүйл юм. Сайн найз нар сайн үлгэр жишээ үзүүлдэг. Хэрэв чи уруу таталтад орвол тэднийг дуудаж болно. Тэд зөвийг сонгоход чинь тусална. Сайн найзууд танд залбирч, судраас уншин, дуулгавартай байхыг сануулж чадна.

Сэм И., 17 настай, Вашингтон, АНУ

ХАРИУЛАХ АСУУЛТ

“Би сүмийн жишгүүдийг дагаснаас болж, сургууль дээр шоолуулах үед яах ёстой вэ?”

Хариултаа liahona.lds.org эсвэл liahona@ldschurch.org эсвэл 3-р хуудсан дахь хаягаар хэрвээ хүсвэл өндөр нягтралтай зургийн хамт 2014 оны 1-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Хариулыг хэмжээ тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).



Далын
Ахлагч
Брэдли Д.Фостэр

ЗАМЫН ТӨГСГӨЛӨӨС

харагдах байдал

Замын төгсгөлөөс ирэх захиас тун тодорхой: “Та үүнийг хийж чадна. Тэгээд та үүнийг хийвэл бүх зүйл сайжрах болно.”

Бишоп оо, би таныг хэзээ ч мартаггүй. Та миний амьдралыг аварсан шүү дээ.”

Өнөөдөр ийм үг хэлж байгаа хүнд эхний үед ийм мэдрэмж төрдөггүй. Тэр өсвөр насны хүүхэд байхдаа айдаг байжээ. Тэрээр наманчлах хэрэгтэйгээ мэдэж байв. Тэр үед би түүний бишоп байсан. Тиймээс бид ярилцах хэрэгтэйг тэр мэдэж байсан ч маш их эргэлзэж байлаа.

“Бишоп миний тухай юу гэж бодох бол?”

“Тэр үүнийг нууцлах болов уу?”

“Би түүний нүүрийг дахиад яаж харах юм бэ?”

Иймэрхүү санаа зоволтууд үнэхээр хэцүү бөгөөд энэ нь наманчлалын замаар аялах зоригтой байдлыг бараг боломжгүй болгодог.

Замыг харах нь

Гэвч тэр зам руу хараад үзье л дээ. Наманчлалын зарим хэсгүүд бусдаасаа хавьгүй хялбар байдаг. Эхний алхам нь хүлээн зөвшөөрөх. Бид буруу зүйл хийж байгаагаа ихэвчлэн мэддэг ба Ариун Сүнс бидэнд үүнийг мэдрэхэд тусалдаг. Бид өөрчлөгдөх ёстой. Өөрчлөгдөх хүсэл ихэнхдээ их хүчтэй байдаг.

Харин дараачийн алхмууд илүү хэцүү юм. Их Эзэн биднийг гэм буруугаа хүлээсний дараа үүнийгээ орхи гэдэг. Бид Тэнгэрлэг Эцэгт хандсан залбирлаараа дамжуулан, нүглээ хүлээх нь нэлээд амар хялбар юм. Бид энэ замаар уучлалыг эрэлхийлж, бусдад учруулсан хохирлыг арилган, зан төлвөө сайжруулах замаар чадах бүхнээ хийснийг Сүнс батлах хүртэл олон нүглээ залруулж чадна.

Гэвч зарим тохиолдолд гэм буруугаа хүлээхдээ бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгээ ярилцахыг шаарддаг. Энэ залуу эрэгтэй чухам ингэх хэрэгтэй байлаа. Түүнд өөрийнх нь чадвараас илүү тусламж хэрэгтэй байсан бөгөөд наманчлалын замаар аялах нь боломжтойг тэр мэдэх хэрэгтэй байв.

Наманчлалын зам дээрх найдвар

Наманчлалын замаар аялсан хүмүүс танд хэлэх болно, энэхүү аялал боломжтой төдийгүй та тэнд очоод эргээд харвал дараах зүйлийг харах болно:

Та нар үүнийг хийж чадна! Тэгээд та үүнийг хийвэл бүх зүйл сайжрах болно.

Их Эзэн бидэнд хайртай учраас бидэнд наманчлахыг зарлиг

болгодог юм. Их Эзэн цагаатгалаараа дамжуулан, бидний нүглийн төлөөсийг төлсөн учраас наманчлал биднийг нүглээс чөлөөлдгийг Тэр мэддэг билээ. Өөрт нь хандсан хүн бүрийг Тэр хүчирхэгжүүлэх болно. Бид цагаатгалын давуу талыг ашиглахын тулд хүн бүр наманчлах ёстойг Алма заасан билээ (Алма 5:33–34-р шүлгүүдийг үзнэ үү). Энэ зам хэцүү байж болох ч бишоп тантай хамт уг замаар алхах болно. Тэр замын дагуу тусламж *бий*.



БИД ИНЭЭМСЭГЛЭХ ХЭРЭГТЭЙ

“Наманчлал нь бурханлаг бэлэг бөгөөд бид наманчлалын тухай ярихдаа ямагт инээмсэглэх хэрэгтэй.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон, “Наманчлалын бурханлаг бэлэг,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 45-р хуудас.



Таныг наманчилж эхэлмэгц сэтгэл санаа тань хөнгөрөөд явчихна.

Бишопдоо хандагтун. Тэр өөрийг тань хайрлаж, хүндлэх болно. Бишопдоо найдах таны бий болгосон найдвар бат бөх юм. Энэ нь танд үүрд оршиж, ирээдүйд бусад бишопуудаас ч өөрийнхөө талаар ийм найдварыг мэдрэхэд тань туслах болно. Адармаатай асуудлууд бий болох нөхцөл байдлаас хамааран, хэтийн төлөв тань өөр байх болно. Бишоп мэргэн ухаан ба туршлагаараа түүнчлэн Их Эзэний сүнсний нөлөөгөөр танд дэлхийн төгсгөл гэх мэт боломжгүй хэмээн бодож байсан зүйл тань магадгүй зөвхөн зам дээрх ердийн нэг овгор байсныг ойлгоход тань туслах болно.

Аврагч бол үнэхээр Дэлхийн Гэрэл гэдгийг ойлгоход тань бишоп тусална. Цагаатгалын давуу талыг ашигласнаар амьдрал тань гэрэл гэгээтэй, ирээдүй тань бат найдвартай болж, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлэх нь дэлхий дээр ирж амьдарсны хамгийн агуу зорилгуудын нэг гэдгийг та ухаарах болно.

Энэхүү үйл явцаар дамжуулан, бишоп тань танд туслах болно. Та түүнийг хайрладаг болж, тэгээд хэзээ ч мартахгүй.

Хүнд хэцүү цагт танд тусалсан хүмүүс тантай сэтгэл зүрхээрээ холбогддог гэдэгт би бат итгэдэг. Тэгэхээр бишоп таны сүнслэг байдлын хямралд цэг тавихад тусалснаараа тантай үүнээс ч илүү их холбоотой болох биш үү? Их Эзэн бишопын нинжин сэтгэл хийгээд өөрийг тань удирдан залах түүний чадварыг өсгөн нэмэгдүүлж чадна. Бишоп тань таны үүрдийн найз байх болно.

Тэгэхээр залуу эрэгтэйчүүд минь, нэгэн өдөр та нар өөрсдөө бишоп бас гадасны ерөнхийлөгчид болоход бишоптойгоо хамт туулсан туршлага тань магадгүй та нарыг сайн бишоп эсвэл гадасны сайн ерөнхийлөгч болоход бэлтгэх болно.


Би нөгөөх залуу эрэгтэйтэй уулзсан тухайгаа дахин хэдэн үг хэлээд яриагаа дуусгая. “Бишоп оо, та миний ярих зүйлээс болоод намайг үзэн ядна даа. Та над руу хэзээ ч дахиж харахгүй бас хэрвээ та миний хэлснийг хэн нэгэнд хэлбэл би амиа хорлох болно” гэж тэр хэлж билээ.

Би түүнд “Би чиний итгэлээс хэзээ ч урвахгүй гэж амлая. Би чиний хэлснийг үүрд дотроо хадгална” гэлээ.

Тэр надад ач холбогдол багатай зарим жижиг сажиг нөхцлүүдийн тухай яриад миний юу гэхийг ажиглав. Намайг түүнд “Би чамд ямар байгааг мэдэж байна. Би чамд тусалж чадна” гэхэд тэр яг ярихыг хүссэн зүйлдээ ортол тун аажуухан ярилаа. Тэр залуу гэм нүглээ хүлээж, өөрчлөгдөхийг үнэхээр хүсч байгаад нь бахархаж байгаагаа би түүнд дахин дахин хэлэв. Хэдийгээр тэр хэзээ ч гүйгээд явчихад бэлэн байдалтай харагдаж байсан ч бид хамтдаа түүний хуваалцах хэрэгтэй зүйлсийг ярилцаж амжив.

Энэ нь тийм ноцтой хэрэг явдал байв уу? Түүнд л тийм байсан. Гэвч тэр надад ярилцах үедээ Их Эзэн чин сэтгэлээсээ наманчилдаг хүмүүст нигүүлсэнгүй ханддагийг илүү сайн ойлгосон юм. Түүний анхны уулзалтаас хойш бид хамтдаа ажиллаж, цаг хугацаа өнгөрөхөд түүний наманчлал бүрэн болсон билээ. Өнөөдөр ч гэсэн тэр над руу утасдаг ба бидний яриа аз жаргалтай байдаг.

Бид бүгдээрээ цагаатгалаас хамааралтай байдгийг ойлгоход нь би түүнд туслах боломжтой байв. Тэр залуугийн амьдралыг аварсан Есүс Христийг магтан дуулах түүний магтаалд би тийнхүү дуу хоолойгоо нэгтгэсэн юм. ■




Би залуу
эмэгтэйн хувьд
порнографтай
тэмцэнэ гэж хэзээ
ч бодож байгаагүй.

Би порнографт донтох нь охи-
дод асуудал уддаг гэж хэзээ ч
бодож байсангүй. Намайг 16
настай байхад миний буруу гэдэг нь
нотлогдсон юм. Нэг удаа би порног-
рафын видео бичлэгтэй байж таа-
раад, ганцаараа байсан болохоор
сонирхоод үзчихэв. Түүнээс хойш
би тийм видео бичлэгийг өдөр бүр
үзмээр санагддаг боллоо. Тэгээд би
порнографт донтсон юм.

Порнограф үзэх нь надад муу-
хай санагддаг болов. Би үүнийг
буруу гэдгийг мэдсэн ч өөрчлөгдөх
талаар юу ч хийсэнгүй. Би хэзээ

ДАХИАД ДОНТОХГҮЙ: Порнографыг ялсан миний замнал

Нэрийг нууцлав



НАМАНЧЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

“Та нар нүглээ наманчилснаар цагаатгалаар дамжуулан уучлалыг хүлээн авч, гэм нүглээсээ цэвэршиж чадна.

“Наманчлал нь гэм буруугаа зүгээр л хүлээхээс илүү чухал зүйл. . . Энэ нь нүглээ орхиж, уучлалын төлөө Бурхан руу эргэх явдал юм. . . .

“ . . . Хэрэв та нар гэм нүгэл үйлдсэн бол хэр зэрэг хурдан наманчилна, уучлалаас ирэх амар амгалан, баяр баяслыг төдий чинээ хурдан олно. . . .

“ . . . Та наманчлах үедээ эцэг эхийнхээ тусламж зөвлөгөөг хүсээрэй. Бэлгийн харьцааны гэм нүгэл болон садар самуун зүйлсийг хэрэглэсэн ноцтой гэм нүглүүдээ бишопдоо хүлээх хэрэгтэй. Түүнтэй ярилцахдаа бүх үнэнээ хэл. Наманчлахад чинь тэр чамд тусална.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 28,29-р хуудсууд.

ч аз жаргалтай байсангүй, Сатаны бузар уруу татаалт надад халдварлаж, олиггүй муухай мэдрэмж сэтгэл эмзэглүүлдэг байсан ч л хүслээ хангахын тулд порнограф үзсээр байлаа. Донтолт намайг улам бүр буруу үйлдлүүд рүү хөтөлж байв. Би хүн бүхэнд: ахдаа, ээждээ, хамгийн муухай нь Их Эзэнд болон өөртөө худлаа хэлдэг болов. Би дахиад ганц кино үзэхэд эсвэл дахиад ёс суртахуунгүй ганц түүх уншихад надад муу юм юу л болов гэж хэмээн өөртөө хэлдэг байлаа.

Би сүм, мючел болон семинарт явдаг байсан ч надад Сүнс ч, зөв хандлага ч байсангүй. Дургүйд хүчгүй гэгчээр би хичээлээс юу ч олж авч чадсангүй. Би аравны нэгээ төлөх, залбирах бас судар уншихаа болилоо. Би гэм буруугаа мэдэрч байсан ч хаяж чадахгүй хэвээрээ байлаа. Тэгээд би гэдэг хүн өдөр ирэх тутам дордсоор байв.

Яваандаа порнограф үзэх миний боломж хязгаарлагдав. Эхэндээ порнограф үзэхгүй бол утгагүй, хоосон, донгио юм шиг санагддаг байсан ч би бас юмс сайнаар өөрчлөгдөж байгааг анзаарсан юм. Миний байдал өөрчлөгдөж эхэллээ. Би өдөр бүр порнограф үзэхээ болив. Порнограф үзэх хүсэл надад байсаар байсан ч би үүнийг эсэргүүцэхдээ яггүй сайн болсон юм. Эцэст нь би хоёр жилийн турш порнографт донтсоны дараа хүч чадлын төлөө үргэлж залбирч, порнограф үзэхээ бүрмөсөн больсон ч дотор сэтгэлээс минь олиггүй муухай мэдрэмж арилахгүй болсон байв. Би бишоптой ярилцах хэрэгтэй гэдгээ мэдэж байсан ч нэг л болж өгөхгүй байв.

Эцэст нь, олон хүн наманчлалын үйл явцаар дамжуулан, сорилт бэрхшээлээ даван туулсан тухайгаа ярихыг сонсоод би бишоптойгоо үнэхээр уулзах хэрэгтэй гэж бодлоо.

Түүнчлэн би сүм дэх нэгэн агуу адислал болох патриархын адислалаа аваагүй байгаагаа ухаарлаа.

Би бишоптойгоо уулзахаар цаг товлов.

Ярилцлага болох орой би бишопынхоо өрөө рүү орохоос гэрвшээд байлаа. Тэр над руу хараад л миний нөхцөл найдваргүй бөгөөд намайг гарч чадахааргүй нүх өөртөө ухсаныг хэлэх байх гэхээс би айж байсан. Тэр над руу хэзээ ч өмнөх шигээ харахгүй болов уу гэхээс л би айгаад байлаа. Гэвч би түүнд бүх түүхээ ярихад тэр над руу элэгсгээр инээмсэглэн, анхааралтай сонсов. Бишоп надад үнэхээр чин сэтгэлээсээ санаа тавьж байлаа. Бишоптойгоо ярилцаж, хэдэн зүйл дээр ажилласны дараа, эцэст нь тэр намайг цэвэр ариун болсныг хэллээ.

Порнографт донтсон жилүүд амьдралын минь хамгийн хүнд үе байсан ч бишопын өрөөнөөс цэвэр ариун мэдрэмжтэй гарч ирэхэд надад үнэхээр сайхан байсан шүү. Олон жил үүрсэн ачаа дарамт мөрөн дээрээс минь авагдчих шиг санагдаж билээ. Би патриархын адислалаа авч, ариун ёслолоос зохистойгоор хүртэн, Сүнстэй дахин хамт байх болсондоо баяртай байлаа. Би чухамдаа шинэ хүн болсон юм шиг мэдрэмж төрж байсан. Хүмүүс намайг хэрхэн өөр болсныг бас өмнө нь байгаагүй өөр гэрэл цацарч байгааг хүртэл хэлдэг байв. Би үргэлж аз жаргалтай байж, бүх зүйл дээр илүү сайн хандлагатай байх болсон.

Бид Их Эзэний тусламжтайгаар өөрчлөгдөж, донтолтыг даван туулж чадна гэдгийг би мэднэ. Мөн бид бишоптойгоо уулзахаас санаа зовох хэрэггүй, учир нь түүнийг бидэнд наманчлахад туслах үед бид Есүс Христийн Цагаатгалаар дамжин, дахин цэвэр ариун болж чадна. ■

Зүгээр нэг туслагч БИШ

Чи гэрийн багшлалт хийхдээ
өөрийгөө хамтрагчийнхаа
зүгээр л нэг туслагч гэж
богдог уу? Дахиад нэг
богдоог үз гээ.

“Би хэрхэн найз бөгөөд гэрийн багш
байхыг мэднэ. Би бусдад туслахын тулд
юу хийж болохыг мэдэхэд дуртай.”



Та дараах дүр зургийг ном эсвэл киноноос олон удаа үзсэн биз ээ. Холоос нүүгэлтэн дөхөх аянгын бараан үүлс лүгээ адил айдас төрүүлэм хүнд асуудал, бэрхшээл бий болоход гай зовлон, гамшиг аюул зайлшгүй мэт санагдана. Тэгтэл нэгэн баатар эр гарч ирээд дайснаа дарж, дархан цолоо мандуулна.

Ийм баатрууд ихэвчлэн туслагчтай байдаг. Тэрхүү туслагч ихэвчлэн багахан чадалтай ч сайхь баатарт аюул учрах үед түүнд тусалдаг.

Гэрийн багшлаалтад бага хамтрагч нь өөрийгөө ахлах хамтрагчдаа зөвхөн туслах үүрэгтэй гэж бодвол энэ нь уруу таталт болж мэднэ. Эцэст нь, насанд хүрсэн хамтрагч тань гэрийн багшаар чамаас илүү олон жил ажилласан, илүү туршлагатай байгаа. Тиймээс асуудлыг шийдэхэд зөвхөн тэр л баатрын үүргээ бие-лүүлэх ёстой гэсэн үг үү?

Яг тийм биш.

Гэрийн багшлаалтад ямар ч гарамгай баатар (таны ахлах хамтрагч),

түүний туслагч (чи) гэж байхгүй. Харин хоёул хамтдаа дэлхийг үнэхээр өөрчилж чадах хоёр гарамгай баатар л бий.

Чамайг хэн гэдэг, ямар мэргэжил боловсролтой вэ? гэдгээс үл хамааран, айлчилж очдог хүмүүсийнхээ амьдралыг ихээхэн хэмжээгээр өөрчлөхөд шаардлагатай зүйлс чамд байгаа.

Үүнээс илүү агуу дуудлага байхгүй

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) “Гэрийн багшийн дуудлагаас илүү агуу ямар ч дуудлага сүмд байхгүй” гэжээ.¹

Гэрийн багш нар зөвхөн сүнслэг захиас хуваалцахаас илүү чухал ажил хийдэг. Тэд гэр бүл болгонд тусламж хүсч хандах найзууд бий гэдгийг мэдэхэд нь тэдэнд тусалдаг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Найз бол сар бүрийн үүрэгт айлчлалаас илүү ихийг хийдэг. . . . Найз санаа тавьж, хайрлан, анхааралтай сонсож бас тусалдаг” гэж хэлжээ.²

Мэдээж хэрэг, аль ч насанд агуу нөхөрлөл үүсэн бий болж болно.

Найзын хувьд үйлчлэх нь

АНУ-ын өмнөд Ютагийн 16 настай Шоон С., хэрхэн найз бас гэрийн багш байхыг мэддэг. Шоон



ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦ



Арванхоёрдугаар сарын турш таны Ням гарагийн хичээл Бурханы хаант улсыг байгуулах дээр төвлөрнө. Гэрийн багшлалт нь үүнийг биелүүлэх нэг арга юм. Гэвч хүн бүр өдөр тутмынхаа үйлчлэлээр дамжуулан, Бурханы хаант улсыг байгуулж чадна. Таныг бусдын төлөө залбирахад Сүнс танд хийж болох зүйлийг тань сануулах болтугай. Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертоны энэхүү зөвлөгөөг санагтун: “Эхлээд ажигла, дараа нь үйлчил.”⁴ Та хэзээ Бурханы хаант улсыг байгуулахдаа ажиглаад дараа нь үйлчлэх боломж олж байсан бэ? Тойрог, гэр бүл эсвэл бусад өсвөр үеийнхэнтэй туршлагаа хуваалцахад бэлтгэ.

ковбой уралдаан мөн барилдаан, мал маллах, машин засах зэрэг олон зүйлийг сонирхдог ажээ. Тэр бас гэрийн багшлалтаар очиж, заадаг хүмүүстэйгээ нөхөрлөн, найз болох дуртай.

“Би хүмүүстэй ярилцаж, тэдэнд тусалж болох зүйл хайх дуртай” гэж Шоон хэллээ.

Түүний гэрийн багшийн хамтрагч нь тойргийнх нь бишоп аж. Тэдний очдог нэг айлын эхнэр нь сүмийн гишүүн, харин нөхөр нь гишүүн биш байв. Шоон анхны айлчлалаараа л түүний нөхөр Флойдтой нөхөрлөж амжжээ. Флойдыг өөрийнхөө жийпний тухай ярьж эхлэхэд Шоонд тэр доороо сонирхолтой санагдсан. “Бид зүгээр л хоорондоо эвтэй байсан” гэж Шоон хэллээ.

Шоон, бишоп хоёр Флойдын гэр бүлд гэрийн багшаар очдог байсан тэр жил Шоон тэдэнтэй нөхөрлөлөө улам бэхжүүлжээ. Тэрээр Флойдод хөдөлгүүр засварлахад нь хааяа тусалдаг байв.

Шооны дуртай судруудын нэгд: “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа” (Мозая 2:17) гэж заасан.

“Хүн бүр бусдад үйлчлэх арга зам хайж байх хэрэгтэй” гэж Шоон хэлжээ.

Таны сүнсний бэлгүүд

Бид бүгдэд сүнсний бэлэг болон авьяас чадвар байдаг. Түүнээс гадна бидэнд онцгой сонирхол ба хобби бий. Бидний хүн нэг бүрд бусадтай яг адилхан хийж чадахгүй өвөрмөц зүйл байдаг.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Хүн бүр ялгаатай бөгөөд оруулах хувь нэмэр нь ч бас өөр өөр байдаг.

Хэн ч бүтэлгүйтэхээс ангид төрдөггүй” гэж заасан.³ Гэрийн багшлалт нь таны хувьд бэлгүүдээ бусдад туслахын тулд ашиглах боломж байж болно.

Жишээ нь, сүнслэг захиас хуваалцах таны ээлж болоход та айлчилдаг хүмүүстэй хамгийн хэрэгтэй юуг хэлж болохыг мэдэхийн тулд урьдаас залбирч болно.

Тухайн гэр бүлд заахаар өгөгдсөн сэдвийн тухайд танд ихэвчлэн хувийн туршлага байгаа. Гэрлээ гэрэлтүүл! Мэддэг зүйлээ хуваалц.

Та түүнчлэн айлчилдаг гэр бүлдүүдээ үйлчлэх үр өгөөж, утга учиртай аргуудыг хайн олж болно. Жишээ нь: Гэрийн багшаар томилогдсон гэр бүлдүүдийн чинь нэгэнд гитар сурахыг хүсдэг нэг хүн байна гэж бод. Та олон жил гитар тоглож байгаа нь энэ тухайд азтай тохиолдол юм. Ийм нөхцөлд хөгжмийн талаарх зөвлөгөөг үе үе өгөх нь зам дээрх цасыг нь цэвэрлэж, модыг нь тайрч өгсөнтэй адил тэдэнд хэрэгтэй байж болно.

Гэрийн багшлалт хийхэд ахлах хамтрагч тань үнэхээр сүнсний цахилгаан станц байж болох л доо. Гэхдээ бүү эргэлз. Та Бурханы хүүхэд бөгөөд гэрийн багшийнхаа хувьд үүргээ биелүүлэхдээ эн тэнцүү.

Гэрийн багшлалтад хувь нэмрээ оруулах гайхамшигтай ямар нэг зүйл өөрт тань үргэлж байдаг. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Эзра Тафт Бэнсон, “To the Home Teachers of the Church,” *Ensign*, 1987 оны 5-р сар, 50.
2. Томас С.Монсон, “Home Teaching—a Divine Service,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 47-р хуудас.
3. Хэнри Б.Айринг, “Өндөр зорилго тавихад нь хүүхдүүдээ тусал,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 74-р хуудас.
4. Линда К.Бертон, “Эхлээд ажигла, тэгээд үйлчил,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 93-р хуудас.

АРИУН ГАЗРУУДАД ЗОГСОГТУН



1

Энэ жил сүмийн сэтгүүлүүд дэлхий даяарх өсвөр үеийнхнийг хэрхэн ариун газруудад зогсож байгаагаа харуулсан зургаа илгээхэд урьж байна. Эдгээр зургуудаас өсвөр үеийнхэн 2013 оны мючелийн сэдвийн дагуу амьдралын тулд юу юу хийснийг хараарай.

1 Би сайн үр нөлөөтэй үйл ажиллагаануудад, ялангуяа гэр бүлтэйгээ хамт оролцдог бол ариун газруудад зогсож байгаа нь тэр.

Ларэ Р., 16 настай, Британий Колумб, Канад

2 Би мөнхийн үнэ цэнэтэй зүйлсийг дэлхийн зүйлсээс илүү дээгүүр үнэлснээрээ ариун газарт зогсдог.

Көрк М., 18 настай, Нэгрос Оксидентал, Филиппин

3 Миний хувьд ариун газарт зогсоно гэдэг нь үйлчлэл хийнэ гэсэн үг. Үйлчлэл хийх миний дуртай арга зам бол ариун сүм юм. Би Их Эзэний өргөөнд Их Эзэний ажлыг хийх үеэрээ сүнсийг маш хүчтэйгээр мэдэрдэг.

Киана Б., 15 настай, Юта, АНУ



2



3




4

4 Би баптисм хүртсэн усан сангийнхаа дэргэд зогсож байна. Би энэ усан санг ариун газар гэж боддог. Яагаад гэвэл энд хүмүүс Бурхантай гэрээ хийж, шинэчлэгддэг.
Жөү-Смит Э., 17 настай, Аква Айбом, Нигери



5

5 Би ууланд гарах бүрдээ дэлхийгээс тусгаарлагддаг. Үүнийг би ариун бөгөөд амар тайван газар гэж ойлгодог.
Етта Р., 17 настай, Орегон, АНУ



6

6 Би нар салхинд гарах дуртай, би тиймэрхүү газруудад байхдаа (Ютагийн Моаб дахь нарийхан нуман хаалга) Тэнгэрлэг Эцэгтэйгээ холбоотойгоо бүр илүү мэдэрдэг. Бидэнд зориулан Их Эзэний бүтээсэн гайхамшигтай зүйлсийг харах нь Сүнсийг мэдрэхэд надад тусалдаг.
Жон Т., 18 настай, Юта, АНУ



7

7 Миний гэр орон ариун нандин газар. Би энд аз жаргал ба амар амгаланг мэдэрдэг. Бас би Мормоны номоо унших үед Ариун Сүнсээр дамжуулан нам гүм байдал, амар тайвныг мэдэрдэг.
Мэлиса Д., 13 настай, Козово



8 Энэ бол шинэ эхлэлийн зураг. Миний хувьд сүмийн барилгууд нь залуу эмэгтэйчүүдийн эрхэмлэх зүйлс болон сайн мэдээний зарчмуудаас суралцдаг ариун газар юм. Сүм дээр би түүнчлэн итгэл нэгтэй залуу охидтой нөхөрлөлөө бэхжүүлдэг.

Луйз С., 15 настай, Рио Гранде до Сул, Бразил

9 Би хүмүүст тусалж, найзуудтайгаа хөгжилдөж байхдаа ариун газарт зогсдог.

Жэймс Р., 17 настай, Хойд Каролин, АНУ

10 Би сайн мэдээгээр амьдардаг найзуудтайгаа байхдаа ариун газарт зогсдог. Тэд надад Тэнгэрлэг Эцэгтэйгээ холбоотой байж, Ариун Сүнсийг ихээр мэдрэхэд тусалдаг.

Жонатан Н., 17 настай, Буэнос Айрес, Аргентин

11 Би ариун ёслол дээр төгөлдөр хуур тоглож байхдаа ариун газарт зогсдог. Дууллуудын аялгуу болон үг нь миний итгэл болон гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг юм.

Чэлсиа А., 13 настай, Бантэн, Индонез

12 Би цугласан хүмүүсийг гайхалтайгаар дуулж байхыг сонсоод сэтгэл уяардаг, энэ үедээ би ариун газарт зогсож байдаг.

Жовани В., 15 настай, Бантэн Индонез

13 Би ням гарагуудад чуулгадаа хичээл заах үед ариун газарт зогсдог. Би сайн мэдээг хуваалцах дуртай.

Рамон М., 16 настай, Калифорни, АНУ

БУСАД АРИУН ГАЗРУУД

Бусад өсвөр үеийнхний ". . . байхдаа би ариун газарт зогсдог" өгүүлбэрийг хэрхэн гүйцээсэн тухай дор өгүүлэв.

- "Сайн мэдээг найзуудтайгаа хуваалцсанаараа"
Жон Б., 17 настай, Сизра, Бразил
- "Номлогчидтой хамт ажиллах нь надад сайн мэдээг хуваалцах илүү туршлагыг өгдөг. Би удахгүй бүрэн цагийн номлогч болно."
Жосеф Х., 18 настай, Жакарта, Индонез
- "Би сагсны талбай дээр багийнхандаа тусалж, тэдэнд болон бүр нөгөө багтаа сайн тамирчны үр чадварыг үзүүлснээрээ"
Эмили С., 12 настай, Юта, АНУ
- "Бид ахлах сургуульдаа найрал дуу дуулж, авьяасаа үзүүлснээрээ"
Таннер М., 17 настай; Кэйлин С., 15 настай; Лэкси Ж., 17 настай; Спэнсэр М., 17 настай; Айдахо, АНУ
- "Залуу эмэгтэйчүүдтэй аяллаар явахдаа би өөртэйгөө адилхан жишиг болон эрхэмлэх зүйлстэй залуу эмэгтэйчүүдтэй уулздаг ба бидэнд зарчмуудыг заадаг удирдагчидтай уулзах боломжтой байж, тэгснээрээ бид зөвийг хийхийг сурдаг."
Норма В., 17 настай, Гуаяас, Эквадор
- "Өдрийн турш Ариун Сүнстэй байхад надад тусалдаг учраас би семинарт явснаар"
Саванна Ф., 17 настай, Аризона, АНУ
- "Сургуулиа дэмжих бэлтгэл дээр би өөрийнхөө юунд итгэдгээ багийнхандаа мэдүүлснээр"
Макэнна Ф., 15 настай, Калифорни, АНУ
- "Ариун ёслол түгээж, Есүс Христийн цагаатгалыг дурсан санахдаа"
Аксэл С., 14 настай, Жакарта, Индонез
- "Би өөрийгөө цэвэр байлгаж, зөвийг сонгосноор хэзээ нэг өдөр ариун сүмд гэрлэж чадна гэдгээ мэднэ, тийм учраас үүнийг үргэлжлүүлэн хийхдээ"
Витни Х., 15 настай, Юта, АНУ
- "Би Бурхантай хийсэн гэрээгээ сахиснаар"
Марк М., 17 настай, Орегон, АНУ

Одоо *та нар* энэ жилийн мючелийн сэдвээс сурсан зүйлийнхээ талаар бод. Та нарын ариун газрууд юу байж болох вэ? Та нар ариун газарт хэрхэн байнга зогсож чадах вэ? Бодол санаагаа өдрийн тэмдэглэлдээ бичээрэй.





Христийн мэндэлсний баярын дуртай дуу

С. Г. Линдстром

Б и үүнийг байдаг л нэг тойргийн Христийн мэндэлсний баярын үдэшлэг байсныг санаж байна: улаан, ногоон бүтээлэгтэй ширээнүүд, цаасан тавган дахь оройн хоол, гүйдсэн жаахан хүүхдүүд, тойргийн гишүүдийн ярилцах баяр хөөртэй дуу чимээ. Хэн нэг нь чимээ шуугианыг намжаан, хоолоо адисалж, тэгээд хүн бүр идэцгээлээ. Хөтөлбөр эхлэх дөхөж байв.

Энэ тойрог манай тойрог биш байсан юм. Би найзтайгаа хамт тойргийнх нь үдэшлэгт ирсэн учраас олон хүнийг танихгүй байв. Бид эртхэн явахыг хүссэн ч найзын маань ээж биднийг хөтөлбөрийг үзээч гэж ятгав.

Хөтөлбөрийн эхний дугаар нь Хүүхдийн хэсгийн хүүхдүүдийнх байлаа. Тэд толгойдоо гялтганасан алтан цагираг өмсөн, тайзан дээр гарч ирэв. Хүүхдүүд дуулж дуусаад жижигхэн алтан одод унагаж, бие бие рүүгээ харайн, хөхрөлдсөөр тайзнаас буулаа.

Дараа нь хоёр төгөлдөр хуурч баяр хөөртэй дуу тоглов. Эхний төгөлдөр хуурч “Oh, Come, All Ye Faithful” (*Hymns*, no. 202) дууг нэг ч ноот алдалгүй тоглолоо. Нөгөө төгөлдөр хуурч, жаахан хүү

төгөлдөр хуурын ард суугаад ээж рүүгээ сэтгэл түгшсэн янзтай харснаа хэмнэлээ чимээгүй тоолж эхлэв. Хүү санаа алдан, хөгжим рүүгээ эргээд “Up on the Housetop” дууг байдаг чадлаараа тоглолоо.

Дараагийн хөтөлбөр нь миний дуртай дуунуудын нэг—“Христийн мэндэлсний баяр” байсан юм.

Би харахаар өндийтөл бөгтөр мөртэй, нэг гараа биендээ наасан эгч эв хавгүй алхлан, төгөлдөр хуурын дэргэд ирж, зогсов. Тэр эгч хаагай зогсоод, эхлэхээсээ өмнө гилжийн, инээмсэглэлээ. Би түүний дуу сайхан байх болов уу гэж бодсон нь буруу байжээ.

“Намайг залуу байхад Христийн мэндэлсний баяр гайхалтай сайхан болдог байлаа” хэмээн тэр дуулаа. Дуу цааш үргэлжлэн, хүүхэд хэрхэн *Христийн мэндэлсний баяр* гэдэг үгийг хэлж сурдаг мөн энэ баяр чухам юуны тухай болохыг хэрхэн олж мэддэг тухай өгүүллээ.

Түүний уруул нэг тийшээ унжсан нь дуу дуулахад хэцүү байв.

Би өрөөн дэх гишүүдийн нүүрийг гярхай ажиглалаа. Хэн ч ичиж зовсон шинжгүй байв. Харин ч тэд инээмсэглэн, баяртайгаар сонсож байлаа.

Би түүнийг
хэнд хандан
дуулж байгааг
нь ойлгох
хүртлээ
түүний дуунд
талархсангүй.


Тэр эгч дуулахаа үргэлжлүүлэн, толгойгоо өргөөд, таазны нэг цэг рүү эгцлэн харж байлаа. Хэдэн хормын дараа би ч бас дээшээ хартал зөвхөн тааз л харагдлаа. Би эргээд түүн рүү хартал түүний нүдэнд нулимс цийлэгнэж байгааг ажиглав.

Түүнийг дуусахад хүн бүр алга ташлаа. Түүний хацар улайсан байв. Түүнийг суудал руугаа явж байхад тойргийн гишүүд гар мөрөнд нь хүрч, чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байлаа. Миний ойролцоо сууж байсан нэг эгч түүнийг сайхан дуулаа шүү гэхэд “Баярлалаа, Түүнд миний дуу таалагдсан гэдэгт найдаж байна” гэж нөгөөх эгч хариулав.

Түүнд ээ? Тэр хэнд зориулж дуулсан юм бол? гэж би өөрөөсөө асуулаа. Хариулыг нь би мэдэж байлаа. Тэр эгч танхимд байсан хүмүүсийн хэнд нь ч хандаж дуулаагүйг би ойлголоо. Тэр үзэгчдийн сайшаалыг авахын тулд дуулаагүй юм. Тэр Аврагчийг бишрэн шүтэхийн тулд дуулжээ.

Тэр тойргийн үдэшлэгээс хойш олон ч Христийн мэндэлсний баяр болж, би “Христийн мэндэлсний баяр” дууг сайн бэлдсэн олон хүн дуулахыг сонссон. Гэвч тэр нэгэн Христийн мэндэлсний баяраар эгэл жирийн тэр нэгэн эгчийн дуулсан үнэнхүү чин сэтгэлийн нөгөөх дууг би тодоос тод санадаг билээ. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Вашингтонд амьдардаг.



Миний ах НОМЛОГЧ



Кэвин В., 11 настай, Мексик

“Би үнэнийг мэдэхийг хүссэн хэнтэй ч гэсэн сайн мэдээнээс хуваалцаж чадна” (“Тэд намайг номлолд дуудна гэж би найддаг,” Children’s Songbook, 169-р хуудас).

Манай гэр бүл—манай ээж, аав, ах бид дөрөв ахыг минь номлолд үйлчилж болохын тулд удаан бэлтгэсэн билээ. Бид түүнийг номлогч байх тухай ярихад нь би түүнийг санахгүй бас ганцаараа байхад дуртай байх болно хэмээн тоглодог байв.

Тэр номлолынхоо өргөдлийг явуулах өдөр боллоо. Ах маань сургуулиа сайн төгсөхийг хичээж мөн бид түүний номлолд зориулж мөнгө хадгалахаар шаргуу ажилласан юм.

Нэг өдөр гадасны ерөнхийлөгч утасдаж, түүний дуудлага ирсэн гэлээ. Ах маань дуудлагаа оройн хоолны дараа задлахаар болов. Тэр Мехико хотын Зүүн номлолд дуудагджээ.

Бид түүнээс хойш удалгүй түүнийг онгоцны буудалд хүргэж өгөн, үдлээ. Гэртээ харих замд ээж уйлахгүй байж чадсангүй харин би уйлаагүй. Гэхдээ хоёрхон цагийн дараа би ахтайгаа байдаг байсан ерөөндөө ороод түүнийг удаан хугацаанд дахин харахгүй гэдгээ ойлголоо. Тэгээд би уйлахгүй байж чадсангүй, уйлсаар л байв. Ээж, аав хоёр намайг тэвэрч, тайтгаруулан, бид бүгдээрээ тэр үед агуу баяр баясгалан бас уйтгар гунигийг мэдэрч билээ.

Тэр өдрөөс хойш би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, ахыгаа үйлчлэх үеэр нь санаа тавихыг Түүнээс гуйдаг байв.

Ах бас намайг номлолд бэлтгэх ёстой гэж хэлдэг байлаа. Би санваар авахаар зохистой байн, семинарт явж, *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь номон дахь зорилгуудаа биелүүлэх ёстой байв.* Ах минь надад ажил хийж, мөнгө хадгалан, судруудаа уншиж, удирдагчдаа дуулгавартай дагадаг байхыг заасан юм.

Би ч бас номлолд үйлчлэхийг хүсдэг, тэгснээр бусад хүмүүс сайн мэдээний адислалуудыг хүлээн авч, үүнийг үнэн гэдгийг мэдэж чадна. ■



Арванхоёр
Төлөөлөгчийн
чуулгын
Ерөнхийлөгч
Бойд К.Пакэр

*Арванхоёр
Төлөөлөгчийн чуул-
гын гишүүд бол Есүс
Христийн онцгой
гэрчүүд юм.*

Гэр бүлтэйгээ хамт цагийг өнгөрүүлэх нь яагаад бидэнд маш чухал вэ?



Гэр бүлийн цаг нь ариун нандин мөч билээ.

Аз жаргалын төлөвлөгөө бол гэр бүлүүдэд зориулсан төлөвлөгөө юм.

Гэр бүл нь энэ амьдралд болоод үүрд мөнхөд орших үндсэн байгууллага юм.

Бид гишүүдээсээ гэр бүлдээ хайр, бишрэлээ харуулахыг хүсч байна.

Сүмийн гэр бүл, эцэг эх болон хүүхдүүд адислагдах болно хэмээн би залбирч байна.

Бойд К.Пакэр, "Бяцхан хүү тэднийг удирдах болно" Лианхона 2012 оны 5-р сар, 5-р хуудас.



Би Есүс Христ дахин ирнэ гэдгийг мэднэ

Есүс таны гарыг барьж, танд адислал өгч байна хэмээн төсөөлж чадах уу? Энэ бол Тэр амилсныхаа дараа Мормоны Номон дахь нифайчуудын хүүхдүүдэд хийсэн зүйл юм.

“Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэдний бяцхан хүүхдүүд авчрагдахыг зарлиг болгов.

“Иймээс тэд бяцхан хүүхдүүдээ авчирч мөн тэднийг түүний эргэн

тойронд газарт доош тавив . . .

“. . . Мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав” (3 Нифай 17:11–12, 21).

Есүс дахин ирж, бидэнтэй хамт дэлхий дээр амьдрах болно гэдгийг бид мэднэ. Тэр бидний Хаан ба Удирдагч байх болно. Энэ нь Түүнтэй уулзахад

бэлтгэгдсэн хүмүүст амар амгалан ба аз жаргалын үе байх болно.

Есүс нифайчуудын хүүхдүүдийг хайрласан шигээ чамд ч бас хайртай. Чи Түүнийг дахин ирэхэд бусадтай эелдэг, дуулгавартай байж, залбирч, зөвийг сонгосноор Түүнтэй уулзахад бэлтгэж чадна. Тэгвэл чи Түүнийг ирэхэд бэлэн байх болно! ■




ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Есүс бидний дунд дэлхий дээр байвал ямар байхыг гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Та нар 2 Нифай 21:6–9-р шүлгүүдийг уншиж болно. Тэгээд та нар тэр үед хүмүүс бие биедээ хэрхэн хандаж, амьтад ямар авир гарган, дэлхий хэр зэрэг аюулгүй байх тухай ярилцаж болно. Гэр бүлийн гишүүн бүрдээ тэд Есүс дахин ирэх үеийг хэрхэн төсөөлөн харж байгааг нь ээлжлэн яриул.



ДУУ БА СУДАР

- “Түүнийг эргэж ирэхэд” (*Children’s Songbook*, 82-83-р хуудсууд.)
- Матай 16:27






Учир нь Тэрээр эрт дээр үед “Хүүхдүүдийг
над уруу ирэхийг зөвшөөр” гэж хэлсэн.



ТҮҮНИЙГ ЭРГЭЖ ИРЭХЭД

Мирла Гринвүүд Тэйни




Өдрийн гэгээ шөнөний
турийд байх болов уу?




Нэг од бусдаасаа илүү хүртц гэрэлтэх
болов уу хэмээн би болно.

Түүнийг эргэж ирэхэд тэнгэр
элчүүд дуу дуулах болов уу?
гэж би боддог.



Тэр бяцхан хүүхдүүдийг Өөр рүүгээ
дуудна гэдэгт би итгэлтэй байна.



Дэлхий хүндралсан
цагаар хучигдсан
байх болов уу эсвэл
хаврын улирталтай
зогссон байх
болов уу?



Дууч шувууд үүрээ
орхи болов уу?

БИДНИЙ ХУУДАС

Би амьд бошиглогчид болон Есүс Христийн тухай хүүхдүүдэд зориулсан хуудсуудыг унших дуртай. Бусдын гэрчлэлийг унших нь миний гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг. *Лиахона* надад зөвийг сонгож, сүмийн жишгүүдийг дагахад тусалдаг. Бас энэ нь намайг Тэнгэрлэг Эцэгтэй илүү ойрхон байхад тусалдаг.

Камилла К., 11 настай, Баруун Малайз



Нэг өдөр манай Хүүхдийн хэсгийнхэн Бразилын Сан Пауло ариун сүмд айлчилсан юм. Тэндхийн цэцэрлэг нь миний урьд өмнө харж байсан цэцэрлэгүүдээс илүү үзэсгэлэнтэй байсан. Бид ариун сүмд хийсэн гэрээгээрээ дамжуулан, гэр бүлтэйгээ үүрд хамт байж чадна гэдгийг мэдсэн юм. Ариун сүмийн ерөнхийлөгчийг хүлээлгийн өрөөнд бидэнтэй уулзах үед бид тэнд байсан гайхамшигтай уран зургуудыг харсан. Би халуун дотно, жаргалтай мэдрэмжийг мэдэрсэн ба ээж үүнийг тайлбарлан, Ариун Сүнс надад миний сурсан зүйл үнэн гэдгийг гэрчилж байгаа нь тэр гэж хэлсэн. Би ариун сүм бол Их Эзэний өргөө гэдэг гэрчлэлтэй болсон.

Ренато Б., 8 настай, Бразил



Ренато гэр бүлийнхээ хамт баптисм дээрээ



7 настай Маурико Х. Мексикт амьдардаг. Тэр баптисм хүртэж, дуулгавартай байснаараа нэг өдөр ариун сүмд орно гэсэн хүсэлтэй байдаг. Тэрээр дүү Даниэлдээ сайн үлгэр жишээ үзүүлэхийг хичээдэг.



Хонг Конгод амьдардаг 3 настай Даниэл гэрийнхээ хамгийн бага нь. Тэр сайхан сэтгэлтэй, үргэлж инээмсэглэдэг. Бас

бусдад үйлчлэх дуртай. Тэр хүү сүм дээр эсвэл гэртээ үргэлж сайн дураараа залбирахыг санал болгодог. Аавтайгаа хамт ариун ёслолын цуглаан эхлэхээс өмнө үүдэнд зогсож, тойргийнхоо гишүүдтэй мэндлэх дуртай. Бас тэр сүмийн дараа дууны ном цуглуулж, цуглааны байрыг цэвэрлэх дуртай. Нэг өдөр тэр сүм рүү явж байхдаа нэгэн бяцхан хөвгүүнийг сүмд ирэхийг урин, ээждээ сайн үлгэр жишээ үзүүлжээ.



Айлин С., 8 настай, Гватемала

Францын Гвинейн Казин салбарын хүүхдүүд ариун ёслолын цуглаан дээрээ Хүүхдийн хэсгээ танилцуулах дуртай. Тэд хэлэх үгээ баяр хөөртэй уншиж, маш сайхан дуулдаг. Тэд Хүүхдийн хэсэгтээ дуртай. Тэдний дуулах дуртай дуунуудын нэг нь "Би Бурханы хүүхэд" юм (Hymns, no. 301).



Тима Б., 6 настай, Украйн



“Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирнэ” (Матай 16:27).

Кэти юм хадгалдаг хайрцгаа ухаж төнхөн, үрчийсэн боодлын цаасан дунд нэг зүйлийг няхуур хайж байлаа. Гэвч тэр хайж байгаа зүйлээ олж чадсангүй.

Тэрээр бүгдийг нь хайрцаг руу буцааж хийгээд ээжийгээ хайлаа.

Кэти төгөлдөр хуурын араар, буйдангийн доор, бүр Томасын орон дотор хүртэл хайв. Алга болчихож дээ. Тэр ээждээ хэлэх хэрэгтэй байлаа.

“Ээж ээ, бяцхан Есүс алга болчихож”

гэж Кэти хэлээд ээжийгээ зочны өрөөн дэх Христийн төрөлтийн

сэдэвтэй баримал руу дагуулж очив. Тэнд Иосеф, Мариа хоёр бас хоньчид байлаа. Мэргэн хүмүүс, бүр тэмээ, илжиг хоёр ч тэнд байв. Эдгээр баримлууд бүгдээрээ хоосон тэвшний эргэн тойронд байлаа.

“Тийм ээ, алга болсон бололтой” гэж ээж хэллээ.

Тэр “Би Түүнийг хайгаад хайгаад хаанаас ч олсонгүй” гэв. Бяцхан Есүсгүйгээр энэ бүгд хэрэггүй байв.

Ээж номын тавиур руу очоод дээшээ гараа сунгаж, тавиур дээрээс нэг юм авангаа “Тэр алга болоогүй байна” гэлээ.

Кэти гүнзгий амьсгаа аваад “Өө, Тэр байна шүү дээ! Би түүнийг тэвшинд нь тавилаа” гэв.

Кэти баримлыг авах гэтэл ээж нь буцаагаад тавиур дээр тавьчихав. “Энэ жил бид бяцхан Есүсийг Христийн мэндэлсний баярын өглөө тэвшинд нь тавих болно. Энэ бол аавын чинь Францад сурсан заншил” гэж ээж хэллээ.

Намайг “Яагаад? Бүгд гунигтай байна шүү дээ” гэхэд ээж маань

“Би тэдний гунигтай эсэхийг нь мэдэхгүй байна. Гэхдээ надад бол “Тэд хүлээж байгаа юм шиг л харагдаж байна” гэлээ.

Кэти баримлуудыг ажиглав. Тэр бяцхан Есүсийн тэвш хоосон байгааг харлаа. Зарим баримлууд хоосон зай руу тэмүүлж байв.

Есүсийг хүлээсэн нь





Кэти “Тийм юм шиг байна” гэлээ.

“Томасыг төрөхөөс өмнө чи дүүтэй болно гээд ямар их баярлаж байснаа санаж байна уу?” гэж ээж асуув.

Кэти хөнжил дээр тоглож байсан бяцхан дүү рүүгээ инээмсэглээд “Тийм ээ, яг л үүрд хүлээх юм шиг санагдаж байсан шүү” гэлээ.

Ээж “Бошиглогчид Түүнийг ирж, биднийг Тэнгэрлэг Эцэгтэй амьдрахаар эргэж очиход маань туслахын тулд ирэхийг нь хэдэн мянган жил хүлээснийг чи мэдэх үү?” гэж асуув.

Кэти Хүүхдийн хэсэгтээ нэгэн бошиглогч Аврагчийн төрөлтийн тухай бичиж байгаа зургийг харснаа санаад “Тийм байх аа” гэлээ.

“Исаиа шиг бошиглогчид Аврагч ирээд юу хийх тухай боддог бас бичдэг байсан. Тэд Түүний төрөхийг насан туршдаа хүлээсэн юм. Христийн төрөлтийн ийм баримлыг гэртээ тавьсан шалтгаан нь олон хүн Аврагчийн ирэхийг өнө удаан хүлээснийг сануулахын тулд юм” гэж ээж хэллээ.

“Би бүх амьдралынхаа турш хүлээхээс залхах байх даа” хэмээн Кэти Есүсийг хүлээж буй хоньчдыг харах зуураа хэлэв.

“Гэхдээ бид Түүнийг хүлээх нэг шалтгаан бас байгаа шүү” хэмээн ээж нь хэллээ.

“Юу билээ?”

“Бид Хоёр дахь ирэлтийн тухай гэр бүлийн үдшээрээ ярилцаж байсныг санаж байна уу?”

Тэр хэсэг бодсоноо “Тэр чинь Есүс дахин ирэх үе гэсэн үг үү?” гэхэд

Ээж нь “Тийм ээ” гэв.

“Энэ чинь хэзээ болох юм бэ?”

“Бид мэдэхгүй. Харин бид яг энэ баримал дахь хоньчид болон эртний бошиглогчдын адилаар Есүсийг хүлээж байна. Энэ чинь бид ч бас Есүсийг хүлээж байгааг санахын тулд бяцхан Есүсийг Христийн мэндэлсний баяр хүртэл тэвшинд нь тавихгүй гэсэн шалтгаан байхгүй юу.”

“Тэр дахиад тэвшинд ирэх үү?” гэж Кэти асуулаа.

“Үгүй дээ, хонгор минь, Тэр тэгэхгүй. Есүс дараагийн удаа ирэхдээ амилсан байх болно. Гэхдээ энэ баримал дахь хоосон тэвш чамайг Христийн мэндэлсний баярын өглөөг хүлээж байгаа шиг мөн хүмүүс бас Есүсийг дэлхийд ирэхийг хүлээж байсан шиг бид одоо Түүний эргэж ирэхийг хүлээж байгааг сануулж байгаа юм. Бид бяцхан Есүсийг алдаагүй. Энэ чинь манай гэр бүл Түүнийг санаж байгаа гэсэн үг.”

“Бид тэгвэл хүлээх хэрэгтэй болж дээ” гээд Кэти инээмсэглэв.

Ээж нь “Тийм шүү, хүлээх зуураа хоёулаа чихэртэй жигнэмэг хийх үү?” гэлээ. ■



“Бид Түүнийг Хаадын Хаан, Эздийн Эзэн болж хаанчлахаар дэлхийд, энэ цаг үед, хүч чадал, сүр жавхлан ба алдар

суунд эргэж ирнэ гэдгийг тунхаглаж байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Standing Together for the Cause of Christ,” Лиахона, 2012 оны 8-р сар, 28-р хуудас.

Сүмийн түүхэн дэх нэг чухал газрыг бидэнтэй хамт судална уу!

Элис Х., 9 настай, Кайл Х., 6 настай. Тэд Ютагийн Солт Лэйк хот дахь анхдагчдын сэргээн баригдсан тосгоны цастай гудамжаар зугаалж байна. Тэд 1800 оны дунд үед очсон юм шиг харагдаж байна. Энэ нь анхдагч нарын Солт Лэйкийн хөндийд суурьшиж байсан үе юм. “Өвийн газар энэ байна”-аар зугаалангаа анхдагч хүүхэд байх ямар байсныг мэдэхийн тулд Элис, Кайл хоёртой нэгдээрэй. ■

Тэр газар энэ байна!

Энни Бийр



*Хотхоны үсчин үс
засаад зассан үснээс
илүү гарсныг нь
хүүхэлдэйн үс болгон
ашиглуулахаар тоглоом
хийгчид илгээнэ.*






Нэгэн гэр бүлийн 12 гишүүн энэхүү анхдагчийн жижигхэн гэрт амьдардаг байжээ. Хүүхдүүд нь унтлагын дээд өрөөндөө орохын тулд гадаа гарч, шатаар өгсдөг байлаа.



Анхдагчдын хүүхдүүд гэр орныхоо ажлыг хийснийхээ дараа тоглоомоороо тоглодог байв. Кайлд таалагдсан нь хоёр олсоор татдаг баавгай байлаа. Энэ нь анхдагч хүүхдүүдэд үнээ хэрхэн саахыг сурахад тусалдаг байв!

Анхдагч хүүхдүүдийн явдаг байсан сургууль нь ихэвчлэн нэг өрөөтэй байшин байлаа. Хэдийгээр бүх насны хүүхдүүд өөр өөр зүйл сурдаг байсан ч тэд нэг өрөөнд хичээллэдэг байв.



Эхний анхдагчид баруун зүг дэх аяллаа 1847 онд дуусгажээ. Бригам Янг анх Солт Лэйкийн хөндийг хараад "Энэ бол зөв газар байна" гэж хэлсэн аж. Энэхүү дурсгалын хөшөөг тэдгээр зоригт анхдагчдыг хүндэтгэн, Бригам Янгийн ач хүүгийн бүтээсэн загвараар босгожээ.

Янзтай!
Анхдагч хүүхдүүд бас чихэрт дуртай байсан!



Есүс мэндэллээ

Чарлот Мэй Шэппард



Мариа, Иосеф хоёр
Бетлехем рүү аялжээ.
Энэ нь маш хол зам
байлаа. Мариа удахгүй
төрөх гэж байлаа.

Бүх дэн буудал
дүүрсэн байв. Мариа,
Иосеф хоёр малын
хашаанд байрлажээ.
Тэднийг тэнд байхад
Есүс мэндэллээ.



Тэдний ойролцоо хоньчид хонио хариулж байв. Тэнгэр элч ирээд тэдэнд Бетлехемд очиж, шинэ төрсөн хүүг хар гэжээ.


Хоньчид Мариа, Иосеф хоёрын байсан малын хашааг олжээ.

Тэнд малын тэвшинд даавуунд өлгийдсөн бяцхан Есүс байлаа.

Тэрээр дэлхийн Аврагч болох билээ.



Христийн мэндэлсний баяраар манай гэр бүл болон найзууд бидэнд бэлэг өгдөг. Гэхдээ энэ бүгдээс хамгийн агуу бэлэг нь Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн бэлэг юм. Тэр Өөрийн Хүү, Есүс Христийг дэлхийд төрөхөөр илгээсэн юм. ■



Баярын шалтгаан

Вал Чадвик Багли

Зурагт нуусан эдгээр зүйлсийг олж дугуйл.



ГЭРТЭЭ ХАРИХ ЗАМ

Хээдэр Витл Ригли



Ажлаас гэр хүртэлх автобусны аялал маань урьдын адил эхэллээ. Би толгойгоо цонхонд наан; автобусны явах, зогсох нь намайг бүүвэйлэхэд таван минутын дотор унтчихсан байлаа. Би бүрэн цагаар хичээллэж, ажил хийхийн зэрэгцээ шинэ хэн гэрлэлтээс ирсэн үүрэг хариуцлагуудаа дасах гэсэн хэвээрээ байсан юм. Зарим өдрүүдэд би ажил, гэр хоёрын хооронд автобусаар явах үедээ өөрийн эрхгүй унтчихдаг байв.

Би нойрмоглон, унтан, сэрэн байх үедээ чиглэл зарлах дуу хоолой сонслоо. Удалгүй би 80 км урт замын турш автобусны шинэ жолоочид эргэлт, гудамж болон автобусны буудал бүрд мэдэгдэж, чиглэл өгөх ёстой байдгийг мэдсэн юм.

Гэртээ хүрэхэд цаг хагасаас илүү удах нь гэдгийг мэдээд би шууд л ундууцлаа. Тэр жолоочийн чадварын тухай барагтайхан бодол толгойд минь орж ирэв. Нэгэн дуу хоолой үргэлжлүүлэн зүг чиг зааж, нойр тасалдуулна.

Гэсэн ч удалгүй тэр дуу намдахыг анзаарлаа. Хартал, надаас хоёр эгнээний өмнө суусан нэгэн эмэгтэй суудал дээрээсээ жолоочид намуухнаар зам зааж өгч байв. Тэрээр жолоочид зөөлөн, аятайхнаар зүг чиг зааж өгөөд автобуснаас буухаасаа өмнө дараагийн хэдэн буудлын

Бид эргэх замаа мэдэхгүй үед Есүс Христ бидэнд уг замыг харуулдаг.

тухай түүнд ярихыг би ажиглалаа. Гэртээ ирснээс нэлээд хойно би тэр эмэгтэйн элэгсэг чиглүүлэлтэй өөрийнхөө шүүмжлэх хандлагыг харьцуулж бодоод дотор бачимдлаа.

Тэгээд би өөрийгөө тэр автобусны жолооч шиг байснаа ухаарсан юм. Тэр жолооч шинэ замаа мэдэхгүй байсантай адил би ч бас амьдралынхаа замыг мэдэхгүй байлаа. Бид хоёр хоёулаа үл мэдэх зам дээр байсан юм. Өмнө нь тэр замаар явж байсан бөгөөд жолоочид урдах замынх нь тухай тэвчээртэйгээр хэлж өгөх хэн нэгэн байсанд тэр баяртай байсан гэдэгт би итгэлтэй байна.

Христ үүнтэй адил биднийг чиглүүлдэг. Бид аль зүг рүү эргэхээ мэдэхгүй үед Түүний үлгэр жишээ бидэнд замыг харуулдаг билээ. Бидэнд асуулт байвал Тэр элэгсгээр хариулдаг. Тэр бусдын хэрэгцээг биелүүлэхийн тулд хэдэн удаа хол зам туулж, аялан, ядрах бол?

Бид тэр өдрөөс хойш автобусны хэд хэдэн шинэ жолоочтой таарсан юм. Хааяа тэнд чиглүүлэл хэрэг болдог байсан бөгөөд тэрхүү элэгсэг эмэгтэй болон Аврагчийн надад үзүүлсэн үлгэр жишээнд би талархаж, тэнд удирдамж чиглэл өгөхөд бэлэн байдаг байлаа. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЭРТ БАЙРЭТТ

Жосеф Фийлдинг Смит

Жосеф Фийлдинг Смит залуудаа шаргуу ажиллаж, хөдөлмөрлөхийг сурчээ. Ээж нь төрөх гэж байгаа эмэгтэйчүүдэд тусалдаг байсан бөгөөд Жосеф ээжийнхээ **морин тэргийг** жолоодон, хүргэж өгдөг байв. Жосеф өсч, том болохдоо судруудыг хайрлах хайрыг өөртөө хөгжүүлжээ. Тэрээр сүмийн сургаалын тухай олон **ном** бичсэн юм. Тэр сүмийн ерөнхийлөгч байхдаа **Ютагийн Прово ариун сүмийг** онцгойлон адислах залбирлын үгийг бичжээ.



Бетлехемийн ойролцоо хоньчид шинэ төрсөн хургануудаа арчилж байхад Тэнгэр элчүүд тэдэнд Аврагчийн төрөлтийг зарласан юм. “Төллөх цагаар ирсэн эрэгтэй хүүхэд ‘Бурханы Хурга’ байсан юм” хэмээн Далын ахлагч Брүс Д.Портэр бичжээ. “Энэ нь гүн утга учир агуулсан нэр байсан юм, учир нь Тэрээр хургануудтай хамт мэндэлж, нэгэн өдөр ‘алагдахаар хөтлөгдөх хурга шиг’ байх болно ... Хамгийн Агуу Нэгэн атлаа Өөрийгөө хамгийн доогуурт тавьсан Тэнгэрлэг Хоньчин Тэрбээр Хурга болжээ.” “Ирцгээ, Түүнийг шүтэн биширцгээе,” 16-р хуудсыг үзнэ үү.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

МОНГОЛАН



10792 Дас 13